



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮНИЙ АСУУЛГА, АСУУЛТ,
ТҮҮНИЙ ХАРИУГ ХЭЛЭЛЦСЭН
ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮНИЙ АСУУЛГА, АСУУЛТ,
ТҮҮНИЙ ХАРИУГ ХЭЛЭЛЦСЭН
ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**

№64

УЛААНБААТАР
2025



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА, АСУУЛТ, ТҮҮНИЙ ХАРИУГ
ХЭЛЭЛЦСЭН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**

**(Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулган)
/2025.03.17 - 2025.07.09/**

№64

Улаанбаатар хот
2025 он

1	Улсын Их Хурлын гишүүний асуулга, асуулт , түүний хариуг хэлэлцэх журам	3
2	Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы завсарлагаа, 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд Улсын Их Хурлын гишүүдээс тавьсан асуулга, түүний хариуг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцсэн талаарх статистик мэдээ	8
3	Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы завсарлагаа, 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд Улсын Их Хурлын гишүүдээс тавьсан асуулт, түүний хариуг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцсэн талаарх статистик мэдээ	10
4	Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, Ж.Чинбүрэн нараас 2025 оны 3 дугаар сарын 28-ны өдөр Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэд хандсан “Эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой тулгамдаж буй асуудлын талаар асуулга хүргүүлэх тухай” АСУУЛГА-14	12
5	Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, Ж.Чинбүрэн нараас Монгол Улсын Ерөнхий сайдад хандсан “Эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой тулгамдаж буй асуудлын талаар асуулга хүргүүлэх тухай” АСУУЛГА-14-ийн хариуг Нийгмийн бодлогын байнгын хорооны 2025 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн хуралдаанаар хэлэлцсэн мэдээлэл	14
6	Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдалаас 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр Боловсролын сайд П.Наранбаярт хандсан “Боловсролын зээлийн сангийн үйл ажиллагааны хэрэгжилтийн талаар” АСУУЛТ-01	37
7	Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдалаас Боловсролын сайдад хандсан “Боловсролын зээлийн сангийн үйл ажиллагааны хэрэгжилтийн талаар” АСУУЛТ-01-ийн хариуг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны 2025 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн хуралдаанаар хэлэлцсэн мэдээлэл	39
8	Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяагаас 2025 оны 4 дүгээр сарын 03-ны өдөр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгаланд хандсан “Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний талаар” АСУУЛТ-15	57
9	Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяагаас Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгаланд хандсан “Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний талаар” АСУУЛТ-15-ын хариуг Нийгмийн бодлогын байнгын хорооны 2025 оны 5 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаар хэлэлцсэн мэдээлэл	58

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ АСУУЛГА, АСУУЛТ ТҮҮНИЙ ХАРИУГ ХЭЛЭЛЦЭХ ЖУРАМ

Улсын Их Хурлын гишүүнээс тавьсан асуулга, түүний хариуг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцэх журмыг Монгол Улсын Их Хурлын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль болон Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиар тус тус зохицуулсан.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/

2024 оны 05 сарын 16 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

8 дугаар зүйл. Гишүүний бүрэн эрх

8.1. Гишүүн дараах бүрэн эрхтэй:

8.1.13. Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг бусад байгууллагын даргад асуулга, асуулт тавьж, хариуг хуульд заасан хугацаанд авах;

37 дугаар зүйл. Улсын Их Хурал хянан шалгах бүрэн эрхээ хэрэгжүүлэх

37.1. Улсын Их Хурлын хянан шалгах ажил нь Засгийн газрын хуулийн биелэлтийг зохион байгуулж хангах үйл ажиллагаа болон Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын хууль биелүүлэх үйл ажиллагаанд хяналт тавихад чиглэх бөгөөд Улсын Их Хурал хянан шалгах бүрэн эрхээ дараах арга хэрэгслээр хэрэгжүүлнэ:

37.1.1. асуулт тавих;

37.1.2. асуулга тавих;

37.1.3. хууль тогтоомжийн биелэлтийн үр дагаварт үнэлгээ хийх;

37.1.4. мэдээлэл сонсох, тайлан, илтгэл хэлэлцэх;

37.1.5. төсвийн хяналт;

37.1.6. Улсын Их Хурлын хяналтын сонгол хийх;

37.1.7. Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хянан шалгах түр хороо байгуулж, тусгай шалгалт явуулах.

37.2. Улсын Их Хурлаас хийх хяналт шалгалтыг Улсын Их Хурлын нэгдсэн удирдамжаар хэрэгжүүлэхээс бусдаар төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын хяналт шалгалттай давхардуулахгүй хэрэгжүүлнэ.

37.3. Улсын Их Хурал хянан шалгах бүрэн эрхээ хэрэгжүүлэх журмыг хуулиар тогтооно.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТУХАЙ

/Шинэчилсэн найруулга/

2024 оны 05 сарын 16 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

ХОЁРДУГААР БҮЛЭГ МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АРГА ХЭРЭГСЭЛ, ТҮҮНИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

6 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын арга хэрэгсэл

6.1. Улсын Их Хурал хянан шалгах бүрэн эрхээ дараах арга хэрэгслээр хэрэгжүүлнэ:

- 6.1.1. асуулт тавих;
- 6.1.2. асуулга тавих;
- 6.1.3. хууль тогтоомжийн биелэлтийн үр дагаварт үнэлгээ хийх;
- 6.1.4. мэдээлэл сонсох, тайлан, илтгэл хэлэлцэх;
- 6.1.5. төсвийн хяналт;
- 6.1.6. хяналтын сонсгол хийх;
- 6.1.7. хянан шалгах түр хороо байгуулж, тусгай шалгалт явуулах.

ГУРАВДУГААР БҮЛЭГ МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

11 дүгээр зүйл. Асуулт тавих

11.1. Гишүүн Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнд тодорхой бодлогын асуудал, түүний санхүүжилт, төрийн санхүү, төрийн нийтийн өмч, хүний эрх, эрх чөлөө хангагдаж байгаа эсэх асуудал болон Улсын Их Хурал бүрэлдэхүүн, удирдлагыг нь сонгож, томилдог байгууллагын хуулиар тогтоосон чиг үүргээ хэрэгжүүлж байгаатай холбоотой мэдээлэл авахаар тухайн байгууллагын даргад бичгээр хандсаныг "асуулт" гэнэ. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8.1.16, 8.1.17-д заасан албан бичгээр авах мэдээлэл нь асуултад хамаарахгүй.

11.2. Асуултыг хүргүүлснээс хойш холбогдох албан тушаалтан 14 хоногийн дотор хариуг гишүүнд бичгээр хүргүүлнэ. Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр асуултын хариуг хугацаа хожимдуулж ирүүлсэн, эсхүл ирүүлээгүй бол асуулт тавьсан гишүүн холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцуулах саналаа энэ хуулийн 57.10-т заасан Байнгын хороонд хүргүүлж болно.

11.3.Гишүүн асуултын хариуд ирүүлсэн холбогдох байгууллага, албан тушаалтны мэдээлэл шаардлага хангаагүй гэж үзвэл нэмэлт мэдээлэл, тооцоо, судалгааг авахаар хугацаатай албан бичиг явуулна. Холбогдох албан тушаалтан албан бичигт заасан хугацаанд нэмэлт мэдээллийг ирүүлэх үүрэгтэй.

11.4.Гишүүний асуултын хариуг холбогдох Байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 114 дүгээр зүйлд заасны дагуу хэлэлцэнэ.

11.5.Асуулт тавьсан гишүүн тодорхой арга хэмжээ авах хүсэлтийг шийдвэрийн төслийн хамт холбогдох Байнгын хорооны даргад уламжилж болно.

11.6.Байнгын хороо гишүүнээс гаргасан хүсэлт, шийдвэрийн төслийг хуралдаанаараа хэлэлцэж санал, дүгнэлтээ нэгдсэн хуралдаанд танилцуулж болно.

12 дугаар зүйл. Асуулга тавих

12.1.Хууль тогтоомжийн биелэлтийг хэрхэн зохион байгуулж, ямар үр дүнд хүрсэн талаар тодруулах, хуульд заасан үйл ажиллагаа явуулахыг шаардаж гишүүнээс Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын Их Хурлаас бүрэлдэхүүн, удирдлагыг нь сонгож, томилдог байгууллагын даргад бичгээр хандсаныг "асуулга" гэнэ.

12.2.Асуулгыг хүргүүлснээс хойш холбогдох албан тушаалтан 30 хоногийн дотор хариуг гишүүнд бичгээр хүргүүлнэ. Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр асуулгын хариуг хугацаа хожимдуулж ирүүлсэн, эсхүл ирүүлээгүй бол асуулга тавьсан гишүүн холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцуулах саналаа энэ хуулийн 57.10-т заасан Байнгын хороонд хүргүүлж болно.

12.3.Гишүүн асуулгын хариуд ирүүлсэн холбогдох байгууллага, албан тушаалтны мэдээлэл шаардлага хангаагүй гэж үзвэл нэмэлт мэдээлэл, тооцоо, судалгаа авахаар хугацаатай албан бичгийг явуулна. Холбогдох албан тушаалтан албан бичигт заасан хугацаанд нэмэлт мэдээллийг ирүүлэх үүрэгтэй.

12.4.Гишүүний асуулгын хариуг холбогдох Байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 113 дугаар зүйлд заасны дагуу хэлэлцэх бөгөөд хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасан журмын дагуу нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж болно.

12.5.Нэгдсэн хуралдаанаар энэ хуулийн 12.4-т заасны дагуу гишүүний асуулгын хариуг хэлэлцээд Улсын Их Хурлаас тодорхой шийдвэр гаргахыг дэмжсэн тохиолдолд холбогдох Байнгын хороонд энэ талаар чиглэл өгч болно.

12.6.Холбогдох Байнгын хороо нэгдсэн хуралдаанаас өгсөн чиглэлийн дагуу хууль тогтоомжийн төсөл болон холбогдох санал, дүгнэлтээ нэгдсэн хуралдаанд танилцуулна.

12.7.Гишүүний асуулт, асуулга, түүний хариуг мэдээллийн нэгдсэн санд тухай бүр байршуулна.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ДЭГИЙН ТУХАЙ

/Шинэчилсэн найруулга/

2024 оны 05 сарын 16 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

АРВАН ГУРАВДУГААР БҮЛЭГ ЕРӨНХИЙ САЙДЫН МЭДЭЭЛЭЛ, ГИШҮҮНИЙ АСУУЛГА, АСУУЛТЫН ХАРИУГ СОНСОХ

113 дугаар зүйл.Гишүүний асуулгын хариуг хэлэлцэх

113.1.Гишүүн Байнгын хорооны хуралдаанаар асуулгын хариуг хэлэлцүүлэхээр бичгээр саналаа ирүүлснээс хойш 10 хоногийн дотор Байнгын хороо хуралдаанаар хэлэлцүүлэх бөгөөд дараах журмыг баримтална:

113.1.1.Байнгын хорооны хуралдаанд асуулгын хариуг холбогдох албан тушаалтан 3 минутаас илүүгүй хугацаанд танилцуулах бөгөөд гишүүд 3 минутаас илүүгүй хугацаанд асуулт асуух;

113.1.2.холбогдох албан тушаалтан асуултад хариулсны дараа асуулга тавьсан гишүүн 5 минутаас илүүгүй хугацаанд үг хэлэх, асуулгатай холбоотой өөр асуулт асуух.

113.2.Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар асуулгын хариуг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж болно.

113.3.Гишүүний асуулгын хариуг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхэд дараах журмыг баримтална:

113.3.1.Улсын Их Хурлын дарга нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх тов, дарааллыг Зөвлөлийн саналыг харгалзан тогтоох;

113.3.2.асуулгын хариуг нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхэд тухайн асуудлыг хариуцан хэлэлцүүлэх Засгийн газрын гишүүнийг Ерөнхий сайд Улсын Их Хурлын даргад урьдчилан мэдэгдэх;

113.3.3.нэгдсэн хуралдаанд асуулгын хариуг холбогдох албан тушаалтан 5 минутаас илүүгүй хугацаанд танилцуулах ба гишүүд асуулгын хариутай холбогдуулж асуулт асуух хугацаа 3 минутаас илүүгүй байх бөгөөд хариулт, тайлбар хангалтгүй гэж тухайн гишүүн үзвэл 1 минутаас илүүгүй хугацаагаар нэмэлт асуулт асууж, тайлбар авах, түүнд хариулах хугацаа 1 минутаас илүүгүй байх;

113.3.4.асуулгад хариулт өгсний дараа асуулга тавьсан гишүүн нэг удаа 5 минутаас илүүгүй хугацаанд үг хэлэх.

113.4.Асуулгын хариуг ээлжит чуулганы үеэр сар бүрийн 2, 4 дэх долоо хоногийн Баасан гарагийн үдээс хойших нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх бөгөөд шаардлагатай бол Баасан гарагийн үдээс өмнөх хуралдаанд хэлэлцэж болно.

113.5.Гишүүний тавьсан асуулгын хариуг нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх үед ижил сэдвийн хүрээнд тавигдсан бусад асуулгын хариуг нэгтгэн хэлэлцүүлж болно.

113.6.Нэгдсэн хуралдаан асуулгын хариуг хэлэлцээд Улсын Их Хурлаас тодорхой шийдвэр гаргах шаардлагатай гэж үзвэл холбогдох Байнгын хороонд энэ талаар чиглэл өгнө.

113.7.Холбогдох Байнгын хороо энэ хуулийн 113.6-д зааснаар нэгдсэн хуралдаанаас өгсөн чиглэлийн дагуу хууль, тогтоолын төсөл боловсруулж, санал, дүгнэлтээ нэгдсэн хуралдаанд оруулна.

114 дүгээр зүйл.Гишүүний асуултын хариуг хэлэлцэх

114.1.Гишүүн Байнгын хорооны хуралдаанаар асуултын хариуг хэлэлцүүлэхээр бичгээр саналаа ирүүлснээс хойш 10 хоногийн дотор Байнгын хороо хуралдаанаар хэлэлцүүлэх бөгөөд дараах журмыг баримтална:

114.1.1.Байнгын хорооны хуралдаанд асуултын хариуг холбогдох албан тушаалтан 5 минутаас илүүгүй хугацаанд танилцуулах бөгөөд гишүүд 3 минутаас илүүгүй хугацаанд асуулт асуух, хариулт, тайлбар хангалтгүй гэж тухайн гишүүн үзвэл 1 минутаас илүүгүй хугацаагаар нэмэлт асуулт асууж, тайлбар авах, хариулах хугацаа 1 минутаас илүүгүй байх;

114.1.2.холбогдох албан тушаалтан асуултад хариулсны дараа асуулт тавьсан гишүүн 5 минутаас илүүгүй хугацаанд үг хэлэх, тавьсан асуулттайгаа холбоотой өөр асуулт асуух.

114.2.Гишүүний асуултын хариуг хэлэлцэх ажиллагааг олон нийтэд мэдээлнэ.

---o0o---

УЛСЫН ИХ ХУРЛЫН 2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ ЗАВСАРЛАГАА, 2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ ХУГАЦААНД УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮДЭЭС ТАВЬСАН АСУУЛГА, ТҮҮНИЙ ХАРИУГ БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦСЭН ТАЛААРХ СТАТИСТИК МЭДЭЭ

№	Улсын Их Хурлын гишүүний нэр	Хандсан албан тушаалтан	Асуулгын агуулга	Хамрагдсан асуудлын тоо	Асуулга тавьсан огноо, дугаар	Хариу ирүүлсэн огноо	Гишүүнээс санал ирүүлсэн огноо	Хэлэлцсэн огноо	Асуулт, үг хэлсэн гишүүн, асуулт тоогоор/ Гишүүн	
									Асуулт, үг	Гишүүн
УЛСЫН ИХ ХУРЛЫН 2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ ЗАВСАРЛАГААНЫ ХУГАЦААНД (2025.01.24 - 03.14)										
1	Н.Наранбаатар	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа	Тушаалын хэрэгжилтийн талаар асуулга тавих тухай	1	2025.01.23 №04	2025.02.18 11/855	-	-	-	-
2	Ө.Шижир	Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ	Төр, нийтийн өмчийн асуудлаар	6	2025.01.31 №05	2025.03.21 ХЭГ/782	-	-	-	-
3	Ө.Шижир	Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ	Хуулийн хэрэгжилтийн талаар	5	2025.01.31 №06	2025.03.21 ХЭГ/781	-	-	-	-
4	О.Номинчимэг	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү	Цахим орчин дахь аюулгүй байдлыг хангахад чиглэсэн бодлого, үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнгийн талаар	3	2025.02.03 №07	2025.02.07 01/313	-	-	-	-
5	О.Номинчимэг	Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл	Цахим орчинд үйлдэгдэж буй гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх бодлого, үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнгийн талаар	4	2025.02.03 №08	2025.02.27 1/1224	-	-	-	-
6	Г.Лувсанжамц	Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ	Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилтийн талаар	6	2025.02.10 №09	2025.03.11 ХЭГ/654	-	-	-	-

УЛСЫН ИХ ХУРЛЫН 2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ ХУГАЦААНД (2025.03.17 - 09)										
7	Б.Хэрлэн	Боловсролын сайд П.Наранбаяр	Боловсролын бодлого, үйл ажиллагаанд тэгш хүртээмжтэй, ялгаварлан гадуурхахгүй байх зарчмыг хэрэгжүүлэх талаар асуулга хүргүүлэх тухай	2	2025.03.21 №12	2025.10.17 1/4828	-	-	-	-
8	Г.Тэмүүлэн Ж.Чинбүрэн	Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ	Эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой тулгамдаж буй асуудлын талаар асуулга хүргүүлэх тухай	4	2025.03.28 №14	2025.04.30 ХЭГ/1174	2025.05.05 УИХ- 03/5648	НББХ 2025.05.13	9	20
9	О.Амгаланбаатар	Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ	Төрийн байгууллагын удирдах албан тушаалтнуудын талаар	3	2025.04.25 №18	2025.05.30 ХЭГ/1570	-	-	-	-
10	Ж.Батжаргал	Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ	Хуулийн хэрэгжилтийн талаар /Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай/	7	2025.04.29 №19	2025.05.30 ХЭГ/1571	-	-	-	-
11	Д.Үүрийнтуяа	Боловсролын сайд П.Наранбаяр	Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийн талаар	2	2025.05.06 №20	2025.06.06 1/2564	-	-	-	-
12	М.Бадамсүрэн	Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан	Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн авто замын талаар	6	2025.06.18 №22	2025.11.13 01/5271	-	-	-	-
13	Ч.Ундрам	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр	Органик бүтээгдэхүүний тухай хуулийн хэрэгжилтийн талаар	10	2025.06.20 №23	2025.06.29 №1979	-	-	-	-
14	Б.Бат-Эрдэнэ	Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар	Боловсролын хуулийн зарим заалтын хэрэгжилтийн талаар	14	2025.07.07 №27	2025.08.19 ХЭГ/2207	-	-	-	-

---000---

УЛСЫН ИХ ХУРЛЫН 2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ ЗАВСАРЛАГАА, 2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ ХУГАЦААНД УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮДЭЭС ТАВЬСАН АСУУЛТ, ТҮҮНИЙ ХАРИУГ БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦСЭН ТАЛААРХ СТАТИСТИК МЭДЭЭ

№	Улсын Их Хурлын гишүүний нэр	Хандсан албан тушаалтан	Асуултын агуулга	Хамрагдсан асуудлын тоо	Асуулт тавьсан огноо, дугаар	Хариу ирүүлсэн огноо	Гишүүнээс санал ирүүлсэн огноо	Хэлэлцсэн огноо	Асуулт, үг хэлсэн гишүүн, асуулт /тоогоор/	
									Гишүүн	Асуулт, үг
УЛСЫН ИХ ХУРЛЫН 2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ ЗАВСАРЛАГААНЫ ХУГАЦААНД (2025.01.25 - 03.14)										
1	О.Батнайрамдал	Боловсролын сайд П.Наранбаяр	Боловсролын зэргийн сангийн үйл ажиллагааны хэрэгжилтийн талаар	8	2025.01.07 №01	2025.01.20 1/248	-	БСШУСБХ 2025.03.26	8	22
2	Г.Лувсанжамц	Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн	Орон сууцны ипотекийн зэргийн зохицуулалтын талаар	3	2025.02.10 №10	2025.03.14 А-1/212	-	-	-	-
3	Ж.Галбадрах	Хот байгуулалт, барилга, орон сууцнуудын сайд Ж.Батсуурь	Хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар	3	2025.03.11 №11	2025.04.07 01/1178	-	-	-	-
УЛСЫН ИХ ХУРЛЫН 2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ ХУГАЦААНД (2025.03.17 - 07.09)										
4	П.Сайнзориг Б.Энхбаяр З.Мэндсайхан	Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ	Асуулт тавих тухай байгууллагын талаар/	3	2025.03.28 №13	2025.04.11 ХЭГ/995	-	-	-	-
5	А.Ариунзаяа	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан	Хөдөлмөрийн хөлсийн доод хэмжээний талаар	3	2025.04.03 №15	2025.04.18 01/1264	2025.04.24 УИХ-03/5089	НББХ 2025.05.07	10	25

6	Г.Тэмүүлэн	Сангийн сайд Б.Жавхлан	Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогын зарцуулалтын талаар	7	2025.04.03 №16	2025.04.17 01/2979	-	-	-
7	О.Батнайрамдал	Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ	Асуулт тавих тухай /Оюу Толгой ордтой холбоотой асуудлаар/	10	2025.04.10 №17	2025.05.05 ХЭГ/1268	-	-	-
8	Д.Үүрийнтуяа	Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн	Эрчим хүчний тарифын зохицуулалтын талаар	1	2025.05.23 №21	2025.06.06 а/1825	-	-	-
9	Ж.Золжаргал	Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар	Улсын Их Хурлын 2025 оны 53 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаар	3	2025.06.20 №24	2025.08.20 ХЭГ/2220	-	-	-
10	П.Сайнзориг	Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн	Монгол банкны арилжааны банканд тавих хяналтын талаар	4	2025.06.27 №25	2025.08.19 А-1/650	-	-	-
11	П.Сайнзориг	Санхүүгийн зохицуулах хорооны дарга Т.Жамбаажамц	Санхүүгийн зохицуулах хороо хяналтын чиг үүрэг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар	1	2025.06.27 №26	2025.08.12 1/3066	-	-	-

---000---

**УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН Г.ТЭМҮҮЛЭН, Ж.ЧИНБҮРЭН НАРААС
2025 ОНЫ 3 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
САЙД Л.ОЮУН-ЭРДЭНЭД ХАНДСАН “ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ,
ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХТЭЙ ХОЛБООТОЙ ТУЛГАМДАЖ БУЙ
АСУУДЛЫН ТАЛААР АСУУЛГА ХҮРГҮҮЛЭХ ТУХАЙ” АСУУЛГА-14**



Монгол Улсын хэмжээнд өрхийн эрүүл мэндийн 224 төв, тосгоны эрүүл мэндийн 20 төв, сумын эрүүл мэндийн 307 төв, дүүрэг, аймаг, бүсийн 31 эмнэлэг, лавлагаа шатлалын үндэсний төвүүд иргэдэд эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлж байна.

Харин Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 03, 04 тоот тогтоолууд гарснаар иргэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүртээмжтэй авахад хүндрэл учирсан, эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах иргэдийн тоо, санхүүжилтийг хязгаарласан байна.

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний гол ачааллыг үүрч байгаа улсын санхүүжилт, өмчлөлтэй эмнэлгүүдийг санхүүгийн дутагдал, хүндрэлд оруулж, үйл ажиллагаанд нь хүндрэл учруулж, доголдуулан, өмчийн ялгаа үүсгэж байгаад харамсаж байна.

Иймд эрүүл мэндийн даатгалын сангаас лавлагаа шатлалын болон аймаг, хотын өрх, сум, сум дундын, эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлгүүдэд олгох санхүүжилтийн хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэх зорилгоор Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн Танд дараах асуулгыг тавьж байна. Үүнд:

1. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх анхан, лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагад эрүүл мэндийн даатгалын сангаас олгох төсөв, тоо хэмжээг хязгаарласнаар иргэд тусламж, үйлчилгээг хүртээмжтэй авахад хүндрэл учруулж байгааг хэрхэн шийдвэрлэх талаар;

2. Өдрийн эмчилгээний зардалтай дүйцэхүйц хэмжээний зардлаар 1 хүний хэвтэн эмчлүүлэх зардлыг тооцож, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардалд суурь тариф тогтоон хязгаарлаж байгаа нь бодит тооцоо, судалгаанд үндэслэсэн эсэх талаар;

3. Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас 2025 онд санхүүжүүлэх төсөв 2024 оноос 20-30 хувиар бууруулсны үндэслэл, тайлбар;

4.2025 онд гэрээлэх төсөв, тоо хэмжээг тохирох боломжгүй байгааг хэрхэн шийдвэрлэх талаар.

Энэхүү асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт заасны дагуу ирүүлж, цаашид Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахад бэлтгэхийг Танаас хүсье.

---oO---

**УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН Г.ТЭМҮҮЛЭН, Ж.ЧИНБҮРЭН НАРААС
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДАД ХАНДСАН “ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ,
ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХТЭЙ ХОЛБООТОЙ ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛЫН
ТАЛААР АСУУЛГА ХҮРГҮҮЛЭХ ТУХАЙ” АСУУЛГА-14-ИЙН ХАРИУГ
НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ 2025 ОНЫ 5 ДУГААР
САРЫН 13-НЫ ӨДРИЙН ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦСЭН МЭДЭЭЛЭЛ**

Нийгмийн бодлогын байнгын хорооны 2025 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, Ж.Чинбүрэн нараас Эрүүл мэндийн сайдад хандсан асуулгын хариуг хэлэлцэв. Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан, Эрүүл мэндийн яамны Хуулийн хэлтсийн дарга Б.Одгэрэл, мөн яамны Анхан болон лавлагаа шатлалын тусламжийн хэлтсийн дарга С.Жаргалсайхан, Санхүү, эдийн засгийн бодлогын газрын Санхүү, даатгалын хэлтсийн дарга Л.Мөнхцэцэг, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дарга С.Энхболд, сайдын зөвлөх А.Батбаяр, мөн газрын Бодлого төлөвлөлтийн газрын Тусламж, үйлчилгээний багц, зохицуулалтын хэлтсийн дарга Б.Ууганбаяр, мөн хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Янжиндолгор нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Х.Энэбиш, референт Б.Цогзолбаяр, Хяналт шалгалтын газрын референт К.Пүрэвсүрэн нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, Ж.Чинбүрэн нараас эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой тулгамдаж буй асуудлын талаарх Монгол Улсын Ерөнхий сайдад хандсан асуулгын хариуг Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан танилцуулав.

Л.Энхнасан: Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан асуулгын хариултыг танилцуулна.

Т.Мөнхсайхан: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Та бүхэнд 2025 оны 3 дугаар сарын 28-ны өдөр Улсын Их Хурлын гишүүн, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн болон Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн нараас эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой тулгамдаж буй асуудлаар Монгол Улсын Ерөнхий сайдад хандсан асуулгын хариуг хүргүүлж, өнөөдөр танилцуулга хийж байна.

Монгол Улсын эрүүл мэндийн салбарт гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн шинэчлэлийг 2021 онд эхлүүлснээс хойш 4 жил болж байна. Өнгөрсөн 4 жилийн хугацаанд хийсэн шинэчлэлийн хүрээнд олон сайн үр дүн гарсан, мөн тулгамдсан асуудлууд ч байна. Энэхүү тогтолцоонд 2024 онд ДЭМБ-аас хөндлөнгийн үнэлгээ хийж, үр дүнг танилцуулсан бөгөөд

олон улсад хийдэг зарчим, сайн туршлага, зөвлөмжүүдийг амжилттай хэрэгжүүлж, богино хугацаанд үр дүнтэй ажилласныг дүгнэсэн. Энэ байдлаар үргэлжлүүлэн сайжруулалт хийвэл 10 жилийн дотор бүх нийтийн эрүүл мэндийн хамралтад хүрэх боломжтойг онцолсон байна. Харин эмнэлгийн тусламж, үйлчилгээний зохион байгуулалтыг сайжруулах, ЭМД-ын сангийн тэнцлийг хангаж цаг тухайд нь төлбөрөө төлдөг болох, эрүүл мэндийн салбарт хийх хөрөнгө оруулалтын төслүүдийг сайтар судлах, төлөвлөж хийх шаардлагатай гэдгийг зөвлөсөн байна.

Хүн амын эрүүл мэндийн байдалд бий болсон үр дүнг авч үзвэл тусламж, үйлчилгээний хүртээмж 43,7 хувиар, нийт хүн амын 80 хувь нь тусламж, үйлчилгээг ЭМД-аар авсан байна. Эрүүл мэндээс үүдэлтэй санхүүгийн эрсдэл буурч, жилд 2 сая төгрөгөөс дээш тусламж, үйлчилгээ авсан иргэдийн тоо 142 мянгаар өссөн ба эдгээрийн дийлэнх нь хүнд өвчтэй иргэд байгаа нь санхүүгийн хамгаалалтын үүргээ тодорхой хэмжээнд гүйцэтгэж буйг илэрхийлж байна. Эрүүл мэндийн байгууллагуудын орлого гүйцэтгэлийн санхүүжилтэд шилжсэнээс хойш 2,17 дахин өссөн бөгөөд хамгийн өндөр өссөн нь сум, тосгоны эрүүл мэндийн төвүүд байна.

Цалин, урамшууллын хувьд эмч, сувилагч нарын гарт олгогдох цалин дунджаар 2,2 дахин өссөн тоо баримт байна. Дээрх орлогын 95 хувийг бүрдүүлж буй ЭМД-ын сангийн тухайд 2021 оноос нэг худалдан авагч болж улсын төсвөөс хариуцах тусламж, үйлчилгээний санхүүжилтийг ЭМД-ын санд шилжүүлж, нэгтгэсэнээс хойш харьцуулалт хийх нь оновчтой бөгөөд 2021 онтой харьцуулахад 1,6 дахин буюу 60 хувиар өссөн байна. Энэхүү шинэчлэл хэрэгжүүлэх цаг мөчтэй зэрэгцээд Ковид-19 цар тахал дэгдэж чамгүй хүндрэл бэрхшээлийг дагуулсан бөгөөд гүйцэтгэлийн санхүүжилтийн тогтолцоо нь энэ хүндрэлийг даван туулахад томоохон үүрэг гүйцэтгэсэн билээ. Гагцхүү эдгээр тусламж, үйлчилгээ үзүүлсэн зардлыг ЭМД-ын сан хариуцаж, үүссэн өр төлбөрүүдийн асуудлыг он дамжин шийдвэрлэхгүй явсаар өдийг хүрсэн. 2024 оны төгсгөлд нөхцөл байдал хүндэрч үе шаттай арга хэмжээнүүдийг авч, амь нас аврах бус амьдралын чанар, сэтгэл ханамжийг дээшлүүлэх, эмчилгээ, үйлчилгээг тодорхой хувиар хязгаарлах зэрэг арга хэмжээг авсан. ЭМД-ын сангийн батлагдсан төсвөөс давсан тусламж, үйлчилгээг эрүүл мэндийн байгууллагуудад үзүүлж, түүний үр дүнд даатгалын санд төлөвлөөгүй нэхэмжлэл үүсэж, өр төлбөрт орж байгаа гэдгийг онцолж хэлмээр байна.

Түүнээс өөрөөр сангийн хөрөнгийг аль нэг банканд байршуулан хөрөнгө бэлдэж, худалдан авалт хийгээгүй. Эрх зүй нь ч тодорхой юм. Даатгуулагч нь тусламж, үйлчилгээ авсан эмнэлгүүд эмч, ажилчдынхаа цалин, урамшуулал болгож олгосон билээ. Иймд 2025 оны төсөвт өмнөх алдаа дутагдлыг давтагдуулахгүй байх, байгаа төсөвтөө багтааж сахилга баттай ажиллах хүрээнд тусламж, үйлчилгээг санхүүжүүлэхдээ тодорхой зарчим баримталж, эрэмбэлэлт хийж ажиллаж байна. Тус зорилтын хүрээнд тусламж, үйлчилгээг олон улсад байдаг аргачлал, туршлага болон эмнэл зүйн үр дүнтэй байдал зэргийг харгалзан цочмог өвчнүүд, төлөвлөж үзүүлдэг өвчнүүд, архаг үеийн өвчнүүд

гэсэн ангиллыг гаргаснаар архаг үеийн өвчлөлүүдийг бууруулах, хязгаарлах арга хэмжээнүүдийг авсан. Амь нас аврах, цочмог болон төлөвлөгөөт тусламж, үйлчилгээ нь гүйцэтгэлээрээ санхүүжих бөгөөд ямар нэгэн хязгаарлалтгүй хэвээр үргэлжилнэ. Зөвхөн үр дүн муутай, шатлал бүрд давхардал үүсэж буй архаг өвчнүүдээр тодорхой хязгаарлалтуудыг хийж байна.

Архаг өвчний тусламж, үйлчилгээг анхан шатны эрүүл мэндийн байгууллага болон аймаг, дүүргийн эмнэлэгүүд амбулаториор эмчлэх шаардлагатай бөгөөд энэ нь эмнэл зүйн хувьд үр дүнтэй, олон улсад ч ийм байдаг. Гэтэл манай улсад эдгээр өвчлөлүүдийг хэвтүүлэн эмчлэх хэлбэрээр олон жил явсан нь хавар, намартаа ядаргаа тайлдаг жишиг тогтсон. Үүний үр дагавар нь тэдгээр өвчнүүдэд санхүүжилт их олгогдож, эсрэгээр нь амь нас аврах боломжтой өвчнүүд санхүүжилтгүй, ар гэрээс гаргах санхүүгийн эрсдэлд ордог. Социалист тогтолцоонд байсан улс орнууд нь “Орос шүтсэн” эмнэлгийн нүсэр бүтцэд суурилсан эмнэлгийн тусламж, үйлчилгээг үзүүлж байсан бөгөөд эдгээр улсууд нь 1990 оноос хойш “орны тоо”-г бууруулж чадсан. Гэтэл манай улсын хувьд “орны тоо”-гоо буулгалгүй улам нэмэгдүүлж, үүний үр дүнд Монгол Улс хүн амд ногдох “орны тоо”-оор дэлхийд 8 дугаар байрт, эмнэлэгт хэвтэлтийн түвшнээр дэлхийд 4 дүгээр байранд, орны ашиглалт 62 хувьтай байна. Хэвтэн эмчлүүлсэн 1 сая тохиолдлын 40 хувь нь хэвтүүлэн эмчлүүлэх шаардлагагүй тохиолдол байгааг Дэлхийн банкнаас хийсэн үнэлгээ, тайланд дурдсан байна. Өөрөөр хэлбэл манай улсын эрүүл мэндийн тогтолцоо үр ашиг муутай, тусламж, үйлчилгээг дахин зохион байгуулах шаардлагатайг харуулж байна. Энэхүү асуудлыг хэзээ нэгэн цагт шийдвэрлэхээс аргагүй, зайлшгүй шийдвэрлэх шаардлага ч үүсэж байна.

Нас баралтын статистик мэдээллийг авч үзвэл 2024 оны байдлаар нас барсан 18 мянган хүний 70 хувийг эмнэлгийн бус нас баралт эзэлж байна. Эмнэлгийн бус энэ нас баралтын 54 хувийг “хэрэв эмнэлгийн тусламж, үйлчилгээ авсан бол сэргийлэх боломжтой” нас баралт эзэлж байна. Гэтэл эдгээр иргэд нь тусламж, үйлчилгээ авч чадахгүй, ялангуяа хөдөлмөрийн насны иргэд, хүүхдүүд энэ дотроо 50 хувийг эзэлж байгаа нь харамсалтай. Иймд бид үр дүнгүй архаг өвчинд даатгалын санхүүжилт мөнгийг зарцуулах биш, ирээдүй болсон үр хүүхэд, хөдөлмөрийн насны нас баралтыг бууруулахад чиглэж, яаралтай тусламжийг өндөр түвшинд хөгжүүлэх, сайжруулах, мөн нас баралтад өндөр нөлөөлөл үзүүлж буй хорт хавдрын тусламж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, төвлөрлийг сааруулах, эрт илрүүлгийг илүү өндөр түвшинд чанартай хийж, үр дүнтэй эмчлэхэд байгаа нөөц бололцоогоо зарцуулах ажлыг зайлшгүй хийх шаардлага байна.

2025 оны 1 дүгээр улиралд өмнөх 3 жилийн турш үүссэн өр төлбөрийг бүрэн барагдуулж дууссан бөгөөд үлдсэн төсөвт багтааж тусламж, үйлчилгээг худалдан авах гэрээг эрүүл мэндийн байгууллагуудтай хийж үндсэндээ дуусаад байна. Төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд заасны дагуу төсвийг үр ашигтай, өр төлбөргүй захиран зарцуулах, төсвийн сахилга батыг хангахад онцгой анхаарч, оны эхнээс холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна.

2024 оны эцэст сангийн төсөв дууссан, эмнэлгүүд цалин тавих боломжгүй, НДШ-ийн хуримтлагдсан өр төлбөртэй, нэн шаардлагатай эмнэлгийн тусламж, үйлчилгээний эмнэлгийн хэрэгсэл тасалдсан, эм хангамжийн байгууллагууд нь хуримтлагдсан өр төлбөрөөс болоод ханган нийлүүлэлтээ зогсоосон зэрэг хүндрэлтэй нөхцөл байдалтай байсан. Эрүүл мэндийн сайдын багцаас хэмнэлт хийж, төсөл, хөтөлбөрийн санхүүжилтийн зориулалтыг өөрчлөх зэргээр арга хэмжээ авч оныг давсан билээ.

2025 онд дээрх асуудлыг давтахгүйн тулд оны эхнээс сар, улирал бүрээр ямар нэгэн тусламж, үйлчилгээнд хэдэн төгрөгийн санхүүжилт хуваарилах тооцооллыг хийж, ЭМД-ын үндэсний зөвлөлөөр сангийн төсвийг нарийвчлан батлах зэргээр арга хэмжээ авсан. Дээрх зарчмын дагуу хуваарилалт хийхэд архаг өвчний тусламж, үйлчилгээг голлон үзүүлдэг байсан эмнэлгүүдийн төсөв илүү буурсан бол амь нас аврах тусламж, үйлчилгээ үзүүлдэг эмнэлгүүдийн төсөв бага хэмжээгээр буурсан байна. Эдгээр төсөв буурсан эмнэлгүүд нь амь нас аврах цочмог болон төлөвлөгөөт тусламж, үйлчилгээг үзүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэх өөрчлөлт хийх, үндэсний хэмжээнд хэрэгжүүлж буй эрт илрүүлгийн бодлогыг хэрэгжүүлэхэд оролцсоноороо тусламж, үйлчилгээний гүйцэтгэлээ нэмэгдүүлэх боломж байгаа гэдгийг онцлон тэмдэглэхийг хүсэж байна.

Түүнчлэн өрх, сумын эрүүл мэндийн төвүүдийн төсвийг бууруулаагүй, нийтдээ 33 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, сумдын эмнэлгийн хувьд заавал хүн хэвтүүлж гол орлогоо олдог биш, анхан шатны суурь тусламж, үйлчилгээг үзүүлж цалин, урамшууллаа олгодог зөв жишиг рүү үү чиглүүлсэн. Тэрнээс нийт төсөв .../минут дуусав./

Л.Энхнасан: Сайдын цагийг нэмье.

Т.Мөнхсайхан: Тэрнээс нийт төсөв буураагүй гэдгийг онцлон хэлэх нь зүйтэй. Эмийн үнийн хөнгөлөлтийн төсөв болон Улсын Их Хурлаас 2025 онд нэмэгдүүлж баталсан, эрт илрүүлгийн төсвийг бууруулаагүй. Зөвхөн эмнэлгийн тусламж, үйлчилгээ дотроо архаг өвчний үеийн тусламж, үйлчилгээнд тодорхой хэмжээний хязгаарлалтуудыг хийсэн. 2025 онд өр төлбөрт төлсөн 316 тэрбумын төсвийн орон зайг үүсгэх бөгөөд үүн дээр нэмэгдээд 2026 оны ЭМД-ын сангийн төсвийн өсөлтөөс хамаарч тусламж, үйлчилгээний тарифыг бодит өртөгтэй ойртуулах, энэ онд хязгаарласан тусламж, үйлчилгээний хязгаарлалтыг арилгах, цалин, урамшууллаа нэмэгдүүлэх арга хэмжээг авах боломж бүрдэнэ.

Цаашид Монгол Улсын эрүүл мэндийн санхүүжилтийн тогтолцоонд олон улсад зөвлөж буй ДНБ-ий 6 хувьд, Засгийн газрын төсвийн 12 хувьд хүргэх чиглэлд бодлогын өөрчлөлт хийж, үе шаттай арга хэмжээ авах зайлшгүй шаардлагатай юм.

2025 онд эрүүл мэндийн салбарт зарцуулж буй төсөв нь ДНБ-ий ердөө 3 хувьтай тэнцэж байна. Энэ нь олон улсын жишиг хэмжээнээс даруй 2 дахин бага байгаа үед хязгаарлалт үүсэхээс өөр арга нөхцөл үүсэж байна. Нөгөө

талаас хүн амын 58 хувь нь эмнэлгийн тусламж, үйлчилгээ авч байгаа гэсэн статистик нь өөрөө Монгол Улсын хүн амын эрүүл мэндийн байдал сайнгүй, өвчлөл их байгааг харуулж байна. Ийм өндөр эрсдэлтэй нөхцөлд даатгалын тогтолцоо маань эрсдэл хуваах чадамж хүндрэх нь ойлгомжтой байна. Иймд Засгийн газрын зүгээс эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх чиглэлд эрх зүйн өөрчлөлт шинэчлэлийг хийж хэрэгжүүлэх бөгөөд үүнд эрхэм гишүүд та бүхний дэмжлэг туйлын чухал гэдгийг илэрхийлэхийг хүсэж байна.

Анхаарлаа хандуулсанд баярлалаа.

Л.Энхнасан: Баярлалаа. Гишүүн Байнгын хорооны хуралдаанаар асуулгын хариуг хэлэлцүүлэхээр бичгээр саналаа ирүүлснээс хойш 10 хоногийн дотор Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх журмын дагуу хэлэлцүүлж байна. Байнгын хорооны хуралдаанд асуулгын хариуг холбогдох албан тушаалтан 3 минутаас илүүгүй хугацаанд танилцуулах бөгөөд гишүүд 3 минутаас илүүгүй хугацаатай асуулт асууна.

Асуулгын хариутай холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Г.Тэмүүлэн гишүүнээр тасаллаа. А.Ариунзаяа гишүүн асуултаа асууна уу.

А.Ариунзаяа: ЭМД-ын сангаас хариуцаж буй тусламж, үйлчилгээний 80 хувийг төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлдэг бөгөөд төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагын орлогын эх үүсвэрээс эмч, сувилагч, төрийн албан хаагчдын цалин, урамшуулал, хангамж тогтдог тул байгаа төсөвтөө тааруулж тусламж, үйлчилгээг худалдан авах шаардлагатай. Цаашид сангийн орлогыг тогтвортой нэмэгдүүлэх эрх зүйн орчныг бий болгох, төсвийг боловсруулах, орлогын олон төрлүүдтэй болох зэрэг шинэчлэл хийхээр төлөвлөж байна. 2025 оны эхний улирлын байдлаар ЭМД-ын сангийн орлогын төлөвлөгөө нь 80 орчим тэрбум төгрөгөөр тасарсан. Дээрх эрсдэлүүд байгаа учраас санхүүгийн сахилга батаар зардлуудыг эрэмбэлэн хязгаарлана, хойшлуулна. 2025 оны төсөв нь өмнөх онтой харьцуулахад 360 орчим тэрбум төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд тус төсөвт төрийн албан хаагчийн цалингийн 6 хувийн өсөлт 2024 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс Засгийн газар төрийн албан хаагчийн цалинг нэмэгдүүлсэнтэй холбоотой санхүүжилт, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын, эрчим хүчний реформтой холбоотой зардлын өсөлтүүд голлох байр суурь эзэлж байна” гэж байгаа юм.

1 дүгээрт, урсгал зардал, төрийн албан хаагчдын цалин хөлс зэргийг яагаад шимтгэл төлөгчдийн сангаас төлдөг юм бэ? Яагаад төр ажиллуулж байгаа албан хаагчийнхаа цалинг, өөрөө гаргаж байгаа гэнэтийн шийдвэрүүдээ, сумдын, жишээлбэл ажилчдын, төрийн албан хаагчдын 40 хувийн нэмэгдлийг гаргаж байгаа юм бол? Яагаад төсвөөрөө энийгээ даахгүй шимтгэл төлөгчдийн бүрдүүлж байгаа сангаас энэхүү асуудлуудыг шийдээд байгаа юм бэ? Энэ чинь эргээд энэ санг алдагдалд хүргэж байгаа шүү дээ. Энэ цагаан дээр хараар бичсэн байгаа асуудлыг л би хэлж байна. Энэ хэвээрээ байх юм бол энэ асуудал шийдэгдэхгүй. Та бүхэн маань энэ сангийн орлогыг нэмэгдүүлнэ л

гэж байна. Сая нэмэгдүүлсэн. Гэхдээ 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 1 хувь байсныг 2 хувь болгож нэмэгдүүлсэн.

4 дүгээр сарын 01-ээс дахиад хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэгдүүлсэн, тиймээ? Тодорхой хэмжээнд энэ арга хэрэгслээрээ нэмэгдүүлээд байгаа байхгүй юу. Гэхдээ ямар үнэ цэнээр. Тэгэхээр энэ сангийн орлогыг нөгөө л албан журмын буюу албан ёсны хөдөлмөр эрхэлж байгаа 700, 800 орчим мянган хүн цалингаасаа ажилтан 2 хувь, ажил олгогч 2 хувийг төлдөг. Бусад 2,4 сая иргэн бол сар бүр 15,0-16,0 мянган төгрөг төлдөг. Энэ асуудлаа цэгцлэхгүй бол уучлаарай, энэ сангийн гол зорилго нь би төлж байгаа шимтгэлээс эрүүл мэндийн үйлчилгээгээ авах ёстой болохоос биш төрийн албан хаагчдын цалинг өгөх гэж шимтгэл төлөөгүй байхгүй юу.

Л.Энхнасан: Т.Мөнхсайхан сайд хариулна уу.

Т.Мөнхсайхан: Өмнөх тогтолцоо маань ЭМД-ын сангаас санхүүжүүлдэг өвчин, төр даадаг өвчин гээд бид өвчнөө өөрсдөө ангилчихсан байсан. Тэгэхээр гүйцэтгэлийн санхүүжилт маань ер нь нэг эх үүсвэрийнх болоод, өөрөөр хэлбэл ЭМД-ын сангийн мөнгө нь төр даах тусламж, үйлчилгээний мөнгө, төсвөөс орж ирж байгаа мөнгө маань нэг эх үүсвэрт цуглараад эмнэлгүүдийн үзүүлж байгаа тусламж, үйлчилгээний өртгөөр нь санхүүжүүлдэг болсон. Тухайн үйлчилгээний өртөг дотор чинь тухайн байгууллагын урсгал зардал, тэр ажлыг хийж байгаа эмч, сувилагчдын цалин мөнгө, тусламж, үйлчилгээг үзүүлэхэд шаардлагатай бүх зүйлийг нь тооцоолоод өртгийн жинг нь тооцоолчихсон. Ингэснээр 2020 оноос өмнө хүмүүс эмнэлэгт хандахад аль болох ачааллаас зугтаж өөр эмнэлэг рүү явуулах зарчимтай байсан бол энэ өөрчлөлтийн хамгийн гол давуу тал нь өнөөдөр бүх эмнэлгүүд аль болох үйлчлүүлэгчээ авч, аятай тухтай орчинд үйлчилгээ үзүүлээд, санхүүжилтээ авахыг эрмэлздэг болсон. Гэхдээ энэ 100 хувь биелэлтээ олтол хугацаа шаардана. Өнгөрсөн 4 жилийн хугацаанд маш их томоохон өөрчлөлтүүд гарсан. Тухайлбал, 2020 оноос өмнө нэг иргэн тусламж, үйлчилгээ авахад 2 сая төгрөгөөс илүү санхүүжилт олгохгүй гэдэг байсан бол санхүүжилтийн тогтолцооны өөрчлөлтөөр 2 саяас дээш яалт ч үгүй санхүүгийн эрсдэлд орж байгаа иргэдэд жишээ нь, 104 сая төгрөгийн элэг шилжүүлэн суулгах мэс засалд орж байгаа хүмүүсээс 5 сая төгрөгийг нь хувь хүн гаргаад, үлдсэн төлбөрийг нь ЭМД-ын сангаас гаргадаг болсон.

Энэ тусламж, үйлчилгээ маань өнгөрсөн 4 жилийн хугацаанд 142 мянган хүнээр нэмэгдсэн. Бид 142 мянган иргэний эрүүл мэндийг санхүүгийн эрсдэлээс нь сэргийлж чадсан гэсэн үг. 2020 онд үзүүлсэн 18 сая тусламж, үйлчилгээг өнөөдөр 26 сая болгон нэмэгдүүлсэн байна. Бид харин одоо үзүүлж байгаа тусламж, үйлчилгээнийхээ санхүүжилтийг зөв оновчтой болгож, эмнэлэгт хэвтэх шаардлагагүй өдрийн эмчилгээгээр эмчлүүлэх боломжтой хүмүүст зарцуулагдаж байгаа үр ашиггүй маш их урсгал зардлаа хэмнэн хүний амь насыг аврах тусламж, үйлчилгээнд зарцуулах мөнгөө илүү нэмэгдүүлэхээр яам бодлогоо гаргаж, зохицуулалтаа хийгээд үр дүн эхнээсээ гарч эхэлж байна.

Гэхдээ зөвхөн энэ жил нэг их хязгаарлалт тавьчихсан зүйл биш, нийт эрүүл мэндийн салбарт тавьж байгаа санхүүжилт чинь хүрэхгүй байгаа учраас өнгөрсөн хугацаануудад бас энэ хязгаарлалт.../минут дуусав./

Л.Энхнасан: Дэгээрээ тодруулга байхгүй юм байна. Гэхдээ нэг минут нэмж өгье.

А.Ариунзаяа: Төрийн албан хаагчдын цалингийн өсөлт болон эрчим хүчний реформтой холбоотой өссөн зардлууд голлох үүрэг хүлээж байгаа учраас төсөв маань хүрэлцэхгүй байна гэдэг дүгнэлтийг ирүүлсэн байна. Тэгэхээр эдгээр төсвөөсөө даах ёстой асуудлаа тусдаа дааж явахгүй бол энэ сангаар эдгээр асуудлууд чинь угаасаа хэцүү. Эдгээр зардлууд өсөн нэмэгдсэн учраас иргэд өнөөдөр эрүүл мэндийн үйлчилгээгээ бүрэн авч чадахгүй байна гэсэн үг. Бэлэн биш байна.

Хяналт тавьж байгаа гэсэн тухайд нэг асуулт байна. Эрүүл мэндийн үйлчилгээтэй холбоотой авч байгаа энэ нэхэмжлэлийн 35 орчим хувьд нь хяналт хийж байгаа гэсэн. Хэд нь зөрчилтэй гарсан бэ? Хийгээгүй эмчилгээнийхээ нэхэмжлэлийг гаргаж эдийн засгийн гэмт хэрэг үйлдэж байгаа газрууд байсан уу?

Л.Энхнасан: Ажлын хэсгээс хариулах уу? С.Энхболд дарга. 6 дугаар микрофон.

С.Энхболд: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. А.Ариунзаяа гишүүний асуултад хариулъя.

2021 оноос хойш буюу гүйцэтгэлийн санхүүжилтэд орсноос хойш нэхэмжлэлийн хяналт маань жилдээ 18 мянга орчим стори (түүх)-г хянадаг байсан бол цахимжилтын ажил эрчимтэй явагдсаны хүчинд жилдээ 60 мянга орчим өвчний түүх дээр хяналтуудыг хийдэг болсон. Ихэвчлэн улсын томоохон эмнэлгүүд дээр нэхэмжлэлийн хяналтууд хийгддэг. Цахимаар болон нарийвчилсан хяналт, мөн шаардлагатай тохиолдолд эмнэл зүйн хяналтуудыг хийгддэг. Эмнэл зүйн хяналтыг тухайн байгууллага хүсэлт гаргасны дараа хийх зохицуулалттай явдаг. Манай цахим дээр бас тодорхой зохицуулалтуудыг хийж явдаг. Ямар нэгэн.../минут дуусав./

Л.Энхнасан: Нэмж хариулна уу? 6 дугаар микрофон.

С.Энхболд: Энд тодорхой зөрчлүүдийг бүртгээд явдаг. Мэдээж оношны давхардал байвал манай зөрчлийн сан руу нэмэгдээд явдаг. Нарийвчилсан тоо яг одоо байхгүй учраас танд бичгээр хүргүүлж болно. Ялангуяа тухайн байгууллагын санхүүжилт өмнөх сарынхаас тодорхой хувиар нэмэгдвэл манай сан дээр бүртгэгдээд, алдааны сан руу ордог. Алдааны сан нэмэгдээд байвал цахим дээр alert буюу анхааруулга асдаг. Энэ дээр давхар хяналтуудыг хийдэг гэсэн үг.

Нийт нэхэмжлэлийн хяналт 2021 оноос хойш хяналт хийгдсэний үр дүнд 5 орчим хувь нь хасагддаг. Энэ юу гэсэн үг вэ гэхээр 2 орчим хувь ... /минут дуусав./

Л.Энхнасан: Нэмээд хариулна уу? 6 дугаар микрофон.

С.Энхболд: Ер нь энэ гүйцэтгэлийн санхүүжилт эхэлснээс хойш эрүүл мэндийн байгууллагууд дээр алдаа, зөрчил харьцангуй бага гардаг болсон. Алдаа, зөрчлүүд засарч байгаа гэсэн үг. Нийт нэхэмжлэлийн 5 орчим хувийг хасагдлын хувь эзэлж байгаа. 95 хувийг эрүүл мэндийн байгууллагууд маань нэхэмжлэлээрээ авч байгаа гэсэн үг. 5 орчим хувийн 2 хувь нь цахимын хяналт байдаг. 2 орчим хувь нь нарийвчилсан хяналт, 1 орчим хувь нь давхардал, ямар нэгэн алдаа зөрчлийн хувийг эзэлдэг. Нийтдээ нэхэмжлэлийн алдааны 5 орчим хувийн хасалт хяналт шинжилгээгээр хасагддаг гэсэн ийм тоо байгаа.

Л.Энхнасан: О.Саранчулуун гишүүн асуултаа асууна уу.

О.Саранчулуун: Асуулгын хариултын 1 дүгээрт “эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх анхан болон лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагад ЭМД-ын сангаас олгох төсвийн тоо хэмжээг хязгаарласнаар иргэд тусламж, үйлчилгээг хүртээмжтэй авахад хүндрэл учруулж байгааг хэрхэн шийдвэрлэх талаар” гэсний 2 дахь хэсэгт “Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын төсвийг 2024 оны төсвийн гүйцэтгэлтэй харьцуулахад 34 тэрбумаар нэмэгдүүлж, огт бууруулаагүй. Үүний зорилго нь лавлагаа шатлалын эмнэлэг, сувилал, хувийн эмнэлгээс өмнө авч байсан зарим тусламж, үйлчилгээг анхан шатын эрүүл мэндийн байгууллагаас авах, эмийн үнийн хөнгөлөлтөөр авах зэргээр анхан шат руу архаг өвчнийг чиглүүлэх бодлоготой уялдуулсан” гэнэ.

Нэгдүгээрт, унаж татдаг хүүхдүүд байгаа. Сэтгэцийн оюуны мэдрэлийн шалтгаант бэрхшээлтэй. Энэ архаг гэдэг ангилалдаа орж байгаа юу? Хэрвээ орж байгаа бол сэтгэцэд нөлөөт болон уналт таталтын эм тасраад байгаа. Олдоц, ханган нийлүүлэлт нь хангалтгүй байгаагаас хавсарсан оноштой олон хүүхдүүдийн эмийг ах, дүү, хамаатан садан, ээж аав нар нь гадаадаас хувиараа зөөвөрлөөд, заримдаа хүнээр, илгээмжээр авчруулж уулгаж байна. Энэ эм үнэтэй учраас хүн бүр гадаадаас авч чадахгүй. Гэтэл тэр эм нь тасалдчихаар тэр айлын амьдрал хүнд байдалд ордог тухай маш олон эцэг, эхчүүдийн гарын үсэгтэй бичиг ирдэг.

Төр өөрөө энэ эмийг авдаг, нөөц бүрдүүлдэг байж болох эсэх талаар асуумаар байна.

Тэр эмийг орж ирэхэд олон улсын эмч нарын бичсэн эмийн удирдамж манайхтай зөрдөг асуудал байна. Тодорхой эмүүд дээр, та нар мэдэж л байгаа байх. Салбар зөвлөл хэзээ хуралдаж энэ стандартыг сайжруулах вэ? гэсэн 3 асуулт дээр тодорхой хариулт өгөөч. Эцэг, эхчүүд маань бас сонсох байх.

Л.Энхнасан: Т.Мөнхсайхан сайд хариулна уу.

Т.Мөнхсайхан: 1 дүгээрт, энэ эмний тухайд ямар нэгэн байдлаар цочмог архаг төлөвлөлт гэж байхгүй. Тийм учраас эмийн санхүүжилт явдгаараа явна. Энэ жилийн хувьд хөнгөлөлттэй эм олгох санхүүжилт нэмэгдсэн. Нөгөө талаас бид даатгалаас хөнгөлөлттэй олгож байгаа эмүүд дээр нэг эх үүсвэрийн худалдан авалтын зохион байгуулалтаар 30 орчим тэрбум төгрөгийн хэмнэлтийг ЭМД-ын сан дээр төлөвлөлтүүд хийгээд, эхнээсээ энэ эмүүд орж ирсэн, үр дүнгээ өгч эхэлж байна. Уналт таталтын хувьд гол хэрэглэж байгаа нэр төрлийн эмүүдийг мөн нэгдсэн эх үүсвэрийн худалдан авалтаар оруулж ирэх ажил хийгдэж байна. Гэхдээ энэ дээр хэлэхэд уналт таталттай хүүхдүүд маань гадны улсуудад очоод олон удирдамж заавраар эмчилгээгээ бичүүлсэн байдаг. Энд нийтдээ бараг 42 төрлийн эмүүд байгаа учраас бүгдийн оруулж ирнэ гэдэг зүйл байхгүй. Гол нэр төрлийг нь оруулж ирэх, үлдсэн нэр төрлүүдийг хувийн хэвшлүүд оруулж ирэх боломжийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулж байна.

Салбар зөвлөлүүдийн тухайд эмчилгээ, оношилгоо, үйлчилгээний гээд манай яаман дээр шаардлагатай 42 төрлийн салбар зөвлөл байна. Зөвлөлүүд хэлэлцэх асуудалтай бол хуралдаад явж байгаа. Уналт таталтын үед үзүүлдэг тусламж, үйлчилгээний салбар зөвлөл саяхан хуралдсан шиг санаж байна. Бид удирдамж зааврыг олон улсын түвшинд хүргэж, guideline (удирдамж)-тай болохгүй бол одоогоор манай улсад яг тогтсон, бүхий л төрлийн өвчлөлийн үед олон улсын стандартын дагуу хийгддэг удирдамж байхгүй. Тиймээс үүнийг нэгдсэн журмаар хийхээс гадна хамгийн гол нь эмчилгээ, оношилгооны шинэ технологи нэвтэрч байгаа энэ үед байнгын update (шинэчлэлт)-ийг хэн, яаж хийх зэрэг зүйлүүдээ бүгдийг нь тодорхой болгож байгаа юм. Энэ ажил ирэх намраас хэрэгжээд эхлэвэл манайхан бүх төрлийн өвчлөл дээрээ удирдамжаа хэрэглээд явна. Өнөөдрийн байдлаар ерөнхийдөө олон улсад хамгийн их хэрэглэгддэг UpToDate (сүүлийн үеийн, цаг үеэ дагасан зөвлөмж)-ийг хэрэглэж, энэ шалгуурыг тавиад явж байгаа гэж ойлгож болно.

Л.Энхнасан: Б.Бат-Эрдэнэ гишүүн асуултаа асууя.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Би нэг сонгогч иргэнээс ирүүлсэн асуултыг асууя. ЭМД-ын үндэсний зөвлөлөөс 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн “Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” 04 дүгээр тогтоол гаргаж, улсын хэмжээнд мөрдөхөөр баталсан боловч үндэслэл муутай өртгийн тооцоолол хийсэн хэвээр байна. Өмнө нь эмнэлэгт хэвтсэн иргэнээс авах хамтын төлбөр нь хувь, улсгүй адилхан 10 хувь байсан бол 03, 01, 08, 04 дүгээр тогтоолоор 15 хувиас 30 хувь болгож өсгөсөн. Суурь тарифыг өсгөсөн боловч зарим эмчилгээний өртгийн жинг үндэслэлгүй, бодит байдалд тохирохгүй багаар тогтоосон. Өртгийн жин хэт бага, хамтын төлбөрөөс өөр төлбөр авч болохгүй байгаа нь төрийн үйлчилгээний зардлаа ч нөхөж чадахгүй байна. Бараа бүтээгдэхүүн, эм тарианы үнэ өсөөд байхад үүнээс өөр нэмэлт төлбөр авахгүй ажиллана гэдэг нь үнэтэй тоног төхөөрөмж битгий ав, эмч, ажилчдын цалинг битгий нэм, урсгал зардлын үнэ тарифыг битгий өг гэж иргэдийг хохироосон, хүний эрхэд халдсан, чанаргүй үйлчилгээ үзүүлэхэд тулгаж байгаатай адил байна.

Хувийн эмнэлгүүд иргэнээс эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд зориулан ямар нэгэн нэмэлт төлбөр авахгүй байхаар зохицуулсан нь эрүүл мэндийн чанартай, хүртээмжтэй олон улсын стандарт шаардлагад нийцсэн, үйлчилгээний үнэ өртгийг тухайн эмчилгээ, үйлчилгээнд хүрэлцэхүйц байдлаар тогтоох шаардлагатай тухай хүсэлтийг эрх бүхий байгууллага, албан тушаалтнуудад удаа дараа гаргасан боловч “тийм байна, ажиллана” гээд л өнгөрдөг.

2025 оны 04 дүгээр тогтоол нь холбогдох хууль тогтоомжийг ноцтой зөрчиж, цаашлаад иргэдийн эрүүл мэндийн чанар, тэгш, хүртээмжтэй нотолгоонд үндэслэгдсэн, олон улсын стандарт шаардлагад нийцсэн үйлчилгээ үзүүлэх боломжийг хязгаарласан. Сэргээн засах болон уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэх бодлогыг дэмжих ёстой яам, агентлагийн түвшинд боловсруулагдаж байгаа стандарт дүрэм, журам нь өнөөгийн түвшинд хэрэгжүүлэх боломжгүй байна. Тухайлбал, монголд бэлтгэгддэггүй мэргэжилтэн, хэл засалч монголд гуравхан байдаг. Энэ 04 дүгээр тогтоолыг мөрдсөнөөр чанарын тусламж, үйлчилгээ доголдоод алдаа гарвал хэн хариуцах вэ? Тогтоол гаргасан ЭМД-ын үндэсний зөвлөл хариуцах уу, мөнгөний дүнд хязгаар тавьж өгсөн төслийн баг хариуцах уу, эсхүл стори (өвчний түүх) бичиж, эмчилгээ хийж буй эмч хариуцах уу?

Л.Энхнасан: Т.Мөнхсайхан сайд хариулна уу.

Т.Мөнхсайхан: Энэ асуулт хувийн хэвшлийн эмнэлгээс ирсэн гэж бодож байна. Бид анхнаасаа гүйцэтгэлийн санхүүжилт гаргахдаа хувийн хэвшлээ маш сайн дэмжсэн. Гэхдээ ямар нэгэн хязгаарлалт тавихгүй бол болохгүй байгаа юм. Энэ санхүүжилтийн тогтолцоог хэрэгжихээс өмнө ЭМД-аас хувийн хэвшилд хамаагүй бага мөнгөөр, улсын эрүүл мэндийн байгууллагуудыг илүү өндөр хувиар санхүүжүүлдэг ялгаатай байдлаас шалтгаалан хувийн хэвшил ачааллыг хуваалцаж чаддаггүй байсан. Иймээс төр, хувийн хэвшил ялгаагүй өвчлөлийн өртгийн жинг нь ижилхэн тогтоож өгсөн. Ингэснээр хувийн хэвшлүүд хөгжих боломжийг бүрдүүлсэн. Одоо хувийн хэвшлүүд тогтоосон өртгийн жингээс дахиад улсын эмнэлгээс илүү хэмжээний мөнгө авах боломжийг нь бүрдүүлээд өгчихөөр эргээд ачааллаас хуваалцах боломж нь хүндрэлтэй болж, өөрөөр хэлбэл хувийн хэвшилд хувь хүний халааснаас гаргах төлбөр хэт өндөр болчихоор мөнгөтэй иргэд л үйлчлүүлдэг болно.

Гэтэл өвчлөл их байгаа учраас тусламж, үйлчилгээ шаардлагатай хүмүүс хувийн эмнэлгээс тусламж, үйлчилгээ авч чадахгүй, ачааллаа хуваалцаж чадахгүй нөхцөл байдал руу орж байгаа учраас ижил хэмжээнд барих нь зөв гэдэг бодлоготой байгаа. Үүнийг маш олон төрлийн тооцоолол хийж байгаа. Тухайлбал, тусламж, үйлчилгээг үзүүлэхэд шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн гаалиар орж ирэх өртөг, тухайн тусламж, үйлчилгээг үзүүлэхэд ажиллах эмч, сувилагчийн хөдөлмөрийн хөлс зардал, тухайн эрүүл мэндийн байгууллагын өндөр өртөгтэй тоног төхөөрөмжийн элэгдэл хорогдлыг хэрхэн тооцох гэх мэтээр бүх зүйлүүдийг тооцоолж байж өртгийн жинг гаргаж

байгаа. Гэхдээ зарим нэгэн учир дутагдалтай зүйлүүд байгааг үгүйсгэхгүй. Ер нь байгаа гэж үзэж байгаа учраас зарим нэг тусламж, үйлчилгээний өртгийн жин дээр өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлага байна.

Бид тусламж, үйлчилгээг авч үзэхдээ эмийн, эсхүл мэс заслын тусламж, үйлчилгээг шүтээд байдаг. Гэтэл манай улсад нөхөн сэргээхийн тусламж, үйлчилгээний хөгжил муу учраас үүнийг хөгжүүлэх, өртгийн жинг зөв тооцоолох, нэмэгдүүлэх шаардлага байгаа. Гол тусламж, үйлчилгээний дараах эмчилгээний бараг 50 хувийг нөхөн сэргээх тусламж, үйлчилгээ эзэлдэг учраас энэ тал дээр цаашдаа анхаарч үзэх асуудлууд байгаа. Ер нь том бодлогоороо хувийн эмнэлгүүд ачааллыг хуваалцах, төр, хувийн хэвшлийн хоорондын ялгааг бууруулах зорилготой байгаа юм.

Л.Энхнасан: Баярлалаа. С.Зулпхар гишүүн асуулт асууя.

С.Зулпхар: Баярлалаа. Миний хувьд стратегийн худалдан авалт буюу гүйцэтгэлийн санхүүжилтийн тогтолцоо руу шилжиж байгааг зөв гэж ойлгож байгаа хүмүүсийн нэг. Гэхдээ асуудал байгааг бүгд яриад л байна. Надад 3 асуулт байна.

Нэгдүгээрт, гүйцэтгэлийн санхүүжилтээр ЭМД-ын сангаас санхүүжилт авч эмнэлгийн үйл ажиллагааг удирдах талаар ялангуяа улсын эмнэлгийн удирдлагууд хэр ойлголттой байгаа вэ?

Эмнэлгийн удирдлагуудтай уулзахаар мөнгө дутаж байна л гэж ярихаас биш санхүүжилт дутсан нөхцөлд хэрхэн зохион байгуулах талаар ойлголт байгаа эсэх нь эргэлзээ төрүүлээд байгаа юм. Энэ дээр хариулт өгнө үү.

Хоёрдугаарт, гүйцэтгэлийн санхүүжилттэй холбоотойгоор ойрын хугацаанд иймэрхүү арга хэмжээнүүд авсан. Нэн шаардлагатай бус хэрнээ ЭМД-ын санд төсвийн нөлөөлөл үзүүлдэг, эмнэл зүйн үр дүн муутай, санхүүгийн хувьд үр ашиггүй тусламж, үйлчилгээг үе шаттайгаар санхүүжилтийг нь хассантай холбоотойгоор сан дээрх ачааллыг хөнгөлөхөд ямар хувь нэмэр болсон бэ? Үүнтэй уялдаад нөгөө талдаа эмнэлгийн үйл ажиллагааны тогтвортой байдалд нөлөөлж байна уу? Дүн шинжилгээ хийж үзсэн үү?

Гуравдугаарт, С.Энхболд даргаас асууя. Баян-Өлгий аймгийн эмнэлгийн санхүүжилт сан дээр 20,9 тэрбумаар төлөвлөгдсөн байсан нь ЭМД-ын ерөнхий газартай гэрээ байгуулахад 17,9 тэрбум болж хасалт хийгдсэнээр санхүүжилт дутуу олгогдож байгаа тухай бичиг ирүүлсэн. Хасалт хийсэн талаар та бүхэн бүгдийг нь ярилаа. Гэхдээ эмнэлгийнхэний яриад байгаа бэрхшээл нь нэгдсэн эмнэлэгт 505 ажилтантай, сар бүр 1,2 тэрбумын санхүүжилт авах схемээр ажилладаг байсан бол одоо ажилтнуудын сарын цалин ч хүрэхээргүй ийм нөхцөл байдал руу орчихлоо гэж байна. Санхүүжилтийн схем, үндсэн зарчим зөв гэж байгаа ч улсын эмнэлгүүд дээр үүссэн энэ байдлыг хэрхэн шийдэх талаарх гаргалгаа, шийдлүүдийн талаар тайлбарлаж өгөөч? Эмнэлгийн удирдлагууд энэ дээр ямар ойлголттой байгаа талаар дахин асууя. Баярлалаа.

Л.Энхнасан: С.Энхболд дарга хариулна уу? 6 дугаар микрофон.

С.Энхболд: С.Зулпхар гишүүний асуултад хариулъя. Орон нутгийн эмнэлгүүдэд бид цочмог, төлөвлөгөөт, архаг гээд оношийн бүлгүүд дээр төлөвлөлт, тодорхой төсвийг тавьж гэрээ хэлцэл хийж байгаа. Энэ жилийн хувьд лавлагаа шатлалын 321 байгууллагатай гэрээ хийхээр төлөвлөснөөс бараг 94 хувь нь хийгдсэн. Баян-Өлгий аймгийн хувьд санхүүжилтийн хувь өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулахад 10 орчим хувь буурсан. Өнгөрсөн 2024 онд 19,5 тэрбум байсан бол энэ жилийн гэрээлэлтийн дүн бараг 18 тэрбумаар хийгдэж, 1,5 тэрбум хасагдсан. Гэхдээ энэ нь зарим тусламж, үйлчилгээ төрөөс даах болон бусад үйлчилгээнд суутгагдаад орчихоор санхүүжилтийн тэнцлийн дүнд нэг их зөрөө байхгүй. Хасагдал 5 орчим хувьтай гэж ойлгож болно. Өөрөөр хэлбэл архаг оношийн бүлэг дээр бага зэргийн хязгаарлалтууд орж төсвөөс хасагдах нөлөөлөл орсон учраас эрүүл мэндийн байгууллагууд маань маш зөв төлөлт хийж, тэвчиж болох зардлуудыг тодорхой хэмжээнд тэвчиж, хүний нөөцийн зөв бодлогыг барьж зохион байгуулалттай ажиллах ёстой.

ЭМДЕГ нь тухайн эрүүл мэндийн байгууллагуудаас үр дүнтэй, хүртээмжтэй, чанартай тусламж, үйлчилгээг худалдаж авах ийм л хууль, эрх зүйн орчинд ажиллах үндсэн чиг үүрэгтэй. Мөн ЭМД-ын үндэсний зөвлөлөөс баталсан тогтоол, журмуудыг хэрэгжүүлж ажиллах чиг үүргийнхээ хүрээнд ажиллаж байна. Тэгэхээр цаашид эрүүл мэндийн байгууллагууд маань жилийнхээ төсвийг зөв төлөвлөж, худалдан авалтуудаа зөв зохион байгуулж төсвийнхөө хүрээнд ажиллах ёстой л гэж хэлмээр байна. Түүрүүн А.Ариунзаяа гишүүний асуултад дутуу хариулсан байна. Манай байгууллага зөрчлийн асуудлаар шүүх, прокурорын байгууллагуудтай хамтарч ажилладаг. Зөрчил үүссэн байгууллагуудад хууль, эрх зүйн орчны хүрээнд нь шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллаж байна. Энэ жилийн 2 дугаар улирлаас эхлээд энэ асуудлууд олон нийтэд ил болно гэдгийг бас хэлье. Баярлалаа.

Л.Энхнасан: Т.Мөнхсайхан сайд хариулна уу?

Т.Мөнхсайхан: Эрүүл мэндийн байгууллагын удирдлагууд харилцан адилгүй л байна. Гэхдээ хагас бие даасан гүйцэтгэлийн санхүүжилтийн энэ тогтолцоонд 2021 оноос шилжсэн. Удирдлагуудыг сургах бэлтгэх ажил 2016 оноос хойш Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хийгдсэн. Би Гэмтэл согог судлалын үндэсний төвийн дарга, Улсын Нэгдүгээр төв эмнэлгийн дарга байхдаа энэ сургалтуудад хамрагдаж явсан. Өнөөгийн нөхцөл байдлыг эргээд дүгнэхэд энэ арга барилд сайн суралцаж, анхаарлаа хандуулж ажилласан, мэдлэг боловсролоо дээшлүүлсэн эрүүл мэндийн байгууллагууд орлогоо маш сайн төвлөрүүлж, тусламж, үйлчилгээгээ тасалдуулахгүй зөв хүргээд, эрүүл мэндийн байгууллагынхаа эмч, сувилагч, ажилчдын цалинг 2-3 дахин нэмэгдүүлэн ажиллаж чадаж байна.

Л.Энхнасан: Нэмэлт цаг өгнө үү.

Т.Мөнхсайхан: Зарим нэг байгууллагын удирдлагууд ойлголтгүй, энэ дээр анхаарлаа хандуулж чадаагүйн улмаас санхүүгийн эрсдэлд ороод ирэхээрээ санхүүжилтийн тогтолцооны өөрчлөлтийг буруу зөв ойлгож ярих тохиолдлууд байна. Сумын ЭМТ, анхан шатныханд нэг зүйлийг сайн тодруулж хэлмээр байна. Санхүүжилтийн энэ тогтолцоо 2020 оноос өмнө ч нэг иргэний санхүүжилттэй байсан. Одоо нэг иргэний санхүүжилтийг нэмэгдүүлээд өгдгөөр нь өгч байгаа. Ингэхдээ хүн ам цөөтэй алслагдмал бүс нутагт коэффициентийг илүү нэмэгдүүлэн бодож байгаа. Дээрээс нь нэмээд 4 төрлийн тусламж, үйлчилгээг гүйцэтгэлээр нь санхүүжүүлэлт нэмж өгч байгаа гэсэн үг. Хэрэв хуучин тогтолцоо руугаа орно гэвэл одоо авч байгаа төсвөөс нь энэ 4 төрлийн гүйцэтгэлээр өгч байгаа энэ санхүүжилт нь хасагдана гэсэн үг. Хуучин нэг иргэнээр санхүүжүүлж байсан тогтолцоонд нь.../минут дуусав/.

Л.Энхнасан: Нэмэлт 3 минут өгнө үү.

С.Энхболд: Бид өнгөрсөн хугацаанд энэ санхүүжилтээс болоод цочмог яаралтай, архаг гээд бүх тусламж, үйлчилгээ нь доголдоод байсан бол энэ жил ангилж нэн шаардлагатай яаралтай тусламж, үйлчилгээгээ ерөөсөө тасалдуулахгүй байх хэрэгтэй юм. Өнгөрсөн онуудад хязгаарлалт хийхдээ бүгдэд нь хийсэн сул тал байсан юм. Энэ тусламж, үйлчилгээг аваад үзэхээр жишээ нь, 2024 онд хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээг 324 мянган хүнд үзүүлж байсан бол 2025 оны байдлаар 303 мянган хүнд үзүүлж байна.

Яаралтай тусламжийг 355 мянган хүнд үзүүлж байсан бол өнөөдөр 401 мянган хүнд үзүүлж байна. Зайлшгүй шаардлагатай тусламж, үйлчилгээнүүд нь өнгөрсөн оныхоос нэмэгдэж яг оновчтой зөв тусламж, үйлчилгээгээ үзүүлж байна. Уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээ өнгөрсөн үеийн байдлаар 143 мянган хүнд үзүүлж байсан бол өнөөдрийн байдлаар 112 мянга болж багассан гэх мэтчилэн бодит өөрчлөлтийн тоонууд гарсан. Үүнийг Та бүхэнд материалаар нь өгч болно. Баярлалаа.

Л.Энхнасан: Баярлалаа. Ж.Чинбүрэн гишүүн асуултаа асууя.

Ж.Чинбүрэн: Асуултад хариулж байгаа, ирүүлсэн мэдээллийг харахад хэтэрхий томъёолсон байдлаар хариулаад байна. Жишээлбэл, анхан шатны тусламж, үйлчилгээний санхүүжилтийг сайжруулах олон гаргалгаанууд байгаа. Тухайлбал, шилжиж байгаа иргэдийн асуудлыг яагаад ярихгүй байгаа юм. Цахим боллоо гээд байр сууцаа, хаягаа өөрчилсөн иргэд очсон газраа анхан шатны тусламж, үйлчилгээний нэг иргэний санхүүжилтийг тухайн хороо, ЭМТ-д нь өгөх боломжгүй байгаад байна. Энэ асуудлыг яаж шийдэх вэ?

Хоёрдугаарт, би бүр толгой эргэчихлээ шүү. Т.Мөнхсайхан сайд өнгөрсөн чуулган дээр Ковид-19 цар тахалтай холбоотой бараг 360 гаруй тэрбум төгрөгийн өр үүслээ гээд байсан. ЭМДЕГ-аас өгч байгаа мэдээлэл, төсөв энэ тэрийн тайланг харахаар 2021 онд 264 тэрбум төгрөгийн өглөгтэй байснаа 2022 онд төсөвт 60 тэрбум л үлдсэн гэж тайлагнаж байгаа, тиймээ? 60 тэрбум болохоор буцаагаад ОУБ-аар төлүүлчихсэн гэж би ойлгоод байгаа. Одоо

яагаад ковид цар тахлын үеийн өр нь 316,3 тэрбум байна гэж яриад байгаа юм. Би бүүр толгой эргээд байна. Т.Мөнхсайхан сайд та тэгж хэлсэн шүү. Ковид цар тахлын зардлыг бид дарахын тулд таналт хийж өрөө дараад явж байгаа гээд байх юм. Ийм таналт хийсэн гээд байгаа биз дээ, гүйцэтгэлийн санхүүжилтийн 20-30 хувийг нь хэмнээд хийсэн гээд байгаа биз дээ? Энэ чинь бүүр даатгуулагчийн эрх рүү халдаад уналаа. Тийм учраас ЭМДЕГ-ын дарга энэ дээр тайлбар хэлээд өгөөч. Энэ ямар учиртай ийм юм болоод байна вэ?

Гуравдугаарт, энэ лавлагаа шатлалын эмнэлгүүдийн гүйцэтгэсэн байдлыг 2024 онд харьцуулахаар 1,4 их наяд байгаа. 2025 онд 1,2 буюу 200 тэрбумаар буулгачихсан. Тэгсэн хэрнээ лавлагаа шатлалын эмнэлгүүдийн авлага нь нийт өрийн 54 хувийг эзлээд байгаа шүү дээ. Төрийн өмчит эрүүл мэндийн байгууллагын авлага нь 54 хувь гээд та хэд тайлан тавьчихсан байна. Тэгэхээр төрийн өмчит эмнэлгүүдийн өглөгийг өгөхгүй байх шалтгаан юу вэ? Яагаад ийм их болоод байна? Энэ дээр нэг тайлбар хэлээч?

Л.Энхнасан: 6 дугаар микрофон. С.Энхболд дарга хариулна уу.

С.Энхболд: Ж.Чинбүрэн гишүүний асуултад хариулъя. Өмнөх онуудын өр, авлагын асуудлыг асууж байна. 2021, 2022 оны үед би Эрүүл мэндийн сайдаар ажиллаж байхдаа ЭМДҮЗ-ийг бас даргалж байсан. Ковидын тусламж, үйлчилгээтэй холбоотой сарын, жилийн гүйцэтгэлийн хэтрэлт нь 2021 онд 264 тэрбумаар давсан. Энэ өглөг 2022 он руу шилжиж орсноор 2022 оны жилийн эцсээр 264 тэрбум гэдгээрээ гарсан. Энэ үед Улсын Их Хурлын гишүүд болон Засгийн газар идэвх санаачилгатай ажиллаж, Засгийн газар, Сангийн яаман дээр ч энэ асуудлууд нэлээн хурцаар явагдсан. Төсвийн байнгын хороон дээр Ж.Чинбүрэн гишүүн ч гэсэн манлайлалтай ажиллаж энэ тусламж, үйлчилгээнд зарцуулсан өр, авлагыг барагдуулахад тодорхой хувь нэмэр оруулсан. Ингээд 200 тэрбумын өрийг тухайн үед Төсвийн байнгын хороон дээр тэглэж, 2023 онд 60 тэрбумын өр өглөгтэй орохоор туссан. Гэхдээ үүнийг Апакс хөтөлбөрийн хүрээнд Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж байсан. Үүнийг ийнхүү эргэн төлөгдөхөөр зохицуулалтыг хийгээд 2023 он руу шилжүүлээд явсан. Ингээд өр, авлагууд маань 2023 онд явсаар жилийн эцэст нэмэгдээд 60 тэрбумын Апакс хөтөлбөрийн санхүүжилт орж ирэхгүй явсаар байгаад 2023 оны жилийн эцэст 218 тэрбум болсон. Энэ өглөг дахиад 2024 он руу шилжээд нийтдээ 316 тэрбум болсон. 316 тэрбум дээр бас тодорхой хэмжээний өр, авлагууд нэмэгдэж өр нь 400 гаруй тэрбумын өглөгийн асуудал эрүүл мэндийн байгууллагуудад үүссэн. Эрүүл мэндийн сайд 2024 онд нэлээн идэвх санаачилгатай ажилласны хүчинд 100 гаруй тэрбумыг сайдын багц болон бусад тусламж, хөтөлбөрүүдээс барагдуулж, 316 тэрбумыг энэ жилийн төсвөөс барагдуулахаар ЭМДҮЗ-ийн хурлаар оруулснаар эхний улиралдаа багтааж бид үлдсэн 316 тэрбумыг 2025 оны төсвөөсөө өгч барагдуулсан.

Л.Энхнасан: Т.Мөнхсайхан сайд хариулна.

Т.Мөнхсайхан: Гол асуудал нь гүйцэтгэл ковидын үед давсан, 2023 онд ковид үргэлжилсэн. Ковидын тусламж, үйлчилгээнүүдийн төлбөр сангийнхаа тэнцлээс даваад яваад байсан. Гэхдээ энэ өр, төлбөрийг барагдуулсан асуудлыг хүмүүс буруугаар ойлгоод байна. Энэ бол эрүүл мэндийн байгууллагууддаа өгөх ёстой өнгөрсөн онуудад хуримтлагдсан өр төлбөрийг барагдуулсан тийм зүйл шүү. Анхан шатны байгууллагуудад үнэхээр тийм асуудал байгаад байгаа. Шилжилт хөдөлгөөн болдог. Нэг иргэнээр нь санхүүжилтийг нь өгөхөөр түр оршин суугчаа, шилжилт хөдөлгөөн болсон зүйлүүдээ яах юм. Тэгэхээр тухайн өрх хороонд хэдэн иргэн байна гэдгээ бид 2 жилдээ нэг удаа тооцоолж гаргаад .../минут дуусав./

Л.Энхнасан: Нэмж хариулна уу. Т.Мөнхсайхан сайд.

Т.Мөнхсайхан: Ингээд санхүүжилтээ өгдөг байсан бол өнөөдрийн байдлаар энийгээ нэлээн урагшлуулаад Үндэсний статистикийн хороотой мэдээллээ шууд солилцдог болж байгаа. Ингэснээр бодит цагийн горимд тухайн хороо, тухайн суманд хэдэн иргэн сууж байна гэдгээр нь санхүүжүүлдэг болсон. Бид тосгоны түвшинд дараагийн шийдэх ёстой хамгийн гол зүйл бол сум, тухайн сумын иргэн биш ч ойролцоо амьдарч байгаа, өөр сумын иргэдийн санхүүжилтийг шийдэх тооцооллуудаа нарийвчлаад гаргаж байна. Үүнийг зөв гаргачихвал тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа иргэдийн тоогоор нэг иргэнийхээ санхүүжилтийг авах боломж бүрдэх юм. Бид нар лавлагаа шатлалын төв.../минут дуусав./

Л.Энхнасан: Нэмээд хариулъя. Т.Мөнхсайхан сайд.

Т.Мөнхсайхан: Бид санхүүжилтийнхээ тогтолцоог зөв голдиролд нь оруулъя. Тэгэхгүй бол лавлагаа шатлалтай буюу 1, 2, 3 дугаар эмнэлэг, ХСҮТ рүү нийт төсвийнхөө 80, 90 хувийн, анхан шат руугаа дөнгөж 10, 20 хувийн санхүүжилтийг өгч байсан. 2021 оноос санхүүжилтийн тогтолцоо өөрчлөгдсөнөөс хойш анхан шатын санхүүжилт маш ихээр нэмэгдсэн. Зарим байгууллагуудынх 3 дахин, доод тал нь 2 дахин нэмэгдсэн. Ингэхээр лавлагаа шатлал дээр үзүүлж байгаа тусламж, үйлчилгээний тоо буурах ёстой учраас бид тодорхой зохицуулалтыг хийж үзэж байгаа. Энэ дээр бид цаашдаа нарийн тооцооллууд хийгээд анхан шатаа дэмжих, санхүүжүүлэх бодлогоо сайжруулна. Лавлагаа шатлалаа Монгол Улсад эмчлэгдэхгүй байгаа шинэ технологийг эмчилсэн тохиолдолд илүү санхүүжүүлнэ гээд өнөөдөр яг үндсэн.../минут дуусав./

Л.Энхнасан: Г.Тэмүүлэн гишүүн асуултаа асууя.

Г.Тэмүүлэн: ЭМД-ын сантай холбоотойгоор Засгийн газарт асуулт тавьсан. Гол үндсэн асуудал маань иргэд, даатгуулагчдынхаа эрх ашгийг хамгаалах үүднээс энэ асуудлыг гаргаж тавьсан юм. Би буруу тооцоогүй бол сүүлийн 2, 3 сар үндсэндээ ЭМД-ын сангаас санхүүжиж байгаа 360 орчим анхан шатны болон лавлагаа шатлалын, мөн ЭМТ-үүд байгаа. Эдгээр 360-аас бараг 20-30 эмнэлгүүдээр нь би сая аймаг, сумдаар тойрч явахдаа хувь хүнийхээ үүднээс үзсэн. Үндсэндээ анхан шатанд ажиллаж байгаа эмнэлгүүдийн маань

нөхцөл байдал хүндэрчихлээ. Бид эмнэлгүүдийг гүйцэтгэлээр санхүүжнэ гээд 2021 оноос хойш явсан. Гүйцэтгэлийн бусаар санхүүжүүлж байна. Тусламж, үйлчилгээний тоо хэмжээг бараг хүчээр тулгаж байна гэж ярьж байна. Тэд ямар нэг байдлаар санхүүжилтийнхээ тусламж, үйлчилгээний төрөл зүйл болоод хэвтэн эмчлүүлэгчдийнхээ ч гэдэг юм уу, бусад үйлчлүүлэх хүмүүсийнхээ тоог хамгаалах ямар нэг нөхцөл боломж байхгүй байна гэдэг. Би сумын нэрийг нь хэлээд яахав, жишээ нь санхүүжилтийнх нь хуваарь дээр энэ нэг сард 9 сая, тэгвэл 6 сард нь 1,8 сая гэж байгаа юм. Тэгэхдээ энэ дүнгүүд нь бүгд задаргаатай, мөнгөтэйгөөр гарч байгаа нь маш нарийвчлалтай үндэслэж гаргаж ирсэн юм шиг харагдаад байгаа юм. Гэхдээ тэднээс үндэслэж ямар нэг санал аваагүй гэдэг. Энэ магадгүй танай өмнөх жилүүдийн чинь гүйцэтгэл дээр суурилсан юм уу гэхээр үгүй гэдэг.

Сумдуудыг аваад үзвэл жишээ нь, 960 сая авч байсан сумдууд ч гэдэг юм уу, 445 сум 40-50 хувийн бууралттай. Аймгийн төвийн нэгдсэн эмнэлгүүдийг аваад үзвэл 16 тэрбум авч байсан бол 12 тэрбум буюу 20-30 хувийн бууралттай. Дүүргийн эмнэлгүүд бас ялгаагүй болчихоод байна. Нэг талдаа ЭМДЕГ үндсэндээ төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засаг шиг, соц үеийнх шиг бидэнд хэдэн хүн эмчлүүлэхийг, ирэх он дуустал сар бүр хэдэн хүн, ямар төрлөөр эмчлүүлэхийг нэг бүрчлэн тоогоор нь зоогоод гаргаж ирсэн гэж байгаа юм. Тэгэхээр би буруу бодоогүй бол энэ он дуустал үзүүлэх хүний тоог манай ЭМДЕГ “Ванга” шиг мэдээд байгаа юм уу гэдэг асуудлыг яриад байна. Үндсэндээ хааж байгаагаас ялгаагүй бодлого явуулаад, эрүүл биш ЭМД сантай боллоо шүү. Энэ асуудлыг анхаарч, гүйцэтгэлээр санхүүжих асуудлыг тавьж өгөөч гээд байгаа юм. Би өмнө нь С.Энхболд даргыг сайд, ЭМД-ын үндэсний зөвлөлийн дарга байхад 2022 онд хандаж байсан. Та ЭМДЕГ-ын дарга болоод бас энэ асуудлыг хөндөж тавьж байгаа. Тэгэхээр асуудал, онош нь нэг болчихоод байна. Энэ дээр та хариулт өгөөч.

Л.Энхнасан: ЭМДЕГ-ын дарга С.Энхболд хариулъя. 6 дугаар микрофон.

С.Энхболд: Г.Тэмүүлэн гишүүний асуултад хариулъя. ЭМДЕГ нь Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг учраас тогтоол, шийдвэрүүдийг хэрэгжүүлдэг байгууллага. Энэ оны 01 дүгээр сарын 02-ны өдөр 2025 оны төсөв батлагдсанаар бид нарийвчилсан хуваарийг батлуулсан. Өмнөх жилүүдэд тухайн жилийнх нь төсвийг баталдаг байсан бол энэ жилийн онцлог нь санхүүгийн сахилга батыг сахиулахын тулд ЭМД-ын үндэсний зөвлөлийн тогтоолоор нарийвчилсан хуваарийн дагуу сар бүрээр төсвийг батлуулсан. Өөрөөр хэлбэл өмнөх оны өглөгийг өгөөд, нийтдээ 1,9 их наядыг 12 сардаа хуваагаад батлуулчихсан гэсэн үг. Ингэхээр сар бүр 164 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгох нарийвчилсан хуваарийг батлуулаад бид Сангийн яаманд өгчихсөн байсан. Үүнээс 104 тэрбум нь лавлагаа шатлал дээр, үлдсэн нь анхан шатын тусламж, үйлчилгээ болон төр даах хөнгөлөлттэй тусламж, үйлчилгээнд зарцуулагдахаар төсвийн хуваарь нь батлагдчихсан. Төсвийн нарийвчилсан хуваарьт багтаахын тулд сар бүрийн төсөвтөө тоо хэмжээ тавьж байгаа.

Түрүүн сайд хэлсэн. Анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа эрүүл мэндийн байгууллагуудаас нэг ч төгрөгийн төсөв хасагдаагүй. Та бүхэн

харвал энд анхан шатны баталсан төсөв, өмнөх оныхоос 40-өөд тэрбумаар илүү байгаа. Энэ бас л анхан шатны тусламж, үйлчилгээнд зарцуулагдахаар тусгагдсан гэсэн үг.

Тэгэхээр энэ жилийн нарийвчилсан төсвийн хүрээнд 533 тэрбум төгрөг нь анхан шатны тусламж, үйлчилгээ буюу 555 гэрээтэй байгууллагуудад хуваарилагдсан, энэ төсвийнхөө хүрээнд явж байгаа. Нэг ч сумын төсөв өмнөх оныхоо төсвөөс хасагдаагүй, сумын ЭМТ-үүд маань тойргийнхоо гишүүд, удирдлагуудад буруу ойлгуулаад байх шиг байна. Үүнийг бид сайн ойлгуулан ярилцаж, гэрээ хэлэлцээр хийгээд явж байгаа.

Л.Энхнасан: Г.Тэмүүлэн гишүүн тодруулъя.

Г.Тэмүүлэн: Үгүй С.Энхболд дарга аа. Энэ ЭМД-ын сан чинь иргэдийн буюу даатгуулагчдын дундын сан, эндээс бид иргэдийн тусламж, үйлчилгээг авах учиртай юм. Гэтэл үндсэндээ зориулалтын бусаар урсгал зардал, цалин хөлс, НДШ ч гэдэг юм уу, төсвөөс гарах зардлууд гэсэн ийм зүйлүүдэд зарцуулагдаад иргэд үйлчилгээгээ авч чадахгүй байгаа нь иргэд, даатгуулагчдын эрх ашиг хөндөгдөж байна гэдэг асуудал яриад байгаа юм. Асуудал үүсэнгүүт Та бүхэн миний түрүүний хэлсэн төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засаг гэдэг шиг 2025 онд төлөвлөсөн тоо хэмжээ, гэрээнүүд, бөглөх хуудас бүгд адилхан ирж байгаа байхгүй юу. Тэр сумынх, аймгийнх, энэ хажуу талын Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг ч гэсэн ялгаагүй бүгд тулгаад явчхаад байна гээд байдаг. Эмнэлгүүдээр ороод үзэхээр манай тойргийн гишүүддээ буруу хэлээд байна уу гэдгийг авч үзсэн. Ялгаагүй, хажуу талын Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг чинь үзүүлдэг хүмүүсийнх нь тоо байхгүй болоод ер нь хоосрох маяг руугаа орж байна гээд байна. Тэгэхээр энэ зөв юм уу? Гүйцэтгэлээр санхүүжих ёстой асуудлыг.../минут дуусав./

Л.Энхнасан: С.Энхболд дарга хариулъя. 6 дугаар микрофон.

С.Энхболд: Анхан шатны тусламж, үйлчилгээн дээр журмаараа нэг иргэний тариф нь хүн амын тоотойгоо уялдан хуваарилагдаж байгаа. Суман дээр 4 төрлийн тусламж, үйлчилгээ, бас гэрээр үзүүлэх тухайд хуульд заасан (9.1.9 дэх заалт) хүрээнд тусламж, үйлчилгээг үзүүлэхийн тулд тухайн жилийнх нь төсвийг батлаад, түүнийгээ 12-т хуваагаад, харин тэр дотроо цочмог яаралтайгаа тухайн эрүүл мэндийн байгууллага нь өөрөө хувиараа хийж өгч байгаа юм. Танайх энэ төсвийн хүрээнд зохицуулалтаа хийж ажиллах нь байна шүү гэдэг ерөнхий зааврыг өгсөн. Тэр тоо хэмжээ буюу цочмогийн оношийн бүлгээс тэдийг, төлөвлөгөөт онош тэдийг, архаг оношийн бүлгээс тэдийг авна гэж тухайн байгууллагаас манайд ирүүлсэн санал дээр нь тохиролцож бид гэрээгээ хийж байгаа. Бүх шатанд яг адилхан явж байгаа.

Л.Энхнасан: Т.Мөнхсайхан сайд сая нэмж хариулъя.

Т.Мөнхсайхан: Яг тоогоор нь яривал 2024 онд анхан шатных 499 тэрбум төгрөгийн санхүүжилт авч байсан байна. Өнөөдрийн байдлаар

энэ онд 533 тэрбум төгрөгийн санхүүжилт авахаар байна. Бид цочмог буюу нэн шаардлагатай яаралтай тусламж, үйлчилгээн дээр ямар нэгэн хязгаарлалт аль ч түвшинд хийхгүй. Сум, өрх, багийн эмнэлгүүд бүгдээрээ энэ тусламж, үйлчилгээгээ үзүүлээд санхүүжилтээ авч болно. Архаг өвчлөлийг л бид тооцоолох боломжтой байхгүй юу. Тийм учраас архаг өвчлөл бол эмнэлэгт хэвтэх шаардлагагүй, төлөвлөөд өдрийн эмчилгээ хийчих боломжтой буюу эмнэлэгт хэвтэх шаардлагагүй өвчлөлөө бууруулъя гэдэг дээр санхүүгийн зохицуулалт хийсэн.

Хэрвээ үнэхээр анхан шатны байгууллагуудаас, ялангуяа сумын ЭМТ-өөс зөвхөн нэг иргэнийхээ санхүүжилтийг авч санхүүжмээр байна, манай санхүүжилт өмнөх оныхоосоо.../минут дуусав./

Л.Энхнасан: Нэмээд хариулна уу.

С.Энхболд: Дордчихлоо, буучихлаа гэсэн сумын Эрүүл мэндийн төв байвал миний нэр дээр бичгээ явуулаад, тэр санхүүжилтийнхээ тогтолцоог хуучин нэг иргэнийхээ санхүүжилтээр санхүүжчих гээд байна шүү дээ. Энэ өөрчлөлтийг хийх боломжууд, гарц гаргалгаанууд гарч болно. Үнэхээр хүсэж байвал. Зарим нэг хүн ам цөөтэй тосгоны эмнэлгүүд хэцүү байна гээд байгаа юм. Тэр улсуудын нэг иргэнээрээ авах санхүүжилтийнх нь тарифыг нэлээн өндөр болгож нэмээд нэг иргэнээр нь өгч байгаа. Энэ чинь яг л хуучин тогтолцоо. Дээр нь нэмээд гүйцэтгэл хийгээд тусламж, үйлчилгээ үзүүлээд санхүүжилт ав л гэж байгаа юм.

Тэгэхээр үнэхээр хуучин буюу зөвхөн нэг иргэнээрээ санхүүжмээр байна гэсэн сумын ЭМТ, тосгоны эмнэлгүүд байвал сайдын нэр дээр хүсэлтээ явуулаад асуудлаа шийдүүлж болно.

Л.Энхнасан: Би нэг асуулт асуучихъя.

Энэ 2025 оны төсөв батлахад бид ЭМД-ын сангийн төсвийг нэлээн нэмэгдүүлсэн. Энэ тайлан дээр, өсөлтөд төрийн албан хаагчийн цалингийн 6 хувь өсөлт, мөн холбогдох цахилгаан, дулааны зардал, түрээсийн зардал гэжээ. Ер нь энэ зардлаас хэдэн хувь эзэлж байна гэсэн асуулт байна.

Хоёрдугаарт, өмнөх онтой харьцуулахад хуримтлагдсан өр болон 316 тэрбум төгрөг бүрэн барагдуулсан гэж байна. Үнэхээр бүрэн барагдуулсан уу, өртэй эмнэлгүүд байна уу?

Энэ олон дахин давхардуулж байгаа өдрийн эмчилгээ, архаг өвчлөлийг ойлгож байна. Гэхдээ уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээ, сувиллын тусламж, үйлчилгээ яагаад бас 60 хувиар буурсан юм бэ? Энэ дээр тайлбар өгнө үү?

Л.Энхнасан: Т.Мөнхсайхан сайд хариулъя.

Т.Мөнхсайхан: Эрүүл мэндийн салбарын нийт санхүүжилтийн 60 хувь нь ажилчдын цалин, НДШ-д явж байгаа. 30 хувь нь эм, эмнэлгийн хэрэгсэл, 10 хувь нь бусад зардал гэсэн байдлаар ерөнхийдөө зарцуулагдаж байгаа.

2024 онд нийт эрүүл мэндийн салбарын төрийн албан хаагчдын цалин 1 их наяд 50 тэрбум байсан. Энэ жилийн 6 хувийн өсөлт ороод ирэхээр 1,1 их наяд 10 тэрбум орчим болж байгаа. Уламжлалт, сувиллын тусламж, үйлчилгээ болон зарим ихэнх оношийн бүлгүүд нь архаг тусламж, үйлчилгээ рүү орж байгаа. Тийм учраас бид тодорхой хэмжээний бууралтууд хийж байгаа. Гэхдээ яг өнөөдрийн байдлаар хуваарилсан төсөв, хуваарилалт, архаг өвчлөлийн бууралтыг тооцож үзвэл өнгөрсөн оныхоос 9 хувиар л буурч байгаа. Энэ жилийн санхүүжилтийнх нь тоо хэмжээг үзүүлэх тусламж, үйлчилгээний тоогоор авч үзнэ гэсэн үг. Ерөнхийдөө 40 хувийн шаардлагагүй хэвтэлт байна гэдэг асуудал яригдаж байхад энэ жилийн хувьд 9 хувийн бууралтыг хийе, нэн шаардлагатай тусламж, үйлчилгээгээ санхүүжүүлэе л гэдэг бодлого яваад байгаа юм.

Л.Энхнасан: Тэр хасаж байгаа 40 хувь нь яаралтай эмчилгээ, үйлчилгээнд орж байна гэж ойлгож болох уу? Ерөнхийдөө буурч байгаа 40 хувь ямар үйлчилгээнд илүү зарцуулагдах юм. Т.Мөнхсайхан сайдын микрофоныг нээнэ үү.

Т.Мөнхсайхан: Ерөнхийдөө ЭМД-ын санд төвлөрч байгаа энэ санхүүжилт нь эмнэлгийн тусламж, үйлчилгээг санхүүжүүлэхээс өөр тийшээ гарах нэгдүгээрт ямар ч боломжгүй гэдгийг хэлэхийг хүсэж байна. Өмнө нь ямар нэгэн байдлаар арилжааны банканд байршуулаад хувийг нь авдаг, хүүг нь авдаг, энэ дээрээ алдагдал хүлээсэн тохиолдлууд байсан бол ЭМД-ын сан бол зөвхөн төрийн санд байршихаас өөр боломжгүй. Энэ талаар хуулийн өөрчлөлтийг хийсэн.

Тэгэхээр архаг, уламжлалтын тусламж, үйлчилгээний буурч байгаа хувь эргээд нэн шаардлагатай цочмог тусламж, үйлчилгээ рүүгээ зарцуулагдсанаар бид илүү олон хүний амь насыг аврах, ирээдүйд хөдөлмөрийн чадвар алдалтаас сэргийлэх гол үндсэн санхүүжилт, эрүүл ирээдүйг бий болгох гэдэг бодлого руугаа энэ санхүүжүүлэлтүүд хийгдэж байгаа.

Л.Энхнасан: Эмнэлгүүд даатгалаас ямар нэгэн өр төлбөргүй болсон гэж ойлгож болох уу? С.Энхболд дарга хариулна уу. 6 дугаар микрофон.

С.Энхболд: Өмнөх онуудын өр, авлага 316 тэрбум, хувийн хэвшил болон улсын эмнэлэг, эмийн сан, анхан шат гээд бүх шатны эмнэлгүүдэд нийлээд 316 тэрбум төгрөгийн өр байсныг бид эхний 3 сард багтааж бүрэн барагдуулсан байгаа. Иймд одоогийн байдлаар ЭМД-ын сангаас авлагатай нэг ч эрүүл мэндийн байгууллага байхгүй гэсэн үг.

Түрүүн та сувиллыг асуулаа. Ер нь ЭМДЕГ 2300 орчим эрүүл мэндийн байгууллагуудтай гэрээ хийж ажилладаг. Үүнээс 321 нь лавлагаа шатлалын

эрүүл мэндийн байгууллага, 555 нь сум болон өрхийн эрүүл мэндийн байгууллагууд байдаг. 1500 орчим эмийн сангууд гэрээтэй ажилладаг гэсэн үг. Үүнээс лавлагаа шатлалын 321 байгууллагаас 44 байгууллага нь сувиллын тусламж, үйлчилгээ үзүүлдэг.

Л.Энхнасан: Гишүүд асуулт асууж дууслаа. Одоо асуулга тавьсан гишүүн 5 минутаас илүүгүй хугацаанд үг хэлнэ. Хоёулаа 5, 5-аар асуулгатай холбоотой өөр ямар нэгэн асуулт асуух боломжтой. Ингээд Ж.Чинбүрэн гишүүн асуулт, үгээ хэлнэ үү.

Ж.Чинбүрэн: Баярлалаа. Би Байнгын хорооныхоо гишүүддээ уриалга гаргах гээд байна. Ер нь энэ гүйцэтгэлийн санхүүжилттэй холбоотой бид зах зээлийн тогтолцоо, нэг ёсондоо үр дүн, чанарын өрсөлдөөнийг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээндээ оруулах гэж энэ өөрчлөлт хийсэн. Гүйцэтгэлтэй холбоотой мэдээж асар их хүсэл байгаа. Санхүүжилт нь өөрөө хязгаартай. Тэр болгоныг давж, дааж гарна гэдэг маш мундаг менежмент, ухаалаг тооцоолол шаардлагатай. Зөвхөн гүйцэтгэлийг харахад л 2024 он гэхэд 316 тэрбум төгрөгийн дутагдал санд үүсэж байна. Тийм учраас эрхэм гишүүдээ, хэдүүлээ энэ асуудлыг чуулганд оруулж, 2026 оны төсөв ярьж эхэлчхээд байгаа энэ хугацаанд ЭМД-ын санг бодитой хэмжээнд хүргэхэд, 3,6 сая иргэддээ эмнэлгийн байгууллага нь очер дараалал үүсгэж, үүдээ хааж, төлбөр нэхэж суудаг үйлчилгээтэй биш, харин үүд хаалгаа нээж, илүү сайхан тусламжийг сэтгэл хангалуун өгдөг байх тогтолцоо, том өөрчлөлтийг хийхэд төсөв санхүүгийн дэмжлэг чухал байгаа учраас энэ тал дээр та бүгдийг чуулганаар асуудлыг хэлэлцэхэд дэмжиж санал хураалтад оролцоосой гэж хүсэж байна.

Хоёрдугаарт, би асуултууддаа тайлбар хэлэхээ болилоо. Ер нь бүтээлч зөв зүйлүүдийг, актуар тооцооллууд, илүү бүтцийн тогтолцооны том шинэчлэл хийх тухайгаа бас яримаар байна. Тухайлбал, Эрүүл мэндийн яам ЭМД-ын санг заавал өөрийнхөө доор байлгах ямар ач холбогдол байгаа юм. Эсрэгээр нь энэ чинь эмнэлэг, өвчтөн, даатгал гэсэн 3 холбоос дунд садаа болоод байгаа энэ тогтолцоог бид өнгөрсөн 5 жилд харлаа. Тийм учраас тогтолцооны том өөрчлөлтүүдээ төсвийн хуультайгаа холбогдуулаад хамтад нь оруулж ирэхийг хичээх хэрэгтэй.

Анхан шатны тусламж, үйлчилгээний нэг иргэний санхүүжилт ер нь тэр чигээрээ бараг нийгмийн эрүүл мэндийн тусламжтай шууд холбоотой болно шүү дээ. Вакцин хийх, хүүхдүүдийг үзэх гээд дандаа нийгмийн эрүүл мэндийн тусламжтай холбоотой. Бид хуультай болчихсон. Тэр 300 гаруй тэрбум төгрөгийг нийгмийн эрүүл мэндийн тусламж руу оруулаад даатгалын сангаасаа, харин гүйцэтгэл нь эмнэлгийн тусламжийн даадаг болох чиглэлд илүү хязгаарлахгүйгээр, өрхийн эмнэлэг гэрээр нь очиж эмчилснийг нь, уламжлалт эмчилгээг нь хасахгүйгээр, хөнгөвчлөх эмчилгээний төсвийг хасахгүйгээр тэр ядарсан өвчтэй зовлонтой, хүнд хүмүүст хөнгөвчлөх тусламжийг бид хасаад байна шүү дээ. Хэмнэж байгаа гэхгүйгээр энэ тусламжийг хэрэгтэйд нь хүргэдэг байх дээр хэдүүлээ анхаарах хэрэгтэй байна. Ингээд яривал бодлогын шинж чанартай олон зүйлүүд байна. Та нарт асар их тоо баримт бүрдчихсэн, big data

үүсчихсэн. 5 жилийн гүйцэтгэлийн санхүүжилттэй холбоотой энэ тоонуудыг бүгдийг нь жагсаагаад харвал, та бүгдийн тайлангаас надад харагдаж байгаа зүйл бол аймгийн нэгдсэн эмнэлгүүдийн хүчин чадлыг нэмэгдүүлэхгүй бол гүйцэтгэлээр санхүүжилт нь хамгийн бага нэмэгдсэн л газар байгаа шүү дээ. Нэг ёсондоо гүйцэтгэж чадахгүй байна гэсэн үг. Мэргэжилтнүүдээ нэмж чадахгүй, сайн мэргэжилтэн авахгүй байна, хос бүтээл менежерүүд алга байна. Энэ болгоныг засаж сайжруулахын тулд стратегийн худалдан авалтынхаа бодлогуудаа илүү хүчтэй болгомоор байна.

Тэгэхээр бидэнд хийх зүйл их байна. Энэ тогтолцооныхоо бодлогыг бүр өөрчлөх, даатгалын сан маань даатгуулагчийнхаа төлөө ажилладаг байхгүй бол ямар нэгэн өр шир, цоорхойг нөхдөг сан байж болохгүй шүү дээ. Тийм учраас даатгуулагчийн эрх ашгийг эрсдэлээс нь хамгаалдаг байх тогтолцоогоо улам бэхжүүлж сайжруулах нь чухал байна. Би мэдээж ойлгож байна. Бид бас суралцаж байна, алдаа оноо, дутагдалтай талууд ч байна, засах хэрэгтэй зүйл ч байна. Энэ болгоныгоо засъя.

Нийгмийн эрүүл мэндийн тусламжийн тухай хуультай болсон. Эмнэлгүүдээ бие даалгаж гарга, “эмнэлгийн сайд” битгий хий гээд байгаа шүү дээ. Эрүүл мэндийн яам бодлогын яам байх ёстой. Харин гүйцэтгэлд нь чанарын шаардлага тавиад үр дүнг нь тооцох, техникийн зөвлөл энэ тэрийг нь ажиллуулж орц тооцооллыг нь зөв хийлгэх шаардлагатай байна. Дулаан, цахилгааны үнэ нэмэгдсэн. Таны бүгдийн нэмсэн гээд байгаа 360 тэрбум төгрөгийн хажууд энэ чинь хаана нь ч хүрэхгүй мөнгө шүү дээ. Яагаад ч хүрэхгүй. Эмнэлгүүд чинь ирэх намар халаалтаа, цахилгаанаа тавьж чадахгүй болох гэж байна. Ийм ноцтой зүйлүүд байгааг бас анхаараарай. Чуулганаар хэлэлцүүлж, төсөвт нэмэгдүүлэх энэ анхны нөлөөллийн ажлыг хэдүүлээ эхлүүлье гэж хэлэх гэсэн юм.

Л.Энхнасан: Баярлалаа. Г.Тэмүүлэн гишүүн үгээ хэлнэ үү.

Г.Тэмүүлэн: ЭМД-ын сантай холбогдуулаад ер нь даатгалын сангийн үндсэн даатгуулагчид буюу иргэдийн эрх ашгийг энэ оны дундаас, эсхүл оны төгсгөлд ямар нэг хүндрэл учруулахгүйгээр тухайн даатгуулагчийн хэрэгцээ, эрх ашигт нь нийцсэн үйлчилгээг олгох зарчмын хүрээнд ажиллуулах л ёстой. Тэгэхээр бидний болгоомжлоод байгаа зүйл бол энэ сан дээр ямар нэг байдлаар эрсдэл учрах вий, түүнээс шалтгаалан иргэд тусламж, үйлчилгээгээ авч чадахгүй эрх ашиг нь хөндөгддөг асуудлууд үүсэх вий л гэдэг асуудал байгаа юм. Бид уг нь төсвийнхөө хүрээнд эмнэлгүүд гүйцэтгэлээрээ санхүүжих санхүүжилтийн тогтолцоонд шилжсэн. Гэтэл бодит байдалд үүнээсээ ухарсан үйлдэл болоод байгаа нь нэг талдаа буруу байна. Магадгүй гүйцэтгэлээр санхүүжиж байгаа санхүүжилтийг та бүхэн буруу гэж үзэж байвал бид дараагийн асуудлыг ч бас ярих ёстой байх. Үр дүнд суурилсан санхүүжилтийн асуудлыг ярих ёстой байх. Ер нь цаашдаа Монгол Улсын хүн амын эрүүл мэнд сайжирсан, үр дүн гарсан гэдэг нь өөрөө чухал асуудал байгаа юм. Гэтэл тусламж, үйлчилгээ, төсвийн зардал бол үндсэндээ сүүлийн жилүүдэд бараг буруу тооцоогүй бол 40 орчим хувиар нэмэгдээд байгаа. Эсрэгээрээ иргэдийн өвчлөл нэмэгдээд, иргэдийн эрүүл мэндийн чанар нэлээн доошлоод байдаг. Урьдчилан сэргийлэх бус

эмчилгээндээ зардлаа нэмэгдүүлээд байгаа асуудлыг бид бараг 10 жилийн өмнө ярьж байсан ч бодитоор өөрчлөлт гарахгүй байна. Өвдсөн зовсон хүмүүсийн эм, тоног төхөөрөмж, эмнэлэг гээд, гэтэл нөгөө өвчтөнүүдийнх нь тоо нь нэмэгдээд л байдаг. Тэгэхээр энэ нь нэг талдаа эрүүл мэндийн салбарын бодлогын алдаа байна уу гэж хараад байна. С.Энхболд сайд та ЭМДЕГ-ын дарга байхаас өмнө өөрөө сайд байсан. Миний онцолж хэлэх гээд байгаа зүйл бол нэг талдаа бүх зүйл мөнгөөр хэмжигдэхгүй, зөв бодлого, зөв зохион байгуулалтаас бас л хамаарах асуудал байдаг. Өвчнөөс урьдчилан сэргийлэх тал дээр магадгүй иргэдийнхээ дунд эрүүл мэндийн соён гэгээрүүлэх, ухуулан таниулах ажлуудыг тогтмол хиймээр юм шиг байгаа юм.

Бид эрүүл мэндийн үйлчилгээ, чанар хүртээмж, иргэдийнхээ урьдчилан сэргийлэх үзлэг зэрэг ажлуудаар бараг эхний 5-д ордог. Сингапур л гэхэд ДНБ-ийхээ 3-аас бага хувийг зарцуулдаг. Гэтэл эсрэгээрээ 17 хувиас илүү зарцуулдаг Америк, Европоос илүү байгаа байхгүй юу. Тэгэхээр үндсэндээ зөв зохион байгуулалт, оновчтой төлөвлөлтийн асуудлууд л байна. Мэдээж энэ өөрчлөлт, шинэчлэлийг хийхэд цаг хугацаа орно. Гэхдээ та бүхэн маань бодлогын өөрчлөлтийг үе шаттайгаар хийхгүйгээр анхан шатны, тухайн ачааллыг үүрч байгаа эмнэлгүүдийнхээ санхүүжилтийг 30-аас 40 хувиар хасаад байгаа нь хааж байгаагаас ялгаагүй бодлого явагдаж байна гэж яриад байна. Энэ зөвхөн сумын, аймгийн эмнэлгийн асуудал биш шүү. Нэгдсэн, дүүргүүдийн эмнэлэг дээр ч гэсэн санхүүжилтийн асуудлууд хүндрээд байна. Эдгээр зардлуудыг өмнөх жилийн гүйцэтгэл, тооцоолол дээр суурилахгүй танаж хасаад байгаа учраас бид цалин, татвар шимтгэл, эмийнхээ өр төлбөрийг төлж, эм, эмнэлгийн хэрэгслийг авч чадахгүй байна. Үндсэндээ бидний өр нэмэгдээд байна гэдэг л асуудал ярьж байгаа юм. Бодитой тулгамдсан энэ асуудал дээр анхаараач. Эргээд гүйцэтгэлээр санхүүжихээр хуучин цаг шиг, төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засаг шиг гэж болмооргүй байна. Та нарын хүчээр тулгаад байгаа энэ шоблом, гэрээ, санхүүжилтийн төсвийн хуваарь ч тэр, нэг л их нарийвчлалтай дүн байгаад байдаг. Түүнийгээ ямар нэг байдлаар зөвшилцөж ярих, ойлгуулах асуудал байхгүй, шууд хүчээр зур.

Магадгүй нэг аймгийн, жишээ нь Баян-Өлгий аймагт хийсэн гэрээг шууд Архангай, Өвөрхангай аймагт хүчээр тулгаад, зөвхөн тухайн аймаг, эмнэлэг, даргынх нь нэр, дансны дугаарыг нь өөрчлөөд хийчхээд байгаа байхгүй юу. Ийм тулган шаардах байдлаар үндэслэлгүй мөнгөн дүнг зааж болохгүй. Эргээд иргэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авахад хүндрэл учраад байна. Үүнийг та бүхэн маань бага дээр нь, хагас жил болоогүй байхад нь анхан шат дээрээ очиж уулзаад зовлон жаргалыг нь яриач. Иргэд ч гэсэн тусламж, үйлчилгээ авч чадахгүй хүндрэлтэй байна. Та 2022 онд яг ийм асуудлыг гаргаж тавьж байсан. Би яг үүнтэй холбоотойгоор 2022 оны 7 дугаар сард Ерөнхий сайдад энэ асуулгыг тавьж байсан. Улсын Их Хурал дээр бид энэ асуудлаар ярилцаад “буруу байна” гэж үзсэн учраас хязгаарлаж, боож байсан асуудлуудыг болиулж байсан. Тиймээс үүнийг судалж үзээч. Бид магадгүй энэ даатгалын сангийн санхүүжилтийн асуудлуудыг Улсын Их Хурал дээр яриад бодлогын хандлагын өөрчлөлтүүдийг хийх агуулгыг бол.../минут дуусав./

Л.Энхнасан: Баярлалаа. Гишүүд үгээ хэлж дууслаа. Энэ асуудлыг чуулганаар хэлэлцүүлэхийг би бас дэмжиж байна. Бид ЭМД-ын тогтолцоо, шинэчлэлт, гүйцэтгэлийн санхүүжилтийн үр дүнг ярилцаж зөв эсэхийг нь иргэдэд ойлгуулах ажлыг хийх шаардлагатай гэж үзэж байна. Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар асуулгын хариуг нэгдсэн чуулганаар хэлэлцүүлж болно.

Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, Ж.Чинбүрэн нарын гишүүдээс “Эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой тулгамдаж буй асуудлын талаар асуулга хүргүүлэх тухай” Монгол Улсын Ерөнхий сайдад хандсан асуулгын хариуг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулна.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн 69,2 хувийн саналаар дэмжигдсэн тул чуулганы нэгдсэн хуралдаанд бэлдье.

Нийгмийн бодлогын байнгын хорооны өнөөдрийн хуралдаанаар хэлэлцсэн асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье.

Гишүүд, ажлын хэсэгт баярлалаа.

---oOo---

**УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН О.БАТНАЙРАМДАЛААС 2025 ОНЫ
01 ДҮГЭЭР САРЫН 07-НЫ ӨДӨР БОЛОВСРОЛЫН САЙД П.НАРАНБЯРТ
ХАНДСАН “БОЛОВСРОЛЫН ЗЭЭЛИЙН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР” АСУУЛТ-01**



Улсын Их Хурлын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 02 дугаар тогтоолоор байгуулагдсан Боловсролын зээлийн сангийн үйл ажиллагаа, журмын биелэлтэд хяналт шалгалт хийх, холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн миний бие ахлан ажиллаж байна.

Ажлын хэсгийн үйл ажиллагааны хүрээнд холбогдох мэдээллийг авах явцад дараах асуудлуудыг тодруулах шаардлагатай байх тул Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, 37 дугаар зүйлийн 37.1.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийг тус тус үндэслэн дараах асуултыг Танд тавьж байна. Үүнд:

1.Боловсролын зээлийн сангаас хэрэгжүүлж буй Монгол Улсын Ерөнхийлөгч, Монгол Улсын Ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлэг болон бусад хөтөлбөрүүдийн 2024 оны хэрэгжилт, тэтгэлэгт хамрагдах хүсэлт гаргасан болон хамрагдсан суралцагчдын зүгээс тэтгэлэгтэй холбоотой ихэвчлэн ямар асуудлаар санал, гомдол, хүсэлт гаргадаг, түүнийг хэрхэн шийдвэрлэсэн талаарх мэдээлэл болон цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар;

2.Боловсролын зээлийн сангийн эргэн төлөлтийн явц болон эргэн төлөлтийг сайжруулах хүрээнд хийгдэж буй ажил, төлөвлөгөө, хөндлөнгийн хуулийн байгууллагатай хамтран ажиллаж буй ажлын явцын талаарх мэдээлэл;

3.Дотоодын их, дээд сургуульд суралцагчдын зээл (оюутны хөгжлийн зээл)-ийн эргэн төлөлт 98 хувь, гадаадад суралцаж төгссөн оюутнуудын зээлийн эргэн төлөлт 4 хувь байна. Эргэн төлөлтийн байдал ийнхүү зөрүүтэй байхад Монголбанкны зээлийн мэдээллийн санд дотооддоо зээлээр суралцсан төгсөгчдийн зээлийн мэдээллийг бүртгэдэг боловч гадаадад зээлээр суралцсан төгсөгчдийн мэдээллийг бүртгэлжүүлэхгүй байгаа шалтгааны талаарх үндэслэл бүхий тайлбар;

4.2025 оны Төсвийн тухай хуулиар Боловсролын зээлийн сангийн нийт 158,4 тэрбум төгрөгийн батлагдсан төсвийн 33,6 тэрбум төгрөгийг зээлийн эргэн төлөлт болон бусад эх үүсвэрээс бүрдүүлэхээр төлөвлөсөн. Уг санхүүжилтийг

хэрхэн бүрдүүлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл;

5.Төрийн албан хаагчийг захиалгаар суралцуулж, чадавхжуулах бодлогыг хэрэгжүүлэхдээ Боловсролын зээлийн сангаас санхүүжүүлж буй зохицуулалт нь төрийн албыг мэргэшүүлэх ач холбогдолтой бөгөөд энэ талаар өмнө нь хэрэгжүүлсэн арга хэмжээний хүрээнд хамрагдсан төрийн албан хаагчийн тоо, сонгох шалгуурын талаарх мэдээллийг харьцуулсан байдлаар, мөн 2025 онд уг бодлогыг хэрэгжүүлэхэд төсөвлөгдсөн зардлын хэмжээг хэрхэн тооцсон талаарх төсвийн мэдээлэл;

6.Монгол Улсад нэн хэрэгцээтэй байгаа багш болон эрэлттэй бусад мэргэжлээр суралцагчдыг дэмжих хүрээнд Боловсролын зээлийн сангаас 2024 онд зарцуулсан төсөв, хөтөлбөрийн дүн, хэрэгжилтийн явц;

7.Дээрх хөтөлбөрийн хүрээнд Засгийн газраас тогтоож байгаа эрэлттэй мэргэжлийн чиглэл нь оюутан, суралцагчдын Боловсролын зээлийн сангийн санхүүжилтэнд хамрагдахад хязгаарлалт болж байгаа эсэх, тийм бол энэ асуудлыг цаашид хэрхэх талаар баримталж буй бодлого, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаарх мэдээлэл;

8.Боловсролын зээлийн сангийн сонгон шалгаруулалтын явцыг цахимжуулах үйл ажиллагааны хэрэгжилтийн талаарх мэдээлэл.

Энэхүү асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт заасан хугацаанд ирүүлэхийг Танаас хүсье.

---oOo---

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН О.БАТНАЙРАМДАЛААС БОЛОВСРОЛЫН САЙДАД ХАНДСАН “БОЛОВСРОЛЫН ЗЭЭЛИЙН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР” АСУУЛТ-01-ИЙН ХАРИУГ БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН БАЙНГЫН ХОРООНЫ 2025 ОНЫ 3 ДУГААР САРЫН 26-НЫ ӨДРИЙН ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦСЭН МЭДЭЭЛЭЛ

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны 2025 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдалаас Боловсролын сайдад хандаж “Боловсролын зээлийн сангийн үйл ажиллагааны хэрэгжилтийн талаар” тавьсан асуултын хариуг хэлэлцлээ.

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд П.Наранбаяр, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, мөн яамны Гадаад хамтын ажиллагааны газрын дарга Б.Энхбаяр, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Б.Батцэцэг, Боловсролын зээлийн сангийн захирал О.Сийлэгмаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны ажлын албаны референт Н.Монголмаа, Хяналт шалгалтын газрын референт Х.Хэрлэн, мөн газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу нар байлцав.

Ч.Ундрам: Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны 2025 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн хуралдаанд ирвэл зохих 15 гишүүнээс 9 гишүүн хүрэлцэн ирсэн тул хуралдааныг эхлүүлэе. Гишүүдэд хэлэлцэх асуудлыг танилцуулсан. Хэлэлцэх асуудалтай холбогдуулан өөр саналтай гишүүн байна уу? Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдалаас Боловсролын сайдад хандаж тавьсан асуултын хариуг Боловсролын сайд П.Наранбаяр танилцуулна.

П.Наранбаяр: Та бүхэнд энэ өдрийн мэндийг дэвшүүлэе. Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдалаас ирүүлсэн асуултын хариуг та бүхэнд танилцуулъя.

1 дүгээр асуултын тухайд:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Ерөнхийлөгчийн илгээлт-2100” хөтөлбөрийн хүрээнд 2024-2025 оны хичээлийн жилийн сонгон шалгаруулалттай холбоотой Боловсролын яаманд давхардсан тоогоор 15 өргөдөл, гомдол ирсэн байна. Эдгээр өргөдлийг судлан үзэхэд Засгийн газрын 2024 оны 102 дугаар тогтоолд заасан өрхийн 1 гишүүн хамран сургах тойргийн асуудлыг түгээмэл хөнджээ.

Монгол Улсын Ерөнхийлөгч, Монгол Улсын Ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлгийн сонгон шалгаруулалтыг Засгийн газрын 2024 оны 102 дугаар тогтоолд тодорхой тусгаж өгсөн. Боловсролын яамны харьяа Боловсролын үнэлгээний төв, Боловсролын ерөнхий газар, Боловсролын зээлийн сан, Боловсролын мэдээллийн төв гэсэн байгууллагуудын системээр дамжуулан мэдээллийг солилцож, тухайн баазад суурилан сонгон шалгаруулалтыг зохион байгуулдаг. Багш, ажилтны хүүхдийн сургалтын төлбөрийн тэтгэлгийн асуудлаар Засгийн газрын 2024 оны 103 дугаар тогтоолын 2.3.6-д заасан “тасралтгүй 15 жил ажилласан байх” тухай заалттай холбоотой гомдол түгээмэл байна.

Боловсролын зээлийн сангаар олгож буй гадаадад суралцагчдын зээл, тэтгэлгийн сонгон шалгаруулалтыг цахимжуулах ажлыг журмын шинэчлэлд тусган хэрэгжүүлнэ.

2 дугаар асуултын тухайд:

Боловсролын зээлийн сангийн зээлийн эргэн төлөлт 2024 онд нийт 14,4 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 15 хувиар өссөн. Зээлийн эргэн төлөлтийг хөтөлбөр тус бүрээр нь авч үзвэл хөнгөлөлттэй зээл 363,18 сая төгрөг буюу өнгөрсөн оноос 52 хувь, оюутны хөгжлийн зээл 11,5 сая төгрөг буюу өнгөрсөн оноос 46 хувиар тус тус өссөн бол гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдын зээл 2,4 тэрбум төгрөг төлөгдөж, өнгөрсөн оноос 43 хувиар буурсан. Зээлийн эргэн төлөлтийг сайжруулах зорилгоор 2024 оны 11 дүгээр сараас эхлэн оюутны хөгжлийн зээл, хөнгөлөлттэй зээл болон дэлхийн шилдэг их, дээд сургуульд зээлээр суралцсан иргэдэд зориулан E-Mongolia цахим системээр дамжуулан зээлийн мэдээлэл хүргэх үйлчилгээг нэвтрүүлээд байна.

Дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчдад хөнгөлөлттэй зээлийг 1992-2016 онд олгосон бөгөөд Засгийн газрын 2004 оны 22 дугаар тогтоолоор 1992-2004 оны суралцагчдын зээлийг бүрэн чөлөөлсөн. Засгийн газрын 2008 оны 178 дугаар тогтоолоор голч дүн 2,8, эзэмшсэн мэргэжлээрээ 2 болон түүнээс дээш жил ажилласан шалгуурыг хангасан төгсөгчдийг зээлээс чөлөөлж байна. Одоогоор Боловсролын зээлийн санд 2004-2016 онд хөнгөлөлттэй зээлээр суралцаж төгссөн нийт 12799 зээлдэгчдийн 14,1 тэрбум төгрөгийн зээл бүртгэлтэй байна. Зээлийн мэдээллийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсэгт заасны дагуу Монголбанкны зээлийн мэдээллийн санд мэдээлэл өгөх, авах болон гэрээ хийгдсэн огнооноос үл хамааран нөхөж илгээх боломжтой талаар магадлал, мэдээлэл ирүүлсний дагуу Зээлийн мэдээллийн санд мэдээлэл хүргүүлэх бэлтгэл ажлыг эхлүүлсэн. Зээлийн эргэн төлөлтийг сайжруулах хүрээнд 7 аймаг, 2 дүүргийн прокурорын байгууллагуудтай хамтран ажиллаж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

Оюутны хөгжлийн зээл нь 2016 оноос эхэлсэн бөгөөд эргэн төлөлтийг сайжруулах зорилгоор E-Mongolia цахим системээр дамжуулан зээлийн эргэн төлөлтийн графикийг 2025 оны 02 дугаар сараас эхлэн зээлдэгчдэд хүргэх

болон гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад 1997 оноос хойш суралцаж төгссөн бүх төгсөгчдийн зээлийн эргэн төлөлтийн хуваарийг үүсгэж Монголбанк руу зээлдэгчийн зээлийн мэдээллийг нийлүүлэх бэлтгэл ажил хангагдаж байна. 2010-2020 онд дэлхийн шилдэг их сургуульд суралцсан иргэдийн зээлийн эргэн төлөлтийг сайжруулах зорилгоор зээлийн мэдээллийг E-Mongolia цахим системээр дамжуулан 2024 оны 11 дүгээр сараас эхлэн хүргэж байна. Зээлийн сангийн хуримтлагдсан авлагыг барагдуулах чиглэлээр олон улсын сайн туршлага судлах, хамтран ажиллах, хуулийн фермийг сонгон шалгаруулах зэрэг ажлыг төлөвлөж байна.

3 дугаар асуултын тухайд:

Оюутны хөгжлийн зээлийн мэдээллийг тусгай программ дээр боловсруулан Монголбанк руу нийлүүлж байгаа боловч гадаадад суралцагчдын зээлийн мэдээллийг уг программд бүртгүүлэх тохируулга хийгдээгүй учраас мэдээлэл солилцох боломжгүй байна. Оюутны хөгжлийн зээлийн программыг ашиглан гадаадад суралцагчийн зээлийн эргэн төлөлтийн мэдээллийг боловсруулах, нийлүүлэх үйл явцад системийн хүчин чадал дутмаг байна. Одоогийн ашиглаж буй 2018 оны программ хангамж болон өгөгдлийн сан нь техникийн болон үйл ажиллагааны шаардлагыг хангахгүй байгаа нь тулгамдсан асуудал болж байна. Тиймээс гадаадад суралцагчдын зээлийн мэдээллийг цахим хэлбэрт шилжүүлэхтэй холбогдуулан Улсын бүртгэлийн газраас регистрийн дугаарын солилцоо болон авлагын мэдээллийг тулгах ажлыг зээлдэгч тус бүрээр хийж эхэлсэн.

Боловсролын зээлийн сангийн мэдээллийн системийн архитектурыг боловсруулах, удирдлага, зохион байгуулалтаар хангах ажлын хэсэг гарсан. Боловсролын сайдын 2025 оны хөтөлбөр, арга хэмжээний зардлын төсөвт сангийн цахим шилжилттэй холбоотой зардлыг санхүүжүүлэхээр тус тус тусгасан болно.

4 дүгээр асуултын тухайд:

Гадаадын болон дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид тэтгэлэг, зээл, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх 13 арга хэмжээнд нийт 158,4 тэрбум төгрөгийн төсөв батлагдсанаас улсын төсвөөс 124,4 тэрбум төгрөг, бусад эх үүсвэрээс 33,6 тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоор байна. Уг санхүүжилтийг хэрхэн бүрдүүлэх талаар гэрээний биелэлтийг дүгнэх, биелэлтэд хяналт тавих, гэрээний үүргийн биелэлттэй холбогдуулан өр, авлагыг барагдуулах зорилгоор хуулийн фермтэй хамтран ажиллана. Мөн зээлийн эргэн төлөлтийг сайжруулах хүрээнд хууль, шүүхийн байгууллагад хандах, өмнөх онуудад үүссэн зээл чөлөөлөлтийн асуудлыг тодорхой болгон эргэн төлүүлэх арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлж, 2025 онд нийт 30 тэрбум төгрөгийн зээлийн эргэн төлөлтийг төлүүлэх зорилт тавин ажиллаж байна.

5 дугаар асуултын тухайд:

Засгийн газрын 2024 оны 102 дугаар тогтоолын 4.13 дахь хэсэгт гадаадын сургалтын байгууллагад магистрын зэргийн өмнөх хэлний бэлтгэл, ахисан түвшний сургалтад суралцах төрийн албан хаагчдаас холбогдох шаардлагыг хангасан тохиолдолд тухайн байгууллага нь шалгаруулж, Боловсролын сайдын тушаалаар баталгаажуулан Боловсролын зээлийн сантай 3 талт гэрээ байгуулна. Төрийн албан хаагчдад олгох зээл, тэтгэлэг нь 2025 оноос эхлэн хэрэгжих бөгөөд тус хөтөлбөрийн хүрээнд 50 суралцагчид 3,5 тэрбум төгрөг буюу 1 суралцагчийн сургалтын төлбөрт дунджаар 20 мянган ам.доллар зарцуулахаар төлөвлөж байна. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага гадаадын сургалтын байгууллагад суралцуулах суралцагчийн тоо, боловсролын зэргийн хөтөлбөр, мэргэжлийн чиглэл, санхүүжилтийн эх үүсвэрийн мэдээллийг санд жил бүрийн 12 дугаар сарын 01-ний дотор ирүүлэхээр тогтоолд заасан.

6 дугаар асуултын тухайд:

Багшийн мэргэжлээр суралцагчдыг дэмжих хүрээнд 2024 онд 4728 суралцагчид 9,6 тэрбум төгрөг, багш, ажилтны хүүхдийн сургалтын төлбөрийн тэтгэлэгт 2 тэрбум төгрөгийн тэтгэлэг олгосон. Дотоодын сургалтын байгууллагад эрэлттэй болон тэргүүлэх мэргэжлээр суралцагчдыг дэмжих зорилгоор 5208 суралцагчдад 10,6 тэрбум буюу төгрөгийн зээл, тэтгэлэг олгосон. Элсэлтийн шалгалтыг 2024-2025 оны хичээлийн жилээс эхлэн жилд 2 удаа зохион байгуулж, 2025-2026 оны хичээлийн жилд босго оноог 490, орон нутгийн сургуулийн босго оноог 430 болгож, тус тус 10 оноогоор нэмэгдүүлэв.

Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагч ажиллангаа сурах, суралцангаа ажиллах боломжийг бүрдүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

7 дугаар асуултын тухайд:

Хөдөлгөөн засалч, хэл засалч мэргэжлээр суралцагчдын хувьд санхүүжилт нээлттэй байгаа хэдий ч тэтгэлэгт хамрагдах хүсэлт ирээгүй. Нэн эрэлттэй мэргэжлийн хувьд төгсөөд орон нутагт 3 жил, нийслэлд 5 жил ажиллах нөхцөлийг зөвшөөрөхгүй тохиолдол гарч байгаа багаас эрэлттэй мэргэжлийн суралцагчид тэтгэлэгт хамрагдах нь бага байгаа тул санхүүгийн дэмжлэгийн нөхцөлийг өөрчлөн сайжруулах чиглэлээр ажиллаж байна.

Сургалтын төлбөрийн дотоодын зээлийг тэргүүлэх, эрэлттэй мэргэжил харгалзахгүй болгох, тэтгэлгийн нөхцөлийг гэрээний үүрэгтэй холбох, Боловсролын зээлийн сангийн үйлчилгээг олон нийтэд таниулах арга хэмжээг авч хэрэгжүүлэхтэй холбоотой зардал тодорхой бус байгааг журамд шинэчлэн тусгахаар судалж байна. Баярлалаа.

Ч.Ундрам: Танилцуулга дууслаа. Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийн гишүүдийг танилцуулсан. Одоо мэдээлэлтэй холбоотой асуулт асуух гишүүд нэрээ өгнө үү. Байнгын хорооны хуралдаанаар асуултын

хариуг холбогдох албан тушаалтан 3 минутаас илүүгүй хугацаанд танилцуулах бөгөөд гишүүд 3 минутаас илүүгүй хугацаанд асуулт асууна гэсэн дэгтэй байна. Үүний дараа асуулт тавьсан гишүүн 5 минутаас илүүгүй хугацаанд үг хэлэх, асуулттай холбоотой өөр асуулт асууж болно гэж заасан байна.

Одоо асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Ш.Бямбасүрэн гишүүнээр тасалъя. С.Эрдэнэбат гишүүн асуулт асууна.

С.Эрдэнэбат: Багш нараас голчлон 1 хүүхдийн сургалтын төлбөрийг төрөөс хариуцна гээд энэ шийдвэр гарсан. Тасралтгүй 15 жил гээд байгаа. Гэтэл хүний л амьдрал, дунд нь хоёрын хооронд 1, 2 сарын, магадгүй 3 сар өвдсөн зэрэг янз бүрийн шалтгаантай байж болно. Үүнийг хэрхэн хэрэглэж байгаа вэ? Журамд нь оруулаад шийдчих боломж байхгүй юу?

Хоёрдугаарт, 30 тэрбум төгрөгийг Боловсролын зээлийн сангаас зээл авсан хүмүүсээр энэ жил төлүүлнэ гээд тавьчихсан. Одоо хэдэн хувьтай байна? Хэрэв энэ зээл төлөгдөхгүй бол тэтгэлэг авах хүүхдүүдийн тоо хасагдах, эсвэл тэтгэлгийн хэмжээ буурах эрсдэл байна уу?

Гуравдугаарт, Монголбанкны зээлийн мэдээллийн санд оруулах бэлтгэл ажил хангагдаж байгаа гэсэн. Энэ яг хэзээ орох вэ?

Дөрөвдүгээрт, гэрээний үүргээ биелүүлчихсэн хүмүүс дотор нь яваад байгаа юм. Тэтгэлэг аваад, буцаж ирээд гэрээнд заагдсан төрийн албандаа тогтвор суурьшилтай, үр бүтээл гаргаж байгаа энэ хүмүүсийн асуудлыг ер нь цаашаа яах юм бэ? Зээлийн сангийн гэрээний үүргийн дагуу хөнгөлөөд, гэрээнийх нь үүргийг дүгнээд тавихгүй маш олон хүмүүс хүлээгээд байгаа юм байна лээ. Үүнийг нь нийгмийн сүлжээгээр зээл авсан нь бараг буруу мэт хэт туйлшруулаад явчихсан, энэ хүмүүсийг дунд нь хэлмэгдүүлээд байж бас болохгүй. Тэр хүмүүс үнэхээр гэрээнийхээ үүргийг биелүүлчихсэн бол гэрээг нь дүгнээд, хаахыг нь хаагаад, харин огт гэрээнийхээ үүргийг биелүүлээгүй, монголдоо буцаж ирээгүй, төрийн байгууллагадаа ажиллаагүй хүмүүсийг, эсвэл дундаас нь сураагүй хаяад явчихсан хүмүүсийг ялгаж салгаад хариуцлага тооцох талаар ямар арга хэмжээ авч байгаа вэ?

Ч.Ундрам: Хуралдаанд Г.Хосбаяр гишүүн ирсэн байна. Ирцэд оръё. Мөн Т.Аубакир гишүүн оролцож байна.

П.Наранбаяр сайд хариулъя.

П.Наранбаяр: Баярлалаа. Энэ нарийн тоог манай Боловсролын зээлийн сангийн захирал О.Сийлэгмаа хариулж өгөхийг хүсье. Хуульдаа “тасралтгүй 15 жил” гэдэг үг орчхоод байгаа юм л даа. Үнэхээр амьдрал баян, янз бүрийн шалтгаанаар түр завсарласан хүмүүс байдаг. Бид аль болохоор л багш нартаа өгөх гэдэг. НДШ-ийг нь хараад ер нь 15 жил тасралтгүй ажилласан байна уу гэдгийг бас харж байгаа.

Нийт 34 тэрбум байхаас 14,6 тэрбум төгрөг нь буцаан төлөгдсөн байгаа. Энэ жил төсөв нэлээн танагдаад 33 тэрбум төгрөг буцааж өөрсдөө олж ав гэсэн ийм байдалтай байгаа.

Монголбанк руу явуулах мэдээллийн тухайд өнөөдрийн байдлаар 3500 орчим хүн зээл авснаас ойролцоогоор 2500 орчим нь төлөөд, суралцаад явж байгаа хүмүүс, зээлээс чөлөөлөгдсөн 1000 орчим хүн байгаа. Энэ дээр үнэхээр таны хэлдгээр суралцсан эрдэм номоо эх орондоо зориулаад, гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлсэн учраас чөлөөлөгдсөн улсууд ч бий, энэ дотор хариуцлага алдсан хүмүүс ч бий. Үүнийг ялгаж, салгах ажил явагдаж байгаа бөгөөд хариуцлага хүлээлгэхээр хүн байвал хариуцлагыг нь хүлээлгэнэ гэсэн ийм юутай байгаа. Тэгэхээр Монголбанк руу явуулах мэдээлэл үүнтэйгээ уялдаж байгаа гэдгийг хэлье. Бусад тоонуудыг манай О.Сийлэгмаа бас нөхөөд хариулчих уу?

Ч.Ундрам: 8 номерын микрофоныг өгье. О.Сийлэгмаа.

О.Сийлэгмаа: Гишүүний асуултад хариулъя. Боловсролын зээлийн сан О.Сийлэгмаа. Зээлийн эргэн төлөлтийн хуваарь 2022 оноос хойш жил болгон 30 тэрбумаар Сангийн яамнаас төлүүлэх гэж байгаа. Жил ирэх тусам бид 4-14 тэрбум хүртэл, сүүлийн 5 жил эргэн төлөлт хийгдсэн. 2024 онд 30 тэрбумыг төлөхөөс 14,6 тэрбум төгрөгийн төлөлт хийгдсэн байна.

“Тасралтгүй 15 жил” гэдэг дээр НДШ-ийн тодорхойлолтыг харж байгаад сар тасраагүй байх энэ зохицуулалтаар багшийн 15 жил, 1 хүүхдийн тэтгэлэг олгогдсон гэсэн тоо байгаа.

Ч.Ундрам: Гэрээний үүргээ гүйцэтгэчихсэн, гэрээнийхээ дагуу зээл авч сураад 5 жил ажиллачихсан яг хэдэн хүүхэд байгаа юм бэ? Эд нарыг цаашид ер нь яах юм бэ?

8 номерын микрофон өгье.

О.Сийлэгмаа: Гэрээний үүргийн биелэлттэй холбоотой тогтоолын хэрэгжилт нь 1997-2012 он хүртэл, тогтоолоор суралцсан иргэд Засгийн газраар орвол шийдвэрлэх ёстой. Гэтэл үүнээс хойш 2011 оны хуулиар Улсын Их Хурлаас журамлана гэхсэн. Улсын Их Хурлын журам гараагүй учраас энэ гэрээний хэрэгжилтийг сайд чөлөөлөх нь өөрөө эрх зүйн зохицуулалтын зөрчилтэй байгаа учраас 2024 онд чөлөөлөлт хийгдээгүй. Одоогийн байдлаар чөлөөлөгдөөгүй 1200 иргэдээс 5 жил ажиллачихсан буюу 2012 он хүртэл гэрээгээр суралцсан нийт 800 орчим иргэд байгаа.

Ч.Ундрам: Улсын Их Хурал журам гаргахгүй шүү дээ. Хууль л гаргана, эсвэл тогтоол гаргана. Тэгэхээр энэ дээр хуулийн хийдэл байгаад байна. Та бүхэн үүнийгээ яаралтай засах хэрэгтэй байна.

П.Наранбаяр сайд хариулъя.

П.Наранбаяр: Тийм ээ, яг ийм асуудал үүсээд байгаа нь үнэн. 2011 оны Дээд боловсролын санхүүжилтийн тухай хуулийн өөрчлөлтөөр Улсын Их Хурал журам гаргаж чөлөөлнө гэж заасан боловч тэр журам гараагүй. Гэрээ байгуулагдаад яваад байдаг, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлчихсэн хүмүүсийг түүний дараа чөлөөлсөн гэсэн асуудал 864 хүнд байдаг байх. 60 орчим хүн дээр үүсчээд байгаа юм.

Тэгэхээр нэгэнт журам нь гараагүй, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлсэн гэж үзээд тухайн үеийн Боловсролын сайд нар чөлөөлчихсөн энэ асуудал дээр Захиргааны ерөнхий хуулийн 48 дугаар зүйл дээр байдаг захиргааны акт сөрөг нөлөө үзүүлсэн акт уу, эерэг нөлөө үзүүлсэн акт уу гэдгийг харж, эндээс хөөн хэлэлцэх хугацаатай холбоотойгоор бас шийдвэр гаргах шаардлагатай. Үүнийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж шийдүүлнэ. Цаашдаа бид энэ зөвхөн хувь.../минут дуусав./

Ч.Ундрам: Дараагийн асуулт Ц.Мөнхтуяа гишүүн асууя.

Ц.Мөнхтуяа: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Олон жил энэ Боловсролын зээлийн сангийн булхай луйврын асуудал хөндөгдөж, яригдаж ирсэн. Гэхдээ 2 жилийн өмнө гишүүн болохоосоо өмнө энэ асуудлаар нийгэмд шүгэл үлээж гаргаж ирж, энэ асуудал руу идэвхтэй манлайлан орж байгаа залуу гишүүн, О.Батнайрамдал гишүүндээ баяр хүргэмээр байна.

2024 онд 30 тэрбум төгрөг төлөгдөхөөс 14,6 тэрбум төгрөгийг төлсөн гээд О.Сийлэгмаа дарга мэдээлэл өгч байна. Би энийг асуух гэж байсан юм.

Хоёрдугаарт, Боловсролын сайд П.Наранбаяраас асуух асуулт байна. П.Наранбаяр сайдыг Шинэ Монгол сургуулийн төлөөлөл гэж бүгд мэднэ. Ж.Галбадрах гишүүний сургууль буюу Шинэ Монгол сургуулийн “сургуулийн менежмент” гэсэн төсөл рүү 120 сургуулиас 10, 10 сая төгрөг буюу 1.2 тэрбум төгрөгийг шилжүүлсэн баримтууд нийгэмд ил болоод явж байгаа. Ер нь багш нар, сургуулиуд энэ асуудлаар надад маш их мэдээлэл өгч байгаа. П.Наранбаяр сайдаас яагаад ийм болчимгүй юм хийчхэв ээ гэж асуумаар байна. Энэ бол цэвэр авлига, ашиг сонирхлын зөрчил шүү дээ. Төрийн өндөр албан тушаалтан тангараг өргөхдөө авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байна гэсэн тангаргаасаа няцаж ашиг, сонирхлын зөрчил гаргаад байна. Шинэ Монгол сургуулийн нөхдүүд улсын төсвөөр тоглож байгаа юм биш үү?

Тэр 10 сая төгрөгийн төсөл нь үнэхээр амжилттай сайхан юм уу гээд асуухаар багш нар толгой сэгсэрч байна. Энэ зүгээр л улсын мөнгийг өөрийнхөө сургууль руу шилжүүлээд хоорондоо улсын мөнгөөр тоглож байгаа л ажил гэж би ч хэлээд байгаа юм биш, олон сургуулиас гомдол ирж байна. Энэ дээр П.Наранбаяр сайд байр сууриа илэрхийлж, олон түмэнд үгээ хүргэмээр байна. Энэ бол цэвэр ашиг сонирхлын зөрчил, гэмт хэрэг.

Дараагийн асуудал, “Эрин” сургуулийг сүр дуулиантайгаар улсын сургууль болголоо гэж зарласан. Би буруутгаж байгаа юм биш. Гэхдээ яг

хэдэн төгрөгөөр, хэнтэй, хэний зөвшөөрлөөр, ямар гэрээ хэлэлцээр хийж энэ сургуулийг авсан бэ? Жишээ нь, 2025 оны төсөвт энэ сургуулийг хэдэн төгрөгөөр аль төсөв дээр тавьсан нь тодорхойгүй. Хууль бус, далдуур хийж байгаа ажил чинь үнэхээр таалагдахгүй байна. П.Наранбаяр сайд энэ 2 асуултад хариулж өг.

Ч.Ундрам: П.Наранбаяр сайд хариулъя.

П.Наранбаяр: Тэгэхээр нэг зүйлийг тайлбарлах хэрэгтэй байна. Би Шинэ Монгол сургуулийн төлөөлөл биш. Би монголын боловсролыг, сургуулиудыг сайн удирдлагатай, сайн менежменттэй, сайн чанартай сургалт явуулах зорилгоор л ажлаа хийж байгаа хүн. Та ингэж хүн гүтгэж болохгүй. Энэ үгээ буцааж авахыг би шаардаж байна.

Хоёрдугаарт, сургуулийн менежментийг сайжруулах зорилгоор гурван ч төсөл энэ яамнаас хэрэгжсэн байдаг юм. Азийн хөгжлийн банк, Нийслэлийн Боловсролын газартай хамтраад сургуулиудыг 3 ангилж, 1, 2, 3 дугаар зэрэглэлд оруулаад явж байгаа, 2 жишээ нь энэ 2 төсөл байна. Гурав дахь нь таны дурдсан төсөл. Энэ төсөл төвийн бүсийн, Сэлэнгэ, Дархан, тэгээд нийслэлийн сургуулиуд нийлээд 120 сургууль. Төрийн өмчийн 700 гаруй сургуулийн 120 дээр нь хэрэгжээд явж байгаа нь үнэн. Эдгээр сургуулиудын өөрсдийнх нь тавьсан хүсэлтийн дагуу л явж байгаа төсөл. 300 гаруй сургууль хүсэлтээ өгснөөс 120 сонгогдсон гэж би сонссон. Энэ дээр сургуулийн хүүхдүүдтэй багш нар нь багаар ажилладаг болж, хүүхдийг хөгжүүлэх хичээлээс гадуурх дугуйлан секцийг хөгжүүлэх зэрэг янз бүрийн ажил хийгдэж байгаа гэж би дуулсан. Доторх асуудлыг нь та хэрэгжүүлж байгаа тэр байгууллагаас нь асуух хэрэгтэй. Нэг сургууль ч гэсэн сайн болоосой гэсэн ийм л төсөл гэдгийг би танд хэлье.

“Эрин” сургуультай холбоотой асуудалд БГД-ийн 29 дүгээр хорооны нутаг дэвсгэр, Гурвалжингийн гүүрний цаана байрладаг нэг ээлжиндээ 960 хүүхэд авч болох олон улсын, Япон маягийн стандартад нийцсэн 10 гаруй мянган метр квадрат талбайтай, гаднаа хөл бөмбөгийн талбайтай, 1 урлагийн заал, 2 ч сагсны талбайтай ийм барилгыг худалдан авах үйл ажиллагаа явагдсан. Энэ санхүүгийн түрээс. Энд нуусан юм байхгүй ил тод байгаа. Та ийм хариуцлагагүй ярьж болохгүй. Ил тод хийгдсэн ажил. Энэ дээр хотын дарга Х.Нямбаатар, яг тэр тойргоос сонгогдсон гишүүн Х.Ганхуяг нартай л та ярьж доторх нарийн юмыг нь асуу. Боловсролын яам тэр байгууллагатай нь нэлээн сайн хэлцэл хийсэн. Эхлээд маш өндөр үнэлгээтэй явсан. 3 жилд хувааж төлөхөөр эхний санхүүжилтийг нь санхүүгийн түрээсийн хэсэг дээр Х.Ганхуяг гишүүн өөрөө хөөцөлдөж оруулж ирсэн шүү дээ. Ийм хэмжээний сургуулийг бид авч, түрээснийх нь, санхүүгийн түрээснийх нь энэ зардлыг нь төсөв дээр тавиулж байгаа юм.

Хариултын минут нэмэх билүү?

Ч.Ундрам: Энэ Эрин гээд сургуулийг төрд авах шийдвэр нь Засгийн газрын тогтоолоор авсан юм уу? Яг ямар хууль, эрх зүйн хүрээнд худалдан авах ажиллагаа нь явагдсан юм бэ? П.Наранбаяр сайд хариулаарай.

П.Наранбаяр: Тэгэхээр энэ дээр нууц юм байхгүй шүү. Х.Ганхуяг гишүүн бас ороод ирлээ. Тэнд 1300 гаруй хүүхэд сурч байна. Өмнө нь хувийн сургууль байхдаа 200 гаруйхан хүүхэд сурдаг байсан. Хүүхдүүдийн эрх маш их зөрчигдөж, ээлжийн коэффициент нь 3 руу орчих гээд байдаг асуудал эрс сайжирч эхэлсэн. Бид цаашдаа санхүүгийн түрээсээр хийх ажлыг эрчимжүүлснээр төр өөрөө цагаа ч хэмнэнэ, хувийн хэвшилтэйгээ ч хамтран ажиллана. Бид Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр оруулж байгаа тогтоолд энэ “санхүүгийн түрээс” гэсэн үгийг оруулсан байгаа. Тэгэхээр хаанаас юу дуулсан юм, ийм асуудлаар ингэж хариуцлагагүй мэдэгдэл хийхгүй байхыг би танаас хүсэж байна. Танаар дандаа ингэж хэлүүлнэ гэж юу байдаг юм. Миний бүх зүйл ил тод байгаа.

Ч.Ундрам: Хасуурын Ганхуяг гишүүн энэ Эрин сургуультай холбоотой асуудлаар мэдээлэл өгье.

Х.Ганхуяг: Ямар асуудал үүсээд ингэж яриад байгааг би сайн ойлгохгүй байна л даа. Үндсэндээ Улаанбаатар хотын хувьд түгжрэл номер 1 асуудал болсон. Тийм учраас бид 20 минутын хот гээд хууль хүртэл баталлаа. 20 минут гэдэг учир нь бид зөвхөн зам барих биш, Үндсэн хуулиараа бид хүлээсэн үүргээ биелүүлэх ёстой юм. Хүүхдүүдийн сурах эрхийг нь өгөх ёстой. Тэр нь юу вэ гэвэл Улаанбаатар хот, би БГД-т ч хэлье, бусад дүүргүүдэд ч хэлье. Манайд 960 хүүхдийн сургуульд 6500 хүүхэд явж байна шүү дээ. Яагаад гэвэл шинээр байгуулсан хотхонд барих ёстой сургуулиа бариагүйгээс, хуучин сургуулийнхаа хажуу бөөрөнд нь, эсхүл хөл бөмбөгийн талбайг нь байхгүй болгоод л өргөтгөл нэмээд явчихсан. Манай БГД-ийн ихэнх сургууль тийм байна. Өргөтгөлөөр асуудал шийдэхээр түгжрэл нэмэгддэг. Өглөө, орой болгон хүүхдээ хүргэж өгөх асуудал үүсдэг.

Бидний хийх ёстой ажил бол гэрт нь ойрхон сургууль, цэцэрлэгийг нь шийдэж өгөх ёстой юм. 2022 онд би боловсролын салбарын төсвийн ажлын хэсгийн ахлагчаар ажиллаж, сугалааны цэцэрлэг гэдэг асуудлыг байхгүй болгосон юм. Түрээслэхийг нь түрээслээд, төр, хувийн хэвшлийн түншлэлээр ажиллуулахыг нь ажиллуулснаар цэцэрлэгийн асуудлыг 100 хувь шийдсэн.

Өнөөдөр Улаанбаатар хотод тулгамдаж үлдээд байгаа хамгийн том асуудал бол сургуулийн асуудал байгаа. Яармагт очвол та нар нэг ч төрийн сургууль олохгүй. Хан-Уул руу яваад үз. Боломжтой газар нь хувийн хэвшил барьчихсан байвал түрээсээр, санхүүгийн түрээсээр, төр, хувийн хэвшлийн түншлэлээр гэх зэргээр сургуулийн асуудлыг шийдэхгүй бол бид хэзээ ч шийдэж чадахгүй. Дандаа хөрөнгө оруулалтаар шийднэ гэж байхгүй. Нэг сургууль барихын тулд хамгийн багадаа 3-4 жил ордог. Барьж байх явцад төсвийн өртөг нь нэмэгдээд явчихдаг. Харин ч П.Наранбаяр сайд, Х.Нямбаатар дарга бидний хийсэн энэ ажил төсөвт асар их хэмжээний хэмнэлттэй шүү. Одоо яриад байгаа тэр Эрин хороололд нийтдээ 3000 хүүхэд байгаа. Бүгдээрээ нэг бол тэр том том замыг алгасаж СХД-ийн сургуульд ордог, тэндээ багтахгүй бол наашаа 10 дугаар хорооллын сургууль руу өглөө, орой бүр явдаг. Тэнд нь бас ачааллаа дийлэхээ больчихсон ийм л нөхцөл байдалд байгаа юм.

Өнөөдөр сургуульд, хүүхдүүдэд мөнгө зарахаас та нар ерөөсөө эмээж болохгүй шүү. Бид энэ төсвөөр Улаанбаатар хотод зам барих ёстой, метро барих ёстой. Гэхдээ үүний зэрэгцээ нийгмийн үйлчилгээг бид хамтад нь өгч байх ёстой, ойртуулж өгөх ёстой юм. Хамгийн сайн сургууль бол гэрт ойрхон сургууль шүү. Тэр гэрт ойрхон сургуульд олон улсын стандартын дагуу хөрөнгө оруулалтыг нь хийдэг, багш нарыг нь хөгжүүлдэг, шаардлагатай компьютер цахимын юмнуудыг нь хийж өгдөг. Ингэж байж л монголын хүүхдүүд энэ .../минут дуусав./

Ч.Ундрам: Дараагийн асуулт Ш.Бямбасүрэн гишүүн асууя.

Ш.Бямбасүрэн: Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе. Хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой юм асууя. Манай улсад хэрэгжүүлж ирсэн энэ олон сангууд ер ач холбогдол, зорилгын хувьд маш зөв зүйтэй сангууд байгаа юм. Гол нь хэрэгжүүлэх явцдаа дүрэм, журмаа зөрчсөн, ашиг сонирхол гаргаснаас сангууд өнөөдөр нэр хүндгүй болчихоод байгаа юм. Боловсролын зээлийн сан бол үнэхээр Монгол Улсад туйлын хэрэгтэй, ирээдүйд бид боловсон хүчнээ бэлдэхэд үнэхээр чухал ач холбогдолтой сан юм. Гэтэл өнгөрсөн хугацаанд явж ирсэн юмаа харахаар үнэхээр хүнд байна л даа. Тэгэхээр бид яаралтай засаж сайжруулмаар байна.

Засгийн газрын 103 дугаар тогтоол дээр байгаа “тасралтгүй 15 жил” гэдэг заалтыг П.Наранбаяр сайд та яаралтай байхгүй болгомоор байна. Засгийн газрын тогтоол учраас та өөрөө Засгийн газрын хуралдаанд оруулаад засчих боломжтой зүйл байна. Энийг ер нь хэзээ хийх вэ?

Монголбанкны зээлдэгчдийн зээлийн мэдээллийг нийлүүлэх бэлтгэл ажил хангагдаж байна гэж байна. Энэ хэзээ дуусах вэ? Бид хийх ажлаа хугацаатай ярьдаг болмоор байна.

Ч.Ундрам: П.Наранбаяр сайд хариулья.

П.Наранбаяр: Баярлалаа. Тэгэхээр би андуураагүй бол “тасралтгүй” гэдэг үг Боловсролын ерөнхий хууль дээрээ байгаа. Тийм ээ. Хуульдаа хатуу заачихсан учраас хуулиа өөрчлөхөөс нааш боломжгүй л болчихоод байгаа юм. Аль болохоор л уян хатан байгаасай гэж би хувь хүнийхээ хувьд хүсэж байгаа юм.

Монголбанк руу явуулах мэдээллийн тухайд нэлээн нягтлах шаардлагатай байгаа. Түрүүн миний хэлсэнчлэн чөлөөлсөн тушаалуудыг захиргааны актыг нь хувьд хэрхэн үзэх вэ гэдэг хуульчийн дүгнэлтүүд гарсан байгаа. Хүчинтэй, хөөн хэлэлцэх хугацааны асуудал ч байгаа. Энэ асуудлуудыг бид Засгийн газраар оруулж хэлэлцээд, та бүхэнтэй бас ярилцаж шийдсэний дараа л үүргээ биелүүлсэн, биелүүлээгүй гэдгийг ялгаж салгах боломж гарна гэж бодож байна. Тэгэхээр энэ асуудлыг бид энэ улиралдаа багтаагаад ер нь хийчих боломжтой болов уу гэж бодож байна.

Ч.Ундрэм: Төрийн өмчийн сургуульд тасралтгүй 15 жил багшилж байгаа багшийн 1 хүүхдийг төрийн өмчийн их сургуульд үнэ төлбөргүй сургана гэсэн заалтыг манай гишүүд яриад байгаа. С.Эрдэнэбат гишүүн, Ц.Мөнхтуяа гишүүн ч гэсэн ярьдаг. Ш.Бямбасүрэн гишүүн та хэд Улсын Их Хурлын гишүүнийхээ бүрэн эрхийн хүрээнд хууль санаачлаад өөрчлөлт оруулж болно. Энэ бол бидний засах ёстой зүйл гэж бодож байна. Удахгүй өргөн мэдүүлэх байх. Аан за, D-Parliament.mn дээр байрлуулаад санал авч байгаа юм байна шүү. Тэгэхээр манай багш нар D-Parliament цахим хуудас руу ороод Боловсролын багц хуультай холбоотой санал, хүсэлтээ цахимаар өгөөд, үүний дагуу бид хуулиа хэлэлцээд явна гэж хэлмээр байна.

Дараагийн асуултыг О.Саранчулуун гишүүн асууя.

О.Саранчулуун: 5 асуудлыг хөндөж асуумаар байна. Боловсролын зээлийн сангаас хөдөлгөөн засалч, хөдөлмөр засалч, хэл засалч гээд мэргэжилтнүүдийг дэмжихээр болж байгаа ч хүсэлт ирээгүй гэж байна. Яагаад гэдэг асуудлыг судалж, суралцагчдыг нэмэгдүүлэх шийдлээ олсон уу?

Хоёрдугаарт, ер нь хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй ажиллах бол мэргэжил шүү дээ. Янз бүрийн өвчин эмгэг, осол, гэмтлээс болоод өөрийгөө илэрхийлж чадахгүй, эргэж нийгмийн харилцаанд орж чадахгүй, алдагдсан чадварыг нь эргэн сэргээх ийм л мэргэжилтнүүд байдаг. Тэгэхээр энэ ядарсан хүмүүстэй ажилладаг хамгийн сайн мэргэжилтнүүд бол тэдний эцэг, эх л байдаг. Тэгэхээр ээж, аавуудыг 2 дахь удаагаа суралцуулах боломж байна уу гэдгийг дахиж асуумаар байна. Энд анх удаа сурч байгаа гээд, хоёрт эдийн засгийн хувьд өндөр үр өгөөжтэй тийм мэргэжилтнүүдийг гэгчихсэн байгаа. Гэтэл нийгмийн эмзэг бүлэгт ажиллах мэргэжилтнээ бэлдэхгүй бол бид энэ хүмүүсээ сэргээж авч чадахгүй, халамжийн мөнгөө ярьсаар л байх болно.

Энэ асуудлыг үргэлжлүүлээд протезын мэргэжилтнүүдийг асуумаар байна. Монгол Улсад өнөөдөр хиймэл гар, хөл хийдэг протезын мэргэжилтэн 2 л байгаа. Нэг нь бараг тэтгэвэртээ гарч байгаа байх. Гэтэл жил болгон сахрын өвчин, ослоос болж зөндөө олон хүмүүс хөлгүй, гаргүй болж байхад хүний нөөц шаардлагатай ийм мэргэжилтнүүдээ дэмжих ямар шийдлүүд байна вэ?

Дараагийн асуудал, 2 дахь мэргэжлээр суралцах шийдвэр гаргаад, болно гээд хэдэн ээжүүд орсон. Одоогийн байдлаар 26 хүн материалаа өгснөөс 7 ээж хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асрахын хажуугаар давхар өөр бусад хүний хүүхдэд тусалдаг мэргэжилтэн болохоор өнөөдөр сурч байгаа. Энэ хүмүүсийн төлбөрийг нэгэнт болно гэж авчхаад, эргүүлээд нөхөж төлөөд өгөх боломж байдаггүй юм уу? Журмаар биш, төсөв нь байвал тушаалаар ч гэдэг юм уу ямар шийдэл байх вэ? Ээжүүд маань энийг заавал дуулгаж өгөөрэй гэж хэлсэн юм.

Дараагийн асуудал, багш гэдэгт ер нь ЕБС-ийн болон МСҮТ-ийн багш 2-ыг л дурдаад байгаа. Тэгэхээр их сургуулийн багш нар багш биш юм уу? Багшийн хүүхэд гэдэгт их сургуулийн багш нарын хүүхэд орж байгаа юу гэдгийг лавлаж асууя. Баярлалаа.

Ч.Ундрам: П.Наранбаяр сайд хариульъя.

П.Наранбаяр: Баярлалаа. Ер нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд тусалдаг, энэ чиглэлээр хамгийн сайн сурдаг хүмүүс бол эцэг, эх нь өөрсдөө юм байна гэдгийг уулзаад, нүдээр үзээд явахаар үнэхээр өөрөө зовлонг нь сайн ойлгодог, илүү сайн мэдэрдэг учраас туслах, энэ мэргэжил эзэмших хүсэл эрмэлзэл ч өндөр байдаг. Би хэд хэдэн эцэг, эхтэй уулзахад ярьж байсан. Боломж нь байгаад байхад ирэхгүй байгаа нь мэдээлэл сайн хүрэхгүй байгаа магадлал байна. Тийм ч учраас бид цаашдаа энэ мэргэжлийн талаарх зөв ойлголтыг хүмүүстээ хүргэх, мэдээллээ нэмэгдүүлэх шаардлагатай гэж бодож байна. Ер нь энэ протезын мэргэжилтэн гэдэг юм уу, ийм хүмүүсийг дэмжсэн сургалт руу бид онцгой анхааръя. Монгол Улсын хэмжээнд 2-хон байна, нэг нь тэтгэвэртээ суух гэж байна гэхээр ийм хүн зайлшгүй шаардлагатай болно. Тэр төлбөр нөхөж олгох тал дээр бид судалж үзье. Тэгэхдээ энд шууд хариулж арай л болохооргүй юм байна. Нэгэнт болоод явчихсан харилцаа учраас төлбөрийг нь нөхөж олгох талаар журамд одоогоор байхгүй.

15 жил багшилж байгаа их сургуулийн багш ч гэсэн орж болох уу гэдэг дээр хуулиараа СӨБ болон ерөнхий боловсролын багш гээд заачихсан. Мэдээж таны хэлдэг үнэн, багш хүн хаана ч багшилсан багш л хүн. Гэхдээ хуулиараа СӨБ болон ЕБС гээд орчихсон байгаа.

Ч.Ундрам: О.Сийлэгмаа дарга аа, нэлээн нарийн тоо баримт асуусан. Яг хэдэн хүн хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй ажиллах мэргэжилд өргөдөл өгч, хэд нь тэнцээд явж байгаа вэ? 8 номерын микрофон.

О.Сийлэгмаа: Гишүүний асуултад хариульъя. Нэгдүгээрт, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд мэргэжил олгох сургалт, ном, сэтгэл зүйч, хоол зүйч гээд эдгээр мэргэжлүүдээр гадаад дотоодод суралцах боломж нь одоогийн 102 дугаар тогтоолоор нээлттэй байгаа. Дотоодын зөвхөн сэтгэл судлалын мэргэжлээр цөөхөн хүсэлт ирж 2024 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр олгосон байгаа. Энэ чиглэлд зарим эрэлттэй мэргэжлээр 112 хүнд олгосон байгаа.

Хоёрдугаарт, багш мэргэжлийн тухайд Боловсролын ерөнхий хуулиар төрийн өмчийн ерөнхий боловсрол болон тусгай мэргэжлийн сургууль, СӨБ-ын багш нар гээд заачихсан учраас их, дээд сургуулийн багшийн “1 хүүхдий”г, “15 жил” гэдэг заалт хэрэгжихгүй байгаа. Эрэлттэй, протезын мэргэжил гэдэг дээр Боловсролын яамны Дээд боловсролын газраас судалгаа хийсэн. Монгол Улсад хиймэл эрхтэн хийх нийт 70 мэргэжилтний хэрэгцээ байгаа ч яг аль нэг сургууль дээр хөтөлбөр хэрэгжүүлэх буюу хөтөлбөрт элсүүлээд суралцуулахад хэрэгжих боломжгүй байгаа учраас одоогийн байдлаар гадаадад суралцах боломжийг нь эрэлттэй, тэргүүлэх мэргэжлийн жагсаалтыг оруулах байдлаар санал тусгачихсан байгаа. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд сүүлийн 5 жилд олгосон санхүүжилт гэвэл нийт 2917 иргэнд 5,4 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон байгаа. Үүнээс 2024 онд 548 иргэнд 1 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон.

Ч.Ундрэм: Т.Аубакир гишүүн асуултаа асууя.

Т.Аубакир: Баярлалаа. Би энэ Байнгын хорооны гишүүн биш. Улсын Их Хурлын гишүүнийхээ бүрэн эрхийнхээ хүрээнд Байнгын хорооны хуралдаанд салбартай холбоотой асуудлаар П.Наранбаяр сайдаас асуух асуулт байна. Багш нар асуугаад өгөөч гэдэг юм.

Хувийн сургуульд ажилласан жилийг улсын сургуульд ажилласан жилтэй адилтгаж, эсхүл ижил түвшинд авч үздэггүйгээс дараа нь улсын сургуульд ажиллахаар хувийн сургуульд багшилсан 10 гаруй жил тоологддоггүй бололтой. Үүнийг асууж, нэг тийш нь шийдэж өгөөч гэсэн хүсэлтийг иргэд, салбарынхантай уулзахад хэлсэн юм.

Хоёрдугаарт, Улсын Их Хурлын гишүүд бүрэн эрхийнхээ хүрээнд сонгогдсон тойргийнхоо боловсролын салбарын аж ахуйн чанартай асуудлуудад анхаарал хандуулж явдаг. Сургууль, цэцэрлэгийн аж ахуйн чанартай, хөрөнгө оруулалт, хүртээмжийн асуудлыг Улсын Их Хуралд санал дэвшүүлээд, тойргийнхоо хүрээнд шийдээд явж байгаа. П.Наранбаяр сайдыг ажиглаад байхад сайд болсноосоо хойш боловсролын салбарыг улс төржүүлж байна. Аж ахуйн чанартай ажлыг чинь Улсын Их Хурлын гишүүд хийгээд өгч байгаа. Сая Х.Ганхуяг гишүүн ч гэсэн тойргийнхоо асуудлыг хэлээд гарлаа. Боловсролын салбар үндсэндээ ХҮН намын хүний нөөцийн газар шиг болсон шүү. Сая бид тойрог дээрээ сар орчим ажиллаад ирсэн. Боловсролын салбар чинь бужигначихсан байна шүү дээ. Та өглөө Засгийн газрын хурлын дараа мэдээлэл хийж байсан. Наадах чинь хариуцлагатай албан мэдээлэл биш байна гэдгийг би хариуцлагатайгаар хэлчихье. Таны томилсон хүмүүс чинь сургууль, цэцэрлэгийн захирал дээр очоод ХҮН намын үнэмлэхийг ав, үгүй бол ажлаа өг гэсэн байна. Энэ нууц биш шүү. Би хариуцлагатай Улсын Их Хурлын гишүүнийхээ хувьд энэ асуудлыг өмнө нь тантай ярьж байсан. Америкийг та бүхэн харж байгаа байх, Ерөнхийлөгчөөсөө эхлээд боловсролын салбартаа ач холбогдол өгөөд эхэлчихлээ. Хятадын тухайд хэдэн мянга, хэдэн зуун жилээр боловсролынхоо салбарт анхаараад ирсэн. Таныг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайд болоход “намаа бэхжүүл” гэж энэ салбарыг өгөөгүй байлтай. Тийм учраас энэ боловсролын салбарыг цаашдаа ийм байдлаар үргэлжлүүлээд байх уу? Аж ахуйн чанартай ажлыг чинь Улсын Их Хурлын гишүүд танаар заалгахгүй хийчихнэ. Та энд ирснээрээ Монгол Улсын боловсролын чанар, ирээдүй болсон хүүхдүүдийн чанартай боловсролд санаа зовох ёстой болохоос ХҮН намыг бэхжүүлэх талаар бодож ажиллах ёсгүй. Та удахгүй хамтарсан Засгаас гарна гэдгээ маш сайн мэдэж байгаа. Жаргал байгаа цагт жаргалын бага амттай гэдэг юм. Байгаа дээрээ жаргаад, намаа бэхжүүлээд авчихъя гэж бодож байгаа юм уу? Багш нар чинь бужигначихсан байна. Энэ.../минут дуусав./

Ч.Ундрэм: П.Наранбаяр сайд хариулья.

П.Наранбаяр: Төрд ажилласан, улсад ажилласан жил гээд яригдаж байгаа. Улсад ажилласан жил гэдгийг та өөрөө ч мэдэж байгаа, ямар нэгэн ялгаварлал байхгүй. Харин Боловсролын ерөнхий хуульд “хувийн хэвшилд

ажилласан бол” гэсэн нэлээн ялгавартай заалт байдаг, түүнийг та хөндөж байх шиг байна. Жишээлбэл, уг хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.6 дахь заалтад “төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежид 15-аас доошгүй жил тасралтгүй ажилласан багш, ажилтны нэг хүүхдийг тэргүүлэх, эрэлттэй мэргэжлээр төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагад үнэ төлбөргүй, хөнгөлөлттэй нөхцөлөөр суралцуулах...” зэрэг заалтууд олон байдаг. Энэ дээр ялгаварлал үүссэн гэдэг шүүмжлэл байдгийг хүлээн зөвшөөрнө. Түүрүүн “тасралтгүй” гэдэг үгийг ч гэсэн ер нь авч хаях нь зүйтэй гэж ярьж байна. Аль салбарт ажилласан нь хамаагүй багш нарын нийгмийн баталгааг олгохдоо ялгаварлах нь зохимжгүй байна гэсэн ийм дуу хоолой байдгийг бас та хэллээ.

Боловсролын салбарт улс төржиж байгаа эсэх, Баян-Өлгий аймагт улс төржиж байгаа эсэх асуудлыг та бас яриад байна. Ажил урагшаа явах ёстой. Баян-Өлгий аймгийн өнөөдрийн элсэлтийн шалгалтын дундаж оноо өсөх, цаашдаа тэнд болохгүй байгаа асуудлууд нь шийдвэрлэгдэх ийм л шаардлагатай гэж үзэж байгаа болохоос би тэнд улс төржүүлэх сонирхол байхгүй, тийм юм байхгүй. Түүний зэрэгцээ хос хэлний хөтөлбөр боловсруулж тэнд хурдан нэвтрүүлэх, Монгол хэл заах явдлыг дэмжих, Казах хэлээр, Тува хэлээр боловсрол эзэмшихийг дэмжих зэрэг бидний өмнө тулгамдсан асуудлууд олон байгаа. Энэ бүхнийг шийдвэрлэхийн тулд бид урагшаагаа явах ёстой. Бид, ХҮН нам энд ирээд Засаг барилцаад жаргаад байгаа юм байхгүй, ачаа л үүрэлцэж байна. Бид ачаагаа үүрэлцэхдээ боловсролын салбарыг сайжруулах, чанарыг нь дээшлүүлэхийн төлөө л явж байгаа. Миний зүгээс ХҮН намын үнэмлэх харж хүнийг ажилд томилсон явдал байхгүй. Баярлалаа.

Ч.Ундрам: Г.Хосбаяр гишүүн асуулт асууя. Дэгийн хуулиараа асуулга дээр тодруулга байхгүй.

Г.Хосбаяр: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Малчны тухай хууль 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн. Энэ хуульд заасан малчнаар 10-аас доошгүй жил тасралтгүй ажилласан малчны 1 хүүхдийг мал аж ахуйн тэжээл, бэлчээр судлал чиглэлийн мэргэжлээр төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагад үнэ төлбөргүй суралцуулах заалт хэрэгжээд эхэлчихсэн. Тэгэхээр энд суралцах хүүхдүүдийн сургалтын төлбөрийн эх үүсвэр Боловсролын зээлийн сан дээр байдаг уу, яг хаана байна вэ?

01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш хөтөлбөрт хамрагдсан, энэ хуулийн хэрэгжилттэй холбоотой ажил хэр урагшилж байна вэ? Цаашдаа ер нь дэмжлэг авах уу? Малчид нэлээн асуугаад байгаа энэ асуудлаар хариулт өгнө үү.

Ч.Ундрам: П.Наранбаяр сайд хариулъя.

П.Наранбаяр: Малчныг дэмжих чиглэлийн энэ заалт хэрэгжинэ. Боловсролын зээлийн санд эх үүсвэр тусаад орж байгаа. Энэ намрын элсэлтээс эхлээд үнэ төлбөргүй мал аж ахуйн тэжээл, бэлчээр судлалын чиглэлээр суралцах боломжоор хангагдана. Түүнчлэн бид журмынхаа шинэчлэл дээр

үүнийг оруулж байгаа болохоор 2025-2026 оны хичээлийн жилд бүрэн тусаад явах боломжтой. Баярлалаа.

Ч.Ундрам: Гишүүд асуулт асууж дууссан учраас асуулт тавьсан гишүүн О.Батнайрамдал 5 минут үг хэлнэ.

О.Батнайрамдал: Баярлалаа. Боловсролын зээлийн сан, энэ сан дотор маш олон булхай олон жил ужгирч явсан. Энэ асуудлыг гаргаж ирээд яг 2 жил болж байна. 2 жилийн өмнөх 3 дугаар сард үүнийг гаргаж ирснээр олон нийтэд хүрч, тэдний бухимдлыг маш их гаргаж байсан. Боловсролын зээлийн сан нь татвар төлөгчдийн мөнгөөр санхүүжиж байгаа энэ 24 тусгай сангийн магадгүй хамгийн үнэ цэнтэй хөрөнгө оруулалт хийдэг сан нь байх гэж би хувьдаа боддог. Үүнтэй олон хүн санал нэгдэх байх. Оюутан, залуучууддаа татвар төлөгчдийн мөнгөөр хөрөнгө оруулалт хийгээд, эргэж өндөр боловсролтой иргэн болоод эх орондоо хувь нэмрээ оруулахад нь гүүр болдог энэ боломж дандаа л Боловсролын зээлийн сан байж ирсэн. Ийм зорилготойгоор анх 1992 онд байгуулагдаж байсан түүхтэй.

Энэ 30 жилийн хугацаанд бүгдийг тооцвол бараг 1 их наяд гаруй төгрөгийг буюу татвар төлөгчдийн мөнгийг санхүүгийн дэмжлэг болгож зээл, тэтгэлэг, буцалтгүй тусламж хэлбэрээр олгосон. Харамсалтай нь энэ их мөнгөний хуваарилалт дандаа шударга бус, ил тод бусаар дарга цэрэг нарын хүүхдүүд авсан, ардын хүүхдэд очдоггүй гэсэн ийм л жишиг явж ирсэн. Өнөөдөр ч гэсэн Боловсролын зээлийн сангийн асуудал гаргаж ирээд 2 жил болж байхад дорвитой шийдэл гарч шийдэгдсэн үү гэвэл асуултын тэмдэгтэй байсаар л байна. Эргэн төлөлт нь 98 хувьтай. Оюутан хөгжлийн зээлээр зээл авсан сурагчид эргэн төлөлтөө маш сайн хийдэг. Хэрвээ эргэн төлөхгүй бол дипломыг нь хураадаг. Монголбанкны зээлийн мэдээллийн санд сүүлийн 9 жил орсоор ирсэн. Өнөөдөр Боловсролын зээлийн сан дээр 15 гаруй мянган диплом хураалттай байгаа. Хэн ч ирж авдаггүй, тоодоггүй, хаясан, архивлагдсан байдаг. Гэтэл гадаадад сургуульд явахад санхүүгийн дэмжлэг болгож өгсөн 2500 гаруй хүүхдийн 360 орчим тэрбум төгрөгийн эргэн төлөлт 4 хувь ч хүрэхгүй л дүнтэй байна. Сая сайдын үгэнд дурдагдсан 14 орчим тэрбум төгрөг гэдэг чинь сүүлийн 30 жилийн хугацаанд төлөгдсөн 14 тэрбум шүү дээ. 2024 оныг аваад үзвэл 2.6 тэрбум л төлөгдсөн байгаа нь дэндүү чамлалттай байна.

Бид энэ 360 тэрбум төгрөгийг хэзээ эргэн төлөгдөнө гэж хүлээх вэ? Эргэн төлөгдөхгүй бол Монголбанкны саарал жагсаалтад орж арга хэмжээ авна гэж явсаар 2 жил болж байна. Энэ асуудлыг гаргаж ирэхэд хөндөгдөж байсан ч одоогоор нэг ч хүүхэд Монголбанкны зээлийн мэдээллийн санд ороогүй л байна. Энэ чинь суралцагчдын, хүний эрхийг зөрчсөн асуудал шүү дээ. Хэний хүүхдийн зээл Монголбанкны зээлийн жагсаалтад ороод, хэний хүүхэд нь одоо хүртэл ордоггүй юм. Том утгаар нь харвал Үндсэн хууль зөрчсөн асуудал байхгүй юу. Тиймээс ямар нэгэн шийдэл гаргаж бид заавал засах ёстой. Олон нийтийн хүлээлт ч байгаа. Монголбанк, Боловсролын яам гэсэн төрийн 2 байгууллага яагаад мэдээллээ солилцож болдоггүй юм. Асуудал дэвшүүлж гаргаад 2 жил

болж байхад одоог хүртэл хүүхдүүдийн судалгааг хийж байна гэдэг. Авлигатай тэмцэх газар, Прокурорын газраас бас хамтарсан ажлын хэсэг гараад 1600 гаруй хүнийг ярилцлагад дуудсан байдаг. Үр дүн нь хаана байна? Одоог хүртэл бид нарт мэдээлэл байхгүй.

2025 оны төсөвт түүхэн хэмжээндээ Боловсролын зээлийн санд 158,4 тэрбум төгрөг төсөвлөгдсөн. Үүний 33,6 тэрбум нь эргэн төлөлтөөр, бусад эх үүсвэрээр санхүүжнэ гэсэн. 2025 онд 780 сая төгрөг л эргэн төлөгдсөн. Биелэлтийг нь харвал 2-3 хувьтай. Энэ хэзээ эргэн биелэх вэ гэдэг том .../минут дуусав./

Ч.Ундрам: О.Батнайрамдал гишүүн асуулт асуух уу? Дэгээрээ та асуулт асууж болно.

О.Батнайрамдал: Асуулт асуучихъя. Тэгэхээр олон нийтээс хүлээлттэй байгаа 2 том асуудал байгаа. Боловсролын зээлийн сангаас, ялангуяа гадаад зээл авсан суралцагчид одоо хүртэл яагаад Монголбанкны жагсаалтад орохгүй байна вэ? Монголбанк мэдээллээ өгчих л гээд байгаа шүү дээ. Энэ асуултын хариултыг өгөхдөө дотоодын зээлийн мэдээллийн сан руу мэдээллээ программаар хийдэг. Тэр программд нь гадаад зээлийн хүүхдүүд орох тохиргоогүй байна гэдэг. Энэ юу гэсэн үг вэ? Программын тохиргооноос болоод дотоод зээл авсан хүүхдүүдийг дарамталж зээлийн мэдээллийн санд оруулдаг, гадаадынх нь ордоггүй. Сүүлийн 2 жилээс өмнө энэ талаар хэн ч хөөцөлддөггүй байсан. Тэр хүүхдүүд зээлээ тэтгэлэг, эсвэл буцалтгүй тусламж гэж ойлгож явсаар ирсэн. Татвар төлөгчдийн мөнгө авахаар яагаад хэн нэгэн даргатай яриад цуцалчихна, чөлөөлчихнө гэж ойлгодог юм? Бид Хаан банкнаас зээл авчхаад хэн нэгэн даргатай яриад чөлөөлүүлчихнэ гэсэн ойлголт байдаг уу? Байхгүй шүү дээ. Энэ дэндүү удаж байна. Яагаад төрийн байгууллага дээр очоод яг мэдээлэл солилцох болохоор хүнд суртал гаргаад, эсвэл тэр нь, энэ нь болохгүй байна гээд одоо хүртэл мэдээллээ солилцож болдоггүй юм. Программын шинэчлэл гэдэг миний бодлоор хариулт биш. Ийм хариулт хэлээд сууж байж болохгүй байна.

Хоёрдугаарт, Боловсролын зээлийн сангийн хувьд энэ оны төсөвт нэмэгдүүлэн тусгасан 158,4 тэрбум төгрөг гэдэг бол түүхэндээ том дүн шүү. Засгийн газар залуучууддаа анхаарч хөрөнгө оруулъя гэж байгаа сайн хэрэг. Гэхдээ энэ дүнгийн 33,6 тэрбум нь зээлийн эргэн төлөлтөөс буцаад хийгдэнэ. Тэр 300 тэрбум төлөгдөөгүй байхад аргагүй шүү дээ. Үүнийгээ буцаад төсөвтэйгөө уяж байж эргэн төлөлт нь заавал хийгдэх ёстой. Эргэн төлөлт бүрийн ард дахиад 1 хүүхдэд боломж олдоно гэсэн үг байхгүй юу. Тэгэхээр энэ дээр бүгдээрээ хүнд суртал гаргаж ярихгүй, шийдэл гаргая. Зээлийн эргэн төлөлт дээр 33 тэрбум төгрөг төлөгдөнө гэдэг том асуудал шүү. 2 жил бөөн асуудал болгож гаргаж ирээд олон нийтийг бухимдуулан байж 14-хөн тэрбум төлөгдсөн байна. Тэгэхээр 33,6 тэрбум гэдэг бол маш том дүн. Энэ дээр бүх нийтийг хамарсан ажил явах ёстой. Маш том төлөвлөгөө гаргаж, олон талаасаа хамжиж байгаад эргэн төлөлт дээр ажиллах ёстой юм биш үү? Энэ дээр сайдад ямар нэгэн төлөвлөгөө, биелж байгаа зүйл байна уу? Энэ 2 асуултад хариулт авъя.

Ч.Ундрэм: П.Наранбаяр сайд хариулъя.

П.Наранбаяр: Баярлалаа. Энэ үнэн. Өмнөх зээлээ төлөөгүй нь дараагийнхаа боломжийг булааж байна л гэсэн үг. Туйлын шударга бус. Сулалцах эрхийг нь шууд зөрчиж, хөндөж байна гэсэн үг. Бид программ, мэдээлэл солилцох ажлаа хийгээд бараг дуусаж байгаа. Уучлаарай дуусчихсан. Одоо зөвхөн дотор нь ялгаж, салгах л ажил явж байгаа.

Хоёрдугаарт, таны хэлж байгааг бүрэн ойлгож байна. Энэ жил 33 тэрбумыг буцааж төлүүлж авахгүй бол, таны хэлсэн үнэн. Энэ олон жилд 14,6 тэрбум л буцаж ирсэн, бид шуурхай арга хэмжээ авахгүй бол болохгүй. 2-3 арга зам байна. Эхнийх нь E-Mongolia системээр зээлийн мэдээлэл нь өөр дээр нь шууд очдог болсон нь сайн тал.

Хоёр дахь нь бид Монголбанкны мэдээлэлд оруулснаар төлөлтийг сайжруулна.

Гуравт, прокурорын байгууллагуудад хандаад явж байгаа, тийм ээ О.Сийлэгмаа?

Дөрөвт, заавал шүүх, цагдаа гэхгүйгээр шууд хуулийн фирмийг хөлсөлж ажиллуулаад тодорхой хэмжээнд хамтран ажиллах боломжууд байгаа. Эдгээр арга замуудыг хэрэглэнэ.

Ер нь зээлийн эргэн төлөлт дээр би ч гэсэн тантай адилхан санаа зовж байна. Жишээлбэл, Ерөнхийлөгчийн тэтгэлгээр явж байгаа хүүхдүүдтэй би сая Польш, Чехэд очоод уулзлаа. Үнэхээрийн мундаг хүүхдүүд, эндээс явахад нь ярилцаж үздэг, гаргаж өгдөг. Тэд үнэхээр амжилттай, 98 хувь нь амжилттай сурч байна. Тэд бол ирээдүйн Монголыг авч явах шинэ үеийн, шинэ маягийн сэхээтнүүд шүү дээ. Тэгэхээр эдгээр хүүхдүүд боломжгүй болчихвол яана гэсэн айдас үнэхээрийн байгаа учраас тантай ч гэсэн хамтарч ажиллая. Эргэн төлөлтийг сайжруулах дээр бид шуурхайлъя. Таны шүүмжлэлийг шууд хүлээж авч байна.

Ч.Ундрэм: Гишүүд асуулт асууж, хариултаа авлаа. Асуулт тавьсан О.Батнайрамдал гишүүн бас үг хэлж, асуулт асуулаа.

Боловсролын зээлийн сантай холбоотой шүгэл үлээсэн гол 2 хүн өнөөдөр энэ танхимд сууж байна. Хоёулаа тодорхой хэмжээний шийдвэр гаргах түвшинд, О.Батнайрамдал Улсын Их Хурлын гишүүн болсон, энэ ажлын хэсгийг ахлаад тодорхой хугацаанд ажиллаа. О.Сийлэгмаа дарга бас шүгэл үлээсэн, одоо энэ санг хариуцаад ажиллаж байна. Тэгэхээр одоо яг энэ мөчид л бид маш хурдан, шуурхай ажиллаад, тодорхой шийдвэрүүд гаргаад цаашаа явмаар байна. Монголбанканд мэдээллээ яаралтай өгөхийг, тэр тогтоолын төсөл дээр ч гэсэн оруулаад, яаралтай мэдээллийг өгье гэж гишүүд хэлж байна.

Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй ажиллах мэргэжил дээр хүмүүс яагаад орж ирэхгүй байна гэдэг дээр мэдээлэл хүргэгдэхгүй байна шүү дээ.

Яг ямар мэргэжлээр би Боловсролын зээлийн сангийн зээл, тэтгэлэгт хамрагдаж болох вэ гэдгийг жирийн иргэдээс та нар гараад асуу. Мэдэхгүй байна. Хаанаас тэр мэдээллийг авах юм? Тэр мэдээллийг сайн өгмөөр байна гэх мэтчилэн нэлээн асуудал дээр бид зөндөө ярилаа. Байнгын хороогоор энэ асуудлыг хэдэн ч удаа ярив. Одоо салбар хариуцаж байгаа сайд та үүнийг шуурхайлмаар байна. Холбогдох хүмүүсээ шуурхай уулзуулаад, хэрэгтэй шийдвэрийг нь гаргуулаад явъя. Энд сайжруулахгүй гэсэн нэг ч хүн энэ танхимд байхгүй байна шүү дээ. Тэгэхээр хурдан засаж залруулаад явмаар байна.

Үүнээс гадна Боловсролын багц хуультай холбоотой засаж сайжруулах асуудлууд байгаа. Үүнийг манай зарим гишүүд өргөн барих гээд бэлдэж байгаа, удахгүй хэлэлцээд явчих байх. Жишээлбэл, багш нарын "...15-аас доошгүй жил тасралтгүй ажилласан багш, ажилтны нэг хүүхдийг тэргүүлэх, эрэлттэй мэргэжлээр төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагад үнэ төлбөргүй, хөнгөлөлттэй нөхцөлөөр суралцуулна..." гэсэн заалтын "тасралтгүй" гэдэг үгийг авах саналыг олон багш нараас ирүүлж байгаа. Энэ дээр бид засаад, хүний амьдрал юм чинь жилийн чөлөө авсан байдаг юм уу, тийм нөхцөлийг бас ойлгох ёстой гэж бодож байна. Эдгээр ажлуудаа шуурхайлъя. Шинэ Улсын Их Хурал, Засгийн газар бүрдээд бараг жил болох гэж байна. Бид яриад л, 2 талдаа мэтгэлцээд л суугаад байж болохгүй. Ажлуудаа шийдээд явмаар байна.

О.Батнайрамдал гишүүний асуултын хариуг хэлэлцэж дууслаа.

---oOo---

**УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН А.АРИУНЗАЯАГААС 2025 ОНЫ
4 ДҮГЭЭР САРЫН 03-НЫ ӨДӨР ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД Л.ЭНХ-АМГАЛАНД ХАНДСАН “ХӨДӨЛМӨРИЙН
ХӨЛСНИЙ ДООД ХЭМЖЭЭНИЙ ТАЛААР” АСУУЛТ-15**



Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт Үндэсний хорооны 2024 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 03 дугаар тогтоолоор хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2025 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 792,000 (долоон зуун ерэн хоёр) мянган төгрөг болгож нэмэгдүүлэх шийдвэр гаргасан.

Энэхүү шийдвэртэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Танд дараах асуултыг тавьж байна.

1. Үндэсний хорооны 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 12 дугаар тогтоолоор хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сард 660,000 (зургаан зуун жаран) мянган төгрөг байхаар тогтоосон байхад 2025 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс дахин нэмэгдүүлэх шийдвэр гаргасан нь Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсэгт заасан “...хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр жилд нэг удаа тогтоох...”, 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэгт заасан хугацааг зөрчсөн эсэх талаар;

2. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2025 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс нэмэгдүүлснээр цалин хөлсөнд уялдуулах эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлийн асуудал, улсын төсөвт үзүүлэх ачааллын талаарх тооцоолол бүхий мэдээлэл;

3. Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн 144.2, 144.3 дахь хэсэгт заасны дагуу төлбөр төлөх хичнээн аж ахуйн нэгж, байгууллага байгаагаас хэд нь тус төлбөрийг төлж байгаа, мөн гадаадаас ажиллах хүч авч байгаа аж ахуйн нэгж, байгууллагад үзүүлж байгаа нөлөөлөл зэргээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэгдүүлснээр үүсэх нөлөөллийг хэрхэн тооцсон талаарх мэдээлэл, тооцоо судалгааг ирүүлнэ үү.

Асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт заасан хугацаанд ирүүлэхийг хүсье.

---oOo---

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН А.АРИУНЗАЯАГААС ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДАД ХАНДСАН “ХӨДӨЛМӨРИЙН ХӨЛСНИЙ ДООД ХЭМЖЭЭНИЙ ТАЛААР” АСУУЛТ-15-ЫН ХАРИУГ НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ 2025 ОНЫ 5 ДУГААР САРЫН 07-НЫ ӨДРИЙН ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦСЭН МЭДЭЭЛЭЛ

Нийгмийн бодлогын байнгын хорооны 2025 оны 5 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяагаас Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад хандсан асуултын хариуг хэлэлцэв. Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан болон тус яамны Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Алимаа, Хөдөлмөрийн бодлогын газрын дарга Б.Нарангарав, Цалин хөлсний бодлого, төлөвлөлт, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ хариуцсан ахлах шинжээч Ш.Гэрэлцэцэг, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Б.Батжаргал, Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооны ерөнхий нарийн бичгийн дарга Х.Буянжаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Х.Энэбиш, референт Б.Цогзолбаяр, Хяналт шалгалтын газрын референт К.Пүрэвсүрэн нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяагаас Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад хандсан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний талаарх асуултын хариуг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан танилцуулав.

Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга Л.Энхнасан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Л.Энхнасан: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан танилцуулга хийнэ.

Л.Энх-Амгалан: Байнгын хорооны дарга, гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяагаас хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний талаар 3 асуулт ирүүлсний дагуу хариуг бид бэлдсэн.

Л.Энх-Амгалан: Байнгын хорооны дарга, Байнгын хорооныхоо гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяагаас хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний талаар ирүүлсэн 3 асуултын хариуг бид бэлдсэн.

Асуулт 1. Үндэсний хорооны 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 12 дугаар тогтоолоор хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 660,0 мянган төгрөг байхаар тогтоосон байхад 2025 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс дахин нэмэгдүүлэх шийдвэр гаргасан нь Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуулийн 5 дугаар зүйлийн

5.4 дэх хэсэгт заасан "...хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр жилд нэг удаа тогтоох...", 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэгт заасан хугацааг зөрчсөн эсэх талаар.

Цалингийн түвшин хамгийн доогуур буюу бага орлоготой иргэдийг хамгаалах бодлогын нэг гол хэрэгсэл бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тогтоох явдал байдаг. Олон улсын хөдөлмөрийн байгууллагын гишүүн орны 91 орчим хувь нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тогтоож байна. Өнөөдөр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг улс орнуудаар авч үзэхэд Австрали 1 цагт 18 ам.доллар, Шинэ Зеланд 1 цагт 16 ам.доллар, Англи, Люксембург, Герман, Аргентин зэрэг улсуудад нэг цагийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нэлээн өндөр байдаг. Азийн хөгжиж буй улс орнуудын 1 цагт ноогдох хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг авч үзвэл Филиппин 1 ам.доллар 64 цент, Индонез 1 ам.доллар 18 цент зэрэг буюу 1 ам.доллараас дээш байгаа бол Бангладеш, Киргизстан, Тажикстан зэрэг улсуудад 1 ам.доллараас бага байна.

Монгол Улсын хувьд 2024 оны байдлаар хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 1 цагт 3929 төгрөг буюу 1 ам.доллар 10 цент байсан бол сая нэмснээр 2025 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш 1 цагийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 4715 төгрөг буюу 1,3 ам.доллар болж өссөн. Үүнийг дахин дахин хэлээд байгаа нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр нэг цагийн хөлсийг тооцож олгодог буюу цагийн ажил хийж байгаа маш их олон хүмүүс байдаг. Тэр тусмаа манай оюутан залуучууд байна.

Бид нарын авсан мэдээллээр нийт 134 мянган хүн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр нийгмийн даатгалынхаа шимтгэлийг төлдөг. Албан журмын буюу ажил хийгээд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр төлж байгаа 176 мянган иргэд байна. Энэ бол нийгмийн даатгалд шимтгэл төлж байгаа нөгөө 1,2 сая иргэдтэй харьцуулахад 25 хувь нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр нийгмийн даатгалын шимтгэлээ төлж байна гэсэн үг. Үүний цаадах асуудал буюу хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг яагаад нэмэгдүүлэх ёстой вэ гэдэг асуудал байна. Манай улсын хөдөлмөрийн зах зээлийн өнөөгийн хомсдолын гол асуудал бол хөдөлмөрийн бүтээмж, хөдөлмөрийн үнэлгээний асуудал байгаа. Нэг талдаа хөдөлмөрийн зах зээлд өнөөдөр 40-өөс 5 мянган бодитой ажлын байр байна, нөгөө талдаа 70-80 мянган ажилгүйчүүд байгаа асуудал юм. Тэгэхээр монгол хүний нэг цагийн хөдөлмөрийн бүтээмж дээр үндэслэсэн цалин хөлсний тогтолцоогоо бид эргэж харахгүй бол цаг үеийн шаардлага хангахаа больсон гэж харж байгаа. Ер нь хамгийн бага цалинтай гэж ойлгож болно. А.Ариунзаяа гишүүн өөрөө энэ салбарын сайд байсан учраас мэргэжлийн сайдын асуулт асуусан.

Тэгэхээр миний өгөх хариулт бол хууль зөрчсөн үү гэвэл зөрчөөгүй. Одоо байгаа хуулийн зохицуулалтаар явах ёстой гэвэл ийм болчхоод байгаа юм. Өнөөдрийн мөрдөгдөж байгаа Хөдөлмөрийн тухай хуулийг А.Ариунзаяа гишүүн өөрөө сайд байхдаа батлуулсан. Мөн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг зохицуулах тусдаа хуультай. Тиймээс энэ 2 хуулийн хоорондын уялдааг хангах цаг хугацааны зайлшгүй нөхцөл байдал үүссэн гэж харж байна. Өөрөөр хэлбэл,

Хөдөлмөрийн тухай хууль шинэчлэгдэн батлагдчихсан учраас хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тогтоох, өөрчлөх асуудлыг зохицуулдаг хуулиа зайлшгүй өөрчлөх ёстой гэсэн логик хандлагаар А.Ариунзаяа сайдыг асуулт тавьсан гэж би хараад байгаа. Тэгэхээр үүнийг хамтдаа өөрчилъе. Хууль зөрчөөд нэмчихсэн гэдэг талаас хариулт өгөхөөсөө илүү зөрчөөгүй юм шүү гэдэг дээр тайлбар хэлье гэж бодсон. Яагаад гэвэл Монгол Улсад хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тогтоох, өөрчлөх тухай асуудлыг Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуулиар зохицуулж, Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн 3 талт Үндэсний хорооноос 2 жилд нэг удаа тогтоохоор заасан. Мөн хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-т заасны дагуу Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн 3 талт Үндэсний хорооны төлөөлөл бүхий аль нэг тал, эсхүл талууд хамтран хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тогтоох, өөрчлөх саналыг гаргаж болох бөгөөд уг саналын дагуу 2 жилээс бага хугацаанд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоож болно гэж бид ойлгож болно. Түүнчлэн ““Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн 3 талт 2023-2025 оны Улсын хэлэлцээр”-ийн цалин хөлсний талаар үндэсний хэмжээнд баримтлах бодлого, үйл ажиллагаанд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэгдүүлэн тогтоох” гэж, мөн Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн 3 талт Үндэсний хорооны 2023 оны хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох 12 дугаар тогтоолын 2 дугаар заалтаар “2025 онд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2024 оны 5 дугаар сарын 01-ний өдрийн дотор шинэчлэн тогтооно” гэж тус тус шийдвэрлэсэн.

Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн 3 талт Үндэсний хорооны төлөөлөл буюу Монголын ҮЭХ-ноос хэрэглээний үнийн өсөлт, хүн амын амьжиргааны доод түвшин зэрэгтэй уялдуулан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний дундаж доод хэмжээг дундаж цалингийн 50 хувьд хүргэх буюу 1 сая төгрөгт хүргэх ёстой.

Дээр дурдсан тогтоол, хэлэлцээрийн хэрэгжилтийг хангаж ажиллаач гэдэг шаардлагыг удаа дараа, мөн 3 талт хэлэлцээрийн үеэр илэрхийлсэн. Олон удаа хурал дээр ч энэ саналыг илэрхийлсэн. Энэхүү саналыг судалж үзээд Улсын хэлэлцээр болон тогтоолд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг хангах хүрээнд Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн 3 талт Үндэсний хорооны 2024 оны 01 дүгээр тогтоолоор хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох асуудлаар тооцоолол хийж, санал боловсруулаад 3 талын хамтарсан ажлын хэсэг ажилласан. Тус ажлын хэсгээс танилцуулсан холбогдох хүчин зүйлс болон талуудын саналыг харгалзан Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн 3 талт Үндэсний хорооны 2024 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 03 дугаар тогтоолоор улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 3929 төгрөг буюу сард 660,0 мянган төгрөг байсныг 2025 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 20 хувиар нэмэгдүүлснээр өнөөдөр Монгол Улсад нэг цагийн хөдөлмөрийн хөлс 4715 төгрөг буюу сард 792,0 мянган төгрөг байхаар шинэчлэн тогтоогоод мөрдөгдөж байна.

Түүнчлэн үүнийг ярихын өмнө А.Ариунзаяа сайд Улсын Их Хурлын чуулган дээр хэд хэдэн удаа, мөн төсвийн үеэр байр сууриа илэрхийлж байсан. Ер нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмснээр хэн хожих, Монгол Улсад хэн хохирох, хэн дээр ачаалал ирэх вэ гэдэг асуудал байгаа. Тэгэхээр хөдөлмөрийн

хөлсний доод хэмжээ нэмэгдэхэд олон мянган хүний цалин хөлс нэмэгдснээр олон өрхийн орлого нэмэгдэж байгаа гэдэг мэдээллүүд бидэнд байна. Нөгөө талаас хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нэмэгдэхэд инфляцад нөлөөлөх эсэх талаар асууж байсан. Ерөнхий сайд ч гэсэн хэд хэдэн удаа Засгийн газар дээр энэ асуудлаар мэргэжлийн байгууллагуудын байр суурийг сонс гэж байсан. Ингээд Үндэсний статистикийн хороо, Монголбанкнаас бид дүгнэлтүүд авсан. Үндэсний статистикийн хорооны болон Монголбанкны мэдээллээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний өсөлт сарын инфляцад 0.002 нэгж хүртэл хувиар нөлөө үзүүлнэ. Энэ нь инфляцад нөлөөлөхүйц нөлөө үзүүлэхгүй гэсэн дүгнэлтийг бидэнд өгсөн. Бид эдгээр нөхцөл байдлуудыг харгалзаж Хөдөлмөрийн тухай хуульд хөдөлмөрийн эрх зүйн хэм хэмжээ тогтоосон актууд хоорондоо зөрчилдвөл ажилтанд илүү таатай нөхцөлийг олгосон зохицуулалтыг хэрэглэхээр тусгасан байгаа. Тийм учраас энэ удаагийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 4 дүгээр сарын 01-ний өдрөөс нэмэгдүүлэхтэй холбоотой гаргасан Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн 3 талт Үндэсний хорооны тогтоол бол монгол ажилтанд илүү таатай нөхцөлийг олгосон шийдвэр болсон гэдгийг хэлье. Энд нэгэндээ ажлаа өгч, авсан гурван сайд сууж байна. Сүүлийн 3 жилийн Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн 3 талт Үндэсний хорооны тогтоолыг Х.Булгантуяа, А.Ариунзаяа сайд бид гурав зурсан. Энд Х.Булгантуяа сайдын буюу Монголын Засгийн газар үүрэг хүлээсэн манай тогтоол байна. Үүний дагуу нэгэнт Засгийн газар, Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн 3 талт Үндэсний хороо үүрэг хүлээсэн учраас энэ хүрээндээ бид нэмсэн. Энэ дээр олон зуун мянган ажилтнууд маань талархаж хүлээж авч байгаа гэдгийг хэлье.

Асуулт 2. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2025 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс нэмэгдүүлснээр цалин хөлсөнд уялдуулах эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлийн асуудал, улсын төсөвт үзүүлэх ачааллын талаарх тооцоолол бүхий мэдээллийн талаар.

Хариулт. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэгдүүлэн тооцсоноор аж ахуйн нэгж, байгууллагад ажиллаж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр цалин хөлс авдаг ажилтны цалин хөлс болон зарим төрлийн тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ нэмэгдэх эерэг үр дагавар гарсан. Тухайлбал, хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэмж авч байгаа 47500 хүний тэтгэмж 93 мянган төгрөгөөр, жирэмсний, амаржсаны тэтгэмж авч байгаа 29500 хүний тэтгэмж 167 мянган төгрөгөөр, ажилгүйдлийн тэтгэмж авч байгаа 16600 хүний ажилгүйдлийн тэтгэмж 182 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж байна.

Нөгөө талаас сайн дурын даатгуулагчийн шимтгэл төлөлт, ажил олгогчдын цалингийн зардал тодорхой хэмжээгээр нэмэгдэнэ. Тухайлбал, нийгмийн даатгалын шимтгэлийн төлөлтөд дараах нөлөө үзүүлэхээр байна. Улсын төсвөөс нийгмийн даатгалын шимтгэлийг хариуцан төлөх 81400 даатгуулагчдын нийгмийн даатгалын шимтгэл 4,7 төгрөгөөр нэмж төлөгдөнө. Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2, 21.17, 21.22, 21.23 дахь хэсэгт заасан цаа буга маллан тайгад амьдарч амьдарч байгаа цаатан болон эмнэлгийн хяналтад байдаг байнгын асаргаа шаардлагатай 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч ажил эрхлээгүй,

эсхүл эцгийн шимтгэлийг бүрэн хэмжээгээр 3 хүртэлх насны хүүхдээ асарч байгаа эх, малчин, туслах малчны төлөх шимтгэлийн 50 хувийг тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцон сар бүр улсын төсвөөс төлөхөөр заасан байдаг. Нийгмийн даатгалын сангаас хариуцан төлөх 18900 даатгуулагчдын нийгмийн даатгалын шимтгэл 2 тэрбум төгрөгөөр нэмж төлөгдөхөөр байна.

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 21 дүгээр зүйлийн холбогдох заалтуудад заасан хөдөлмөр эрхлээгүй, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсаны тэтгэвэр авагчийн шимтгэлийг бүрэн, 3 хүртэлх насны хүүхдээ асарч байгаа эхийн шимтгэлийн 50 хувийг нийгмийн даатгалын сангаас хариуцан төлөх зохицуулалттай.

Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн орлого 129 тэрбум төгрөгөөр нэмэгдэнэ. Үүнд, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний цалинтай даатгуулагч болон Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 19.4 дэх хэсэгт заасны дагуу хөдөлмөрийн хөлсний дээд хэмжээнээс дээгүүр цалинтай, нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцсон ажил олгогч сар бүр төлж буй 295,000 даатгуулагчдын шимтгэлийн орлого 101 тэрбум төгрөгөөр нэмэгдэнэ. Түүнчлэн сайн дураар хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцож нийгмийн даатгалын шимтгэл төлөгч 134,000 даатгуулагчийн шимтгэл 28,7 тэрбум төгрөгөөр нэмэгдэхээр байна.

Нийгмийн даатгалын сангийн орлого нь 120 гаруй тэрбум төгрөгөөр нэмэгдэж, зарлага нь 38,4 тэрбум төгрөгөөр нэмэгдэж байгаа. Үүнд, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 21.2 дахь хэсэгт заасны дагуу тэжээгчээ алдсаны бүрэн тэтгэврийн доод хэмжээ авдаг 1498 тэтгэвэр авагчийн тэтгэврийн доод хэмжээ 66 мянгаас 132 мянга болж нэмэгдэж байгаа. Энэ дээр 2,5 тэрбум төгрөгийн зардал гарна. Нийгмийн даатгалын сангаас олгох хөдөлмөрийн чадвар алдсаны болон жирэмсний, амаржсаны, ажилгүйдлийн тэтгэмжийн даатгал нь нийт 36 тэрбум төгрөгөөр нэмэгдэж байгаа. Эх, эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуулийн дагуу 0-18 насны 3 болон түүнээс дээш өрх толгойлсон эх, эцэгт улирал бүр тэтгэмж олгохоор заасан байдаг. Энэ тэтгэмжид 2024 оны 12 дугаар сарын байдлаар 8812 иргэн хамрагдаж, нийгмийн халамжийн сангаас 20 орчим тэрбум төгрөгийг олгосон байна.

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2025 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 792,0 мянган төгрөг болгосноор 3,5 тэрбум төгрөг нэмж шаардагдана. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэгдүүлснээр холбогдох зардлын өөрчлөлтийн мэдээллийг Сангийн яаманд бид тухай бүр хүргүүлж байсан. А.Ариунзаяа гишүүн Улсын Их Хурлын чуулган дээр Сангийн сайд Б.Жавхлангаас хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нэмэгдсэнтэй холбогдуулж төрөөс ЭМД-ын шимтгэлийг нь төлдөг дөрвөн зохицуулалтын талаар 2025 оны улсын төсөвтэй холбогдуулан асууж байсан. Энэ дээр миний бие андуураагүй бол Эрүүл мэндийн даатгал бусад даатгалуудтай холбогдуулаад нийт 47 орчим тэрбум төгрөгийн

эх үүсвэрүүдийг урсгал зардал дээр суулгасан гэдэг мэдээллийг Сангийн сайд Б.Жавхлан удаа дараа өгч байсан гэдгийг би энд онцолж хэлье гэж бодож байна.

Асуулт 3.Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн 144.2, 144.3 дахь хэсэгт заасны дагуу төлбөр төлөх хэчнээн аж ахуйн нэгж, байгууллага байгаагаас хэд нь тус төлбөрийг төлж байгаа, мөн гадаадаас ажиллах хүч авч байгаа аж ахуйн нэгж, байгууллагад үзүүлж байгаа нөлөөлөл зэргээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэгдүүлснээр үүсэх нөлөөллийг хэрхэн тооцсон талаарх мэдээлэл, тооцоо судалгааг ирүүлэх талаар.

Хариулт. Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн 144.2-т “Өмчийн төрөл хэлбэрээс үл хамаарч 25 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нийт ажлын байрныхаа 4 хувиас доошгүй орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулна” гэж, 144.3-т “Аж ахуйн нэгж, байгууллага энэ хуулийн 144.2-т зааснаар хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллуулаагүй бол ажиллуулбал зохих орон тоо тутамд ногдох төлбөрийн хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцүү байх бөгөөд уг төлбөрийг сар бүр Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд санд төлнө” гэж заасан. Хуулийн уг заалтын дагуу Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд 2024 онд 4346 хүний 7,1 тэрбум төгрөг төвлөрсөн байна. Энэ их чухал тоо шүү. Хөдөлмөрийн бэрхшээлтэй иргэд ажиллуулаагүй бол аж ахуйн нэгжүүдээс төлөх энэ төлбөр нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдсан байдаг учраас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд буюу хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд маань хөдөлмөр эрхлэх 7,1 тэрбумын шинэ боломжууд гарч ирсэн гэж ойлгож болно. 2024 онд тус санд төлбөр төлсөн хүний тоогоор бодоход 2025 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нэмэгдсэнээр сард ойролцоогоор 1,1 тэрбум төгрөг нэмж төлөгдөнө. Энэ 1,1 тэрбум юу болох вэ гэвэл хөгжлийн бэрхшээлтэй ч хөдөлмөрлөх боломжтой нөгөө 90-ээд мянган иргэдэд дахиад 1 тэрбум төгрөгийн ажлын байр нэмэгдэх боломжийг нэмэгдүүлсэн гэж ойлгож болно. Ийм эерэг сайн талууд байна.

Гадаадаас ажиллах хүч авч ажиллуулах аж ахуйн нэгж, байгууллага нь Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1-д “Хуульд өөрөөр заагаагүй бол гадаад ажилтны ажлын байрны төлбөрийн нэг сарын хэмжээ нь нэг сард ногдох хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээтэй байна” гэж зааснаас гадна уг хуульд заасан шаардлагыг хангаж байгаа тохиолдолд гадаад ажилтны ажлын байрны төлбөрийн хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагддаг зохицуулалттай. Мөн энэ хуулийн 32 дугаар зүйлийн 32.3-т заасан “...гадаад ажилтан, боловсрол, шинжлэх ухаан, эрүүл мэнд, соёл, спортын байгууллагад гэрээгээр ажиллах эмч, эрдэм шинжилгээний ажилтан, мэргэжлийн багш, дасгалжуулагч авч ажиллуулах ажил олгогчийг ажлын байрны төлбөрөөс чөлөөлнө” гэж заасны дагуу чөлөөлөлтүүд явагддаг.

Хоёрдугаарт, мөн хуульд “Засгийн газрын шугамаар авсан гадаадын хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн хүрээнд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх болон стратегийн ач холбогдол бүхий дэд бүтэц, үйлдвэрлэл, шинэ хотын бүтээн байгуулалтад гадаад ажилтан ажиллуулах тохиолдолд Засгийн газар

ажлын байрны төлбөрөөс хөнгөлж, чөлөөлж болно.” гэсэн заалттай. Та бүгдэд өгсөн мэдээллээр 2024 онд гадаад ажилтан авсан нийт байгууллагын тоо 5733, Монгол Улсад орж ирсэн гадаад ажилтны тоо 26480 байгаа. Энд 280 мянган хятад орж ирдэг энэ тэр гэсэн тоо байхгүй, би үүнийг далимдуулаад тайлбар хийчихье.

Монгол Улсад орж ирж байгаа гадаад ажилтнуудад хязгааргүй тоо гэж ерөөсөө байдаггүй. Энэ хязгаар нь Монгол Улсын нийт хүн амын 3 хувь, нэг улсаас ирэх тоо нэг хувиас хэтрэхгүй гэсэн хязгаартай байдаг. Тийм учраас Монгол Улсад жилд 30-40 мянгаас дээш гадаадын нэг ч ажилтан орж ирдэггүй хуультай. Яагаад үүнийг гуйвуулаад квотгүй гэх ойлголт.../минут дуусав./

Л.Энхнасан: Сайд дуусгаж хариулах цагийг нэмье.

Л.Энх-Амгалан: Квот дотроо тухайн салбаруудаас зарим салбарыг нэмдэг зохицуулалттай гэсэн тайлбарыг энэ далимд өгье. Ингээд эцэст нь дүгнэхэд асуултуудад хариулахдаа би онцолж хэлсэн.

А.Ариунзаяа гишүүн хийдэл гараад байгаа энэ 3 талт Үндэсний зөвлөлийн хэлэлцээрүүдийг хэрэгжүүлэхэд 1 дүгээрт тодорхой эрх зүйн зохицуулалтууд хэрэгтэй учраас Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг зохицуулах тухай хуульд өөрчлөлт оруулах шаардлага байгааг олж хараад энэ өөрчлөлтийг хийх гэж байна гэж харж байгаа. Ер нь цалин хөлсний бодлогоо бид эргэж харах зайлшгүй шаардлага үүссэн. Өнөөдөр манай улсын ДНБ-д эзэлж байгаа бодит цалингийн зардал хамгийн бага буюу дөнгөж 31-32 хувь хүрэхгүй хэмжээнд байна. Бусад улсуудын ДНБ-д үзүүлдэг бодит цалингийн зардал 40-60 хувьд хүрчихсэн.

Өнөөдөр Монголчууд яагаад Солонгос, Австралийг зорьж байгаа гэдэг асуудлын хариулт нь Монгол Улсад монгол хүний хөдөлмөрийн бүтээмж, нэг цагийн үнэлэмжтэй холбоотой, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний зохицуулалттай холбоотой асуудлууд гарч ирж байгаа юм. Тиймээс энэ хүрээндээ цөмөөрөө ярилцаж, тодорхой шийдэл гаргаад явах нь зүйтэй болов уу гэсэн хүлээлттэй байгаа гэдгийг салбарын сайдын хувьд хэлье.

Л.Энхнасан: Баярлалаа. Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд гишүүн асуултын хариуг хэлэлцүүлэхээр бичгээр саналаа ирүүлснээс хойш 10 хоногийн дотор Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэхээр заасны дагуу өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар А.Ариунзаяа гишүүний асуултыг хэлэлцүүлж байна. Мөн Байнгын хорооны хуралдаанд асуултын хариуг холбогдох албан тушаалтан 5 минутаас илүүгүй хугацаанд танилцуулах бөгөөд гишүүд 3 минутаас илүүгүй хугацаанд асуулт асуух, хариулт, тайлбар хангалтгүй гэж үзвэл 1 минутаас илүүгүй хугацаагаар нэмэлт асуулт асууж, тайлбар авах, хариулт 1 минутаас илүүгүй байх зохицуулалттай.

Одоо асуултын хариутай холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Х.Булгантуяа гишүүнээр тасаллаа. А.Ариунзаяа гишүүн асуултаа асууя.

А.Ариунзаяа: Түрүүлээд ирчихээр дахиад л нөгөө 1 дүгээрт асуулт асуух болчихоод байдаг. Уг нь сонсож байгаад асуулт асуувал илүү улс төр хийх боломжтой юм, сайд аа. Хажууд суучихаад Л.Энх-Амгалан сайд маань манай А.Ариунзаяа ингэсэн юм, тэгсэн юм гэхээр зөөлрөх маяг ороод болдоггүй.

Нэг талдаа бол үнэн л дээ. Би яагаад хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний талаар асуулт тавьсан гэхээр мэдэхгүй биш мэдэж байгаа. Бодлогын талаар олон нийтийн анхаарлыг оруулж, мөн Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуулийг өөрчлөхгүй бол сөрөг үр дагаврууд маш олон байна гэдгийг хэлэх гэж энэхүү асуултыг тавьсан. Уг нь чуулганаар сонсьё гэсэн ч асуулт биш асуулгын хариултыг сонсдог юм байна. Сайдаа, төсвийн төсөл өргөн барьсан хойно энэ шийдвэр чинь орж ирсэн учраас төсөв дээр ороогүй. Сангийн яамны зүгээс ЭМД-ын сан, нийгмийн даатгалын сангийн орлого төсвийн татаас тал дээр нь ахиу тавьчихсан байгаа учраас төрөөс даах орлого дээр асуудал үүсэхгүй гэж Б.Жавхлан сайд хариулсан. Гэхдээ үүнийг яг Байнгын хороон дээр ч, төсөв дээр ч яриагүй, манай бүлэг дээр ярьсан асуудал. Миний гол болгоомжлоод байгаа зүйл бол орлого тал чинь гайгүй болдог юм байж, зарлага тал чинь нэмэгдэхээр төлөвлөгдөөгүй, төсөвлөгдөөгүй зардал гарч ирэхээр эрсдэлтэй шүү. Үүнийгээ анхаарч зөв талаас нь ярьж, дараа төсвийн тодотгол орвол энэ дээрээ төсвөө хангалттай тавихгүй бол одоогийн нөхцөл байдал, хүндрэл улам л даамжирна гэсэн үг. Тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ нэмэгдэнэ. Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авч байгаа 47,5 мянган хүний тэтгэмжийн хэмжээ 93 мянган төгрөгөөр, жирэмсний, амаржсаны тэтгэмж авч байгаа 29,5 мянган хүний тэтгэмж 167 мянган төгрөгөөр, ажилгүйдлийн тэтгэмж авч байгаа 18,6 мянган хүний тэтгэмж 182 мянган төгрөгөөр нэмэгдэнэ гэж ярьж байна. Яг одоо тэтгэмж авч байгаа хүмүүсийн сарын тэтгэмж нэмэгдэж байгаа юу? Энэ чинь эргээд ямар буруу ойлголт өгч байна гэхээр тэтгэвэр, тэтгэмж дагаж нэмэгддэг юм шиг ойлгогдоод байна.

Уг нь л та хэдийн энэ тайлбар чинь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нэмэгдсэн дүнгээрээ төлж байгаа бол тэр дүнгээсээ дараа, алсдаа нэмэгдэж тооцогдоно гэдэг тогтолцоо л доо. Одоо хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тэтгэмж авч байгаа хүмүүс байгаа бол тэр нь нэмэгдэнэ гэсэн л агуулга. Гэтэл нийт иргэдийн тэтгэмж яг өнөөдөр нэмэгдэх юм шиг ойлголт өгөх чинь эргээд галтай, буруу шүү. Та нар нэмэгдэнэ гэсэн, минийх нэмэгдээгүй байна, нэмэгдүүлээч гэдэг шаардлага ирнэ шүү дээ. Үүнийгээ яаж тооцсон юм, тайлбарлаад өг.

Л.Энхнасан: Сайд хариулах уу? Ажлын хэсгээс хариулах уу? Б.Батжаргал даргад 6 дугаар микрофоныг өгнө үү? А.Ариунзаяа гишүүний асуултад хариулъя.

Б.Батжаргал: Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний нэмэгдэлтэй холбоотойгоор нийгмийн даатгалын сангийн зарлага тал дээр буюу богино хугацааны эрсдэл болох тэтгэмжүүдийг программ дээр тооцоолол хийгээд 2025 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш эрсдэлд ороод хүсэлтээ гаргах магадлалтай тооцоо болон хүнийхээ тоог дундаж цалингийн хэмжээтэй оруулж тооцсон байгаа. Завсрын үе гарна. Энэ нь дунджаар 660,0 мянгатай болон

792,0 мянгатай хэсэг сарыг нь тооцно. Тэгэхээр 7 дугаар сараас эхлээд хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж бүрэн 792,0 мянган төгрөгөөр тооцогдохоор дундын завсрын болон бүрэн бодолттой хувилбараар тооцож гаргасан зардлын тооцоолол байгаа. Баярлалаа.

Л.Энхнасан: А.Ариунзаяа гишүүн тодруулъя.

А.Ариунзаяа: Харин тийм. Би наадхыг чинь мэдээд байна Б.Батжаргал дарга аа. Тийм учраас болгоомжтой байгаарай гээд байна. Та нар одоо тэтгэвэр, тэтгэмж авч байгаа хүмүүсийн сарын тэтгэмж 4 дүгээр сарын 01-ний өдрөөс нэмэгдэх юм шиг ойлголтыг өгчхөөд байна. Гэтэл үгүй байгаа биз. 792,0 мянгаасаа тооцож шимтгэл төлж байгаа бол алсдаа тэр хүмүүс тэтгэвэр, тэтгэмж авах буюу саяын тооцооллоор эрсдэлд оруул гэж байна шүү дээ. Тэр үед тооцогдох мөнгө нь нэмэгдэнэ гэж ярьж байгаа байхгүй юу. Тэгэхээр маш болгоомжтой, зөв илэрхийлээрэй гэж хүсэж байна. Тэгэхээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмснээр шууд өнөөдрийн тэтгэвэр, тэтгэмж нэмэгдэх ойлголт байхгүй. Тийм биз.

Өнөөдөр бодогдож байгаа цалин нэмэгдэж байгаа бол алсдаа бодогдох тэр тэтгэвэр, тэтгэмж л нэмэгдэх болохоос биш өнөөдрийн олголт дээр ямар ч нөлөө байхгүй. Тийм учраас өнөөдрийн ахмадууд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нэмсэн юм чинь миний тэтгэвэр, тэтгэмж нэмэгдэх ёстой гэж яриад байна.

Л.Энхнасан: Сайд хариулна уу.

Л.Энх-Амгалан: А.Ариунзаяа гишүүн салбарын энэ бүх асуудлыг сайн мэдэж байгаа, болгоомжлох нь зөв. Бид үүнийг хүлээж авах ёстой. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нэмэгдэнгүүт бүх хүмүүсийн цалин, бүх тэтгэвэр, тэтгэмж нэмэгдэнэ гэдэг ойлголт хэзээ ч байхгүй. Угаасаа тийм боломж ч байхгүй. Тэгэхээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг ямар аргачлалаар нэмэх ёстой юм гэдгээрээ л явна. Үнэнийг хэлэхэд өнөөдөр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр цалин авч байгаа хүн Монголд бараг байхгүй, харин шимтгэл төлж байгаа хүмүүс л байгаа. Өөрөөр хэлбэл үүнийг шимтгэл төлөх хэмжээ болгочихсон. Тэгэхээр бид А.Ариунзаяа гишүүний хэлээд байгаа Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуульдаа цаг үеийн шаардлага, эрэлт хэрэгцээнд нийцүүлсэн өөрчлөлтүүд хийхээс өөр сонголт, гарц байхгүй.

Л.Энхнасан: Баярлалаа. М.Ганхүлэг гишүүн асуултаа асууя.

М.Ганхүлэг: Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдолтой тодруулах 2, 3 асуулт байна. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэгдүүлэх, олон улсын жишигт нийцүүлэхтэй холбогдолтой агуулга явах нь зөв. Гэхдээ эдийн засагт үзүүлж байгаа нөлөөллийг нь үзэхээр бүртгэгдээгүй ажиллах хүчний тоог нэмэгдүүлэх, инфляцад нөлөөлөх, орон нутгийн түвшинд Улаанбаатар болон төв суурин газраас илүү бодит байдал дээр хүндрэл илүү байх, ажилгүйдэл бий болох нэг шалтгаан болох, хамгийн гол нь ялангуяа хөдөө аж ахуй, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч нарын хувьд сөрөг үр дагавар гардаг. Ялангуяа улирлын

чанартай ажил хийдэг, хөдөө аж ахуйн зэрэг салбарынхны хувьд хүндрэл тулгардаг. Тэр утгаараа гарах өөрчлөлт, нөлөөллийг судалдаг, тооцдог, хариу арга хэмжээ авдаг асуудал хэр байдаг вэ?

Хоёрдугаарт, сая сайд хэллээ, шимтгэлийн тодорхой авах дүн гэж үндсэндээ ашиглагдаад байна гэж. Энэ агуулгын хүрээнд Б.Батжаргал даргаас голчлон асууя.

Хувиараа нийгмийн даатгалын шимтгэл төлдөг хэчнээн иргэд байдаг вэ? Сар бүр сайн дураараа төлөөд л байдаг, бодит байдал дээр эдгээр иргэд зээлд хамрагдах, визэнд орох ч юм уу бусад чиглэлээр бараг ашиглагдах боломжгүй байдаг. Тэгэхээр энэ талаар цаашдаа яах ёстой вэ?

Гуравдугаарт, энэ оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс Малчны тухай хууль хэрэгжиж байгаа. Үүнтэй холбоотой малчдыг дэмжих нэлээн заалтууд орсон. Түүний нэг нь нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэхтэй холбоотой тодорхой агуулга орсон. Энэ хуулийн хэрэгжилтийн явц болон ирэх оны төсөвт тусгах санал, судалгааны явц ямар байгаа вэ?

Л.Энхнасан: Сайд хариулна уу.

Л.Энх-Амгалан: М.Ганхүлэг гишүүний асуултад хариулъя.

М.Ганхүлэг гишүүн ээ, Монгол Улсад өнөөдрийн байдлаар хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр сайн дурын даатгал төлж байгаа 134,0 мянган иргэд байна. Эдгээр нь ерөнхийдөө малчид, хувиараа хөдөлмөр эрхэлж зах дээр худалдаа, үйлчилгээ хийж байгаа иргэд байгаа. Жижиг аж ахуйн нэгжүүд ч гэсэн ерөнхийдөө хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр ажилтнуудынхаа нийгмийн даатгалын шимтгэлийг төлөөд явж байгаа. Энэ гэхдээ их хортой шүү дээ. Нийгмийн даатгалын шимтгэлээ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр төлөөд байна гэдэг нь ирээдүйд бага тэтгэвэр авна л гэсэн үг. Иргэдийн дунд санал асуулга явуулахад бараг 100 мянган иргэд нийгмийн даатгалын шимтгэлийг бууруулахыг дэмжсэн. Ер нь ажил олгогч нар болохоор нөгөө алтыг нь аваад авдрыг нь хаяна гэдэг шиг залуу насанд нь ажил хөдөлмөр эрхлүүлчхээд ямар нэгэн байдлаар үйлдвэрлэлийн осолд оронгуут, эсвэл өтөл насанд чиний тэтгэвэр, тэтгэмж надад хамаагүй л гэсэн ийм харгис бодлого байхгүй юу. Тиймээс бид нийгмийн даатгалын шимтгэлийн ойлголтыг, нийгмийн ойлголтуудыг ер нь өөрчилмөөр байна. Ерөнхий сайдын ярьдаг нөгөө АМНАТ-ын татварыг ард иргэд ойлгодоггүй юм байна гэдэгтэй яг адилхан нийгмийн даатгалын шимтгэлийг шимтгэл, хураамж, татвар гээд ойлгочихсон. Уг нь энэ чинь ирээдүйдээ хийж байгаа хуримтлал байхгүй юу. Тиймээс энэ чиглэлээр бид ойлголтуудыг өөрчлөх зайлшгүй шаардлагатай гэж харж байна. Бас 1 өдрийн хөлсөөр ХАА-н салбарт ямаагаа самная гэж байна. Тухайлбал, өдөрт 70-80 мянган төгрөгөөр ямаа самнаад өгөөч, ногоогоо тарья 100 мянган төгрөг, Улаанбаатар хотод барилгын ажилд өдөрт 100 мянган төгрөг өгье гэхээр ирж ажиллах хүн ерөөсөө байхгүй байна шүү дээ.

Уг нь монгол хүний 1 цагийн ажлын хөлс 3929 төгрөг буюу 1 ам.доллар 10 цент байсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмснээр хамгийн багадаа 4715 төгрөг болсон сайн талтай гэдэг утгаар нь бид харах ёстой.

Хоёр дахь асуултад хариулахад минут хүрэхгүй байна. Би Малчны тухай хуулийн хэрэгжилтийн асуудлыг дэлгэрэнгүй хариулж өгье.

Л.Энхнасан: Сайдын минутыг нэмье.

Л.Энх-Амгалан: Энэ дээр бид ойлголтуудаа нэг болгож авах ёстой гэж бодож байна. Би ч бас хөдөөнөөс сонгогдсон гишүүн. Малчны тухай хуулийг хэрэгжүүлэхэд үүссэн асуудал бол өнгөрсөн хугацаанд бид нийгмийн даатгалын сан дээр маш их ачааллууд үүсгэж, улс төрийн үр дагавартай шийдвэрүүдийг гаргаж байсан. Бид 10 жилийг нөхөн тооцох тухай хуулийг баталж гаргасан. Эдийн засгийн өршөөл зарласан, малчдын тэтгэврийн насыг 5 насаар наашлуулсан, олон хүүхэдтэй эхчүүдийг хүүхдийн тоогоор 1,5 жилээр үржүүлж тэтгэвэрт гаргадаг тогтолцоонд шилжсэн гэх мэтээр Улсын Их Хурлаас гаргасан тогтоол шийдвэрүүдийн бүх ачааллууд өнөөдөр нийгмийн даатгалын сан дээр ирээд, эдгээр хуулиудыг өөрийн буюу нийгмийн даатгалын шимтгэл төлөгчдийн мөнгөөр хэрэгжүүлсэн. Нэг ёсондоо шударгаар нийгмийн даатгалын шимтгэлээ төлөөд, хуримтлал хийгээд явж байсан хүмүүсийн мөнгөөр нэг хэсэг улсуудад хөнгөлөлт өгсөн гэсэн үг байхгүй юу. Энэ бол 5,6 их наяд төгрөгийн бодитой ачааллыг нийгмийн даатгалын сан дээр үүрүүлсэн.

Уг нь шударга ёсоор яах байсан гэвэл Улсын Их Хурлын гишүүд хуулиа батлуулж болно, гэхдээ тэр хуулийг хэрэгжүүлэх эх үүсвэрийг төсөв дээр суулгаж өгөх ёстой байсан. Малчдын тухайд малчдын насыг 5 насаар наашлуулж тэтгэвэрт гарах хууль батлуулахад олон мянган малчид маань алга ташсан. Олон улс төрчид дахиж сонгогдсон. Гэхдээ хамгийн харамсалтай нь өнөөдөр нийгмийн даатгалын сан дээр маш том ачааллыг үүсгэсэн. Энэ нийгмийн даатгалын сан гэдэг чинь НДШ төлөгчдийн хуримтлал шүү дээ. Гэтэл малчдын тэтгэврийн насыг наашлуулсантай холбоотой хуулийг хэрэгжүүлснээр өнгөрсөн хугацаанд 68 тэрбум төгрөгийн ачааллыг бусдад нь үүрээд явж байна. Өөрөөр хэлбэл малчдын нэрийн өмнөөс бусад шударгаар шимтгэл төлсөн хүмүүс үүрээд явж байна. Одоо дахиад энэ хуулийг сунгая, малчдад ажиллаагүй, төлөөгүй шимтгэлийг нь дахиад олгоё гэсэн хуулийг намайг хэрэгжүүл гэж шахаж байгаа байхгүй юу. Би малчдадаа таалагдаж, Улсын Их Хуралд дахин сонгогдох улс төрийнхөө оноог харвал маш хурдан энэ хуулийг хэрэгжүүлнэ. Гэхдээ би Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд хийж байгаа тохиолдолд энэ хуулийг хэрэгжүүлэх иргэний ёс зүй алга. Бусдын төлж байгаа, бусдын хуримтлуулсан шимтгэлээс нэг хэсэг улсуудад хөнгөлөлт хийдэг энэ гашуун алдааг би дахиж үргэлжлүүлэхийг хүсэхгүй байна. Тийм учраас би Улсын Их Хурлын гишүүдээсээ хүсэхэд хууль хэрэгжүүлж болно. Гэхдээ энэ хуулийг хэрэгжүүлэхэд жил бүр 38 тэрбум төгрөгийн эх үүсвэр хэрэгтэй байна, Г.Тэмүүлэн гишүүн ээ.

Г.Тэмүүлэн гишүүн Улсын Их Хурал дээр их олон удаа дайрч, шүүмжилж байгаа. Би ч бас Г.Тэмүүлэн гишүүнээс илүү малчдадаа хайртай. Надад жил

бүр 38 тэрбум төгрөгийг улсын төсөв дээр тавьж өгөөч, М.Ганхүлэг гишүүн ээ. Ингэсэн тохиолдолд.../минут дуусав./

Л.Энхнасан: Б.Батжаргал дарга асуултад хариулах уу? 6 дугаар микрофон.

Б.Батжаргал: М.Ганхүлэг гишүүний асуултад хариулъя. 2024 оны жилийн эцсийн байдлаар сайн дурын даатгалд даатгуулсан хүний тоо 171,332 байгаа. Үүнээс малчин хүн 51,502 байна. Малчдын хувьд 2023 онд Улсын Их Хурлаас баталсан Нийгмийн даатгалын ерөнхий хуульд заасны дагуу шимтгэлийн 50 хувиар улсын төсвөөс, 5 жилийн хугацаанд төлүүлэх хуулийн зохицуулалттай байна. Сайн дураар даатгуулж байгаа иргэдийн зүгээс хамгийн их хүсэлт тавьдаг зүйл бол нийгмийн даатгалын үндсэн үйлчилгээнээс гадна банкны зээл авахад нотлох баримт болгож өгөөч гэсэн хүсэлт байдаг. Энэ асуудлаар НДЕГ-ын зүгээс арилжааны 13 банканд хүсэлт явуулсан. Энэ дээр Монголбанкны Ерөнхийлөгчийн баталсан журмаар сайн дурын даатгалаар төлж байгаа орлогыг тухайн иргэний өр, авлагын харьцаанд оруулах боломжгүй гэсэн заалт байдаг учраас боломжгүй гэсэн хариуг банкнууд ирүүлсэн.

Л.Энхнасан: Нэмж хариулна уу. 6 дугаар микрофон.

Б.Батжаргал: НДЕГ-ын зүгээс яамаараа дамжуулаад уг журамд өөрчлөлт оруулах тухай саналыг Монголбанкны Ерөнхийлөгчид уламжлахаар бид ажиллаж байна. Визний хувьд Монгол Улсад суугаа ЭСЯ, консулын газарт шууд хандах эрх манай Ерөнхий газарт байхгүй учраас яамаараа дамжуулаад энэ хүсэлтийг тавихаар ажиллаж байна. Баярлалаа.

Л.Энхнасан: М.Ганхүлэг гишүүн тодруулах уу?

М.Ганхүлэг: Хөдөө аж ахуй болон ЖДҮ-ийн салбарын хувьд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нэмэгдсэнтэй холбогдолтой ямар эрсдэлүүд тулгарч болох вэ? Сая сайд ажиллах хүчинтэй холбогдолтой асуудлыг бас хэллээ. Цагийн хөлс нэмэгдээд ажиллах хүчнийг ажиллуулахад хувийн хэвшил талаасаа газар тариалан, туслах малчин авахад улам л хүндрэлтэй болох эрсдэлүүд байна л даа. Мөн дээрээс нь ЖДҮ эрхэлж байгаа, шинээр эрхэлж байгаа хүмүүст энэ өөрчлөлтөөр ямар эрсдэл тулгарах вэ гэдэг дээр судалсан, анхаарсан зүйл юу байгаа тухай асуултууд юм. Үүнийг тодруулаад байгаа нь энэ өөрчлөлтийн хамгийн хүндээр тусаж байгаа хэсэг энэ юм. Тиймээс бид үл тоогоод, агуулгаараа зөв гэдэг байдлаар явах нь зөв үү, буруу юу гэдэг асуудал байна. Малчдын тухай асуудлыг бид дахиад сайн ярилцах ёстой. Аль болох талаас нь, энэ хуулийг хэрэгжүүлэх талаас нь бид авч үзэх.../минут дуусав./

Л.Энхнасан: Л.Энх-Амгалан сайд хариулна.

Л.Энх-Амгалан: М.Ганхүлэг гишүүн ээ, бид хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэгдүүлэх гээд байгаа нь 2 жил тутамд нэг биш, бараг жилд 2-оос доошгүй байгаасай л гэж бодож байгаа юм. Хөдөлмөрийн хөлсний доод

хэмжээ нэмэгдээд байхад Монгол хүний ажлын цалин хөлс нэмэгдэнэ. Мэдээж нөгөө талдаа бүтээмж гэдэг асуудлыг бид хэзээ ч мартаж болохгүй. Мэдээж бүтээмжийг бий болгож байж цалин хөлс нэмэгдэх ёстой. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нэмэгдчихээр хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа хүмүүс, жижиг аж ахуйн нэгжүүд хөлд нь чирэгдчихгүй биз гэдэг болгоомжлол байгаа. Тэрийг үгүйсгэхгүй. Гэхдээ бодит нөхцөл байдал дээр өнөөдөр сард 792,0 мянган төгрөгийн цалин авч байгаа хүн ер нь Монгол Улсад байна уу? Энэ чинь хуучин 600,0.../минут дуусав./

Л.Энхнасан: Нэмж хариулна уу.

Л.Энх-Амгалан: Аль болохоор монгол хүний цалин хөлсийг бүтээмжтэй нь уялдуулж сар бүр, жил бүр нэмэгдээд яваад байгаасай л гэж бодож байна. Ер нь Монголчууд тэнэг биш л дээ. Яагаад ажлын цагийн хөлс 4715 болчихоод байхад, 1 өдөр ямаа самнаад 100,0 мянган төгрөг өгье гэхэд ирж ажиллахгүй байна гэдэг нь тийм тэнэг, залхуудаа биш гэж ойлгоод байгаа. Бас халамж хавтгайрчихсандаа ч биш гэж ойлгож байгаа. Энэ бол Монгол хүн илүү бүтээмжтэй ажилладаг гэдэгтээ итгэлтэй, үүнээс илүү цалин хөлсөөр, Солонгост очоод хамгийн өндөр ур чадвартай, хамгийн өндөр цалинг өнөөдөр Монголчууд авч байна шүү дээ. Австралид очсон монголчууд барилгын төмөр бетон, зангидалт дээр хамгийн өндөр цалингуудыг авдаг. Монгол хүн ийм ур чадвартай учраас .../минут дуусав./

Л.Энхнасан: Баярлалаа. Сайдаа яаманд хэчнээн хүмүүс ямар түвшний цалин авсан, авч байгаа талаар сүүлийн үеийн судалгаа байна уу?

Л.Энх-Амгалан: Үндэсний статистикийн хорооноос Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал гээд судалгаа гаргадаг. Энэ дээр 2024 оны 4 дүгээр улирлын байдлаарх дундаж цалингийн мэдээлэл салбараар гардаг.

Л.Энхнасан: Тэгээд таны хэлж байгаа 792,0 мянгаас бага цалин авч байгаа хүмүүсийн тоо ер нь хэд юм бол?

Л.Энх-Амгалан: 550,0 мянган төгрөг хүртэлх цалин авч байгаа нийт 18 мянга гэсэн тоо байна. Гэхдээ энд цалингийн дансаа зөв бүртгэж байна уу гэдэг дээр миний хувьд эргэлзээ байгаа. Бодит амьдрал дээр эргэн тойрноо харахад сая төгрөгөөс доош цалин авдаг гэх хүмүүс цөөн байна гэж хараад байгаа. Тойрогтоо очиж уулзалт хийхэд ер нь монгол хүний өрхийн орлого, дундаж орлого нэмэгдэж байгаа. Үүнтэй уялдуулаад дундаж орлого .../минут дуусав./

Л.Энхнасан: Ц.Идэрбат гишүүн асуулт асууя.

Ц.Идэрбат: Байнгын хорооны гишүүдэд энэ өдрийн мэндийг хүргэе. Гурван асуулт байна.

Нэгдүгээрт, хэд хоногийн өмнө Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүнийг сонгох ажил зохион байгуулагдсан. Хуулиараа яам, ажил олгогч, үйлдвэрчний эвлэл гээд заагаад өгчихсөн. Энэ бүрэлдэхүүнд ахмадуудын төлөөллийг оруулах нь зүйтэй юм биш үү? Сонсголын зохион байгуулалтаас харахад “би эндээс гарч ирсэн хүн, би томилогдох ёстой” гэсэн ийм дүр зураг анзаарагдаад байгаа юм. Тэгэхээр квотынхоо асуудал дээр эргэж хараад, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн шийдвэрийн гол бүлэг нь ахмадууд байгаа учраас ахмадын төлөөлөл нь Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлдөө ороод ажиллавал шийдвэр зөв тал руугаа, амьдралтай гарах юм болов уу гэж харсан. Үйлдвэрчний эвлэлд нь ч байг, ажил олгогч нь ч байг, Засгийн газрын төлөөлөл нь ч байг. Энэ дээр ямар байр суурьтай байна вэ?

Хоёрдугаарт, цалин хөлстэй холбоотой асуудал дээр уг нь хууль, эрх зүйн орчинг нээгээд өгчихвөл ялангуяа хөдөө сум, багт ажлын байр нэмэгдэх нэг зүйл бол гэрээт малчны асуудал юм. Энэ асуудал одоогоор аман зохицуулалтаар явж байгаа. Үүнийг хууль, эрх зүйн хувьд зохицуулчихвал залуучууд мал маллаад, цалин хөлс бүх юм нь хуулийн хүрээнд зохион байгуулагдаад явчих бүрэн бололцоотой. Хэн нэгэн хүн сайхан ааштай үедээ аваад, саар ааштай үедээ чи яв гээд явуулчихдаг байдлаас болоод, эсвэл нөхөр нь ажил хийхгүйгээс болоод энэ том хөдөлмөрийн зах зээл хаягдчих гээд байдаг. Улсын Их Хурлын гишүүний хувьд би хууль санаачлаад явж болох ч яам өөрөө бүтцээ ашиглаад судалгаагаа хийгээд хөдөө аж ахуй, тэр дундаа мал аж ахуйн салбар дээр ажлын байр бий болгох зүйл хийчихмээр байна.

Би аймгийн Засаг дарга байхдаа гэрээт малчны асуудлаар хөтөлбөр хэрэгжүүлээд нэг жил орчим явж байсан, ковидын үед. Нааштай үр дүн дөнгөж гарч эхэлж байсан. Нэг нь малаа маллуулах, нөгөө нь мөнгө олох хэрэгцээ аль аль талдаа учраас яам ер нь ямар бодлоготой, ямар судалгаа хийсэн байдаг вэ?

Л.Энхнасан: Л.Энх-Амгалан сайд хариулъя.

Л.Энх-Амгалан: Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тэр гишүүн сонгох асуудал дээр манай яам тэтгэвэр авагчдын төлөөлөл буюу ахмадын холбооны төлөөллийг сонгож өгөөч гэдэг хүсэлтээ Нийгмийн бодлогын байнгын хороонд ирүүлсэн. Сонгон шалгаруулалтыг хуулиараа Нийгмийн бодлогын байнгын хороо хийдэг. Хуучин бол Сүхбаатар гуай төлөөлж байгаад хугацаа нь дууссан учраас оронд нь ахмадуудын төлөөлөл болох хүнийг Үндэсний зөвлөлийн гишүүнээр ажиллуулж өгөөч гэдэг хүсэлтээ ирүүлсэн. Энэ дээр Байнгын хорооны дарга хариулах болов уу гэж бодож байна.

Хоёрдугаарт, Хөдөлмөрийн тухай хуулиар туслах малчинтай холбоотой энэ зохицуулалтыг их сайн хийж өгсөн. Одоо харин бид малчдад сайн ойлгуулж өгмөөр байгаа юм. А.Ариунзаяа сайд байхдаа гэрээ хийх хэрэгтэй шүү гээд хөдөлмөрийн жишиг гэрээний загваруудыг нь хүртэл боловсруулж өгсөн. Нийгмийн даатгалын шимтгэлийг нэг нь төлөх ёстой гээд хэдэн үүрэг хариуцлагууд байдаг. Тэр үүрэг хариуцлагуудаа хэн хэн нь ойшоохгүй дундаа тохирох гэдгээс болж эрх ашиг нь хөндөгдөх асуудал байдаг. Цаашдаа Хөдөлмөр эрхлэлтийг

дэмжих сангаас малжуулах хөтөлбөртэйгөө уялдуулаад залуу малчид буюу туслах малчдыг дэмжих бодлого хэрэгжүүлэх ёстой гэж бодож байна. Малчдаас өөр ямар ч хүн өнөөдөр нийгмийн даатгалын шимтгэлийнхээ 50 хувийг төрөөр даалгаагүй, өөрөөр хэлбэл төрөөс малчдын нийгмийн даатгалын шимтгэлийн эхний 5 жилийнх нь 50 хувийг дааж байгаа. Уг нь эдийн засгийн хөшүүрэг, бодлогууд яваад байдаг. Гэтэл үнэндээ малчид маань жаахан, юу гэмээр юм зарим үг хэлчихээр хатуудчих гээд байдаг, ер нь бол бүтээмжтэй, хөдөлмөрөө зөв үнэлүүлсэн, хөдөлмөрийнхөө харилцааг зөв зохицуулсан харилцаанд орох нь зүйтэй болов уу. Сүүлийн жилүүдэд хэрэгжиж байгаа цагаан алт хөтөлбөр, ХАА-н салбарт хэрэгжиж байгаа хоршоог дэмжих зэрэг хөтөлбөрүүд хэрэгжих учраас хөдөө мал маллах, хөдөө аж ахуй эрхлэх ажилчдын хүсэл сонирхол нэлээн нэмэгдэж байгаа болов уу гэсэн хүлээлттэй байна.

Л.Энхнасан: Ц.Идэрбат гишүүн тодруулга хийнэ.

Ц.Идэрбат: Миний 3 дахь асуудал бол хууль, эрх зүйн орчноо сурталчлах ажлыг маш сайн хийхгүй бол энд яриад л байдаг, тэнд суманд байгаа төрийн албан хаагчид цааш нь хүргэж байна уу гэдэг чинь чухал асуудал болчихоод байна. Жишээ нь, энэ залуу малчны асуудлын тухайд, өвөл биднийг тойрогтоо ажиллаж байхад Дорнод аймгийн Цагаан-Овоо сумын Зүрхэт багийн малчин Оюунзүл гэдэг эмэгтэй “би нийгмийн даатгалын шимтгэлээ хувааж төлмөөр байна” гэдэг юмыг ярьсан. Гэтэл хууль дээрээ уг нь эхний сарыг нь төлөөд гэрээ байгуулаад явах боломжтой байгаа шүү дээ. Энэ дээр хэлэх гэсэн зүйл бол малчдын нийгмийн даатгалын шимтгэлийг 50 хувь хөнгөлж байгаа. Энэ чинь хугацаатай, хугацаа нь яваад байгаа. Дээрээс нь малчид сар бүр биш тодорхой хугацаанд гэрээ байгуулаад төлөх бололцоотой байгаа.

Л.Энхнасан: Л.Энх-Амгалан сайд хариулна.

Л.Энх-Амгалан: Ц.Идэрбат гишүүн маш чухал санал хэлж байна. Үнэхээр зовлонг нь мэддэг хүн, орон нутагт аймгийн Засаг даргаар ажиллаж байхдаа Дорнодын малчдын дунд их сайн жишиг дэлгэрүүлсэн юм байна лээ. Уг нь суман дээр нийгмийн даатгалын байцаагч, халамжийн гээд нийгмийн ажилтнууд байгаа. Анхан шатан дээр ажиллаж байгаа манай ажилтнууд батлагдсан хууль тогтоомж иргэдэд яг ямар давуу тал олгоод байгаа талаар байнга мэдээлэл өгч байдаг. Энэ тал дээр жаахан алдаа дутагдлууд байгаа, би тантай санал нэг байна. Тийм учраас жаахан хол сонсогдож магадгүй ч шинэ технологи нэвтрээд хиймэл оюун ухаанаар 24 цагаар малчдад ийм хөдөлмөрийн гэрээ хийх бололцоо байна, нийгмийн даатгалын шимтгэлээ бололцоотой үедээ.../минут дуусав./

Л.Энхнасан: Сайдын микрофоныг нэмж өгнө үү.

Л.Энх-Амгалан: Виртуал гээд ярихаар гадаад үг, харь ертөнцийн үгээр ярилаа гээд малчид маань шүүмжилж магадгүй. Гэхдээ өнөөдөр ухаалаг утас хүн бүхний өдөр тутмын хэрэглээ болчихсон. Монгол Улсад 1600 орчим хөдөөгийн багуудаас 1400 орчимд нь сүлжээ орчихсон. Тиймээс малчид маань ухаалаг

гар утсан дээрээ хөдөлмөрийн гэрээгээ хийчихэж болно. Бидэнд хуулиа энгийн үгээр ойлгуулах, тайлбарлах, сурталчлах, хуулиар нээгдэж байгаа боломжуудыг малчдад өгөх чиглэлээр цаг үеийнхээ эрэлт хэрэгцээнд нийцсэн ажлуудыг хийх шаардлагууд байгаа. Технологийн онцлогийг харуулсан шинэ бүтээгдэхүүн үйлчилгээнүүд удахгүй гаргаж ирнэ гэж бодож байна.

Л.Энхнасан: Ц.Идэрбат гишүүн тодруулъя, нэг минут.

Ц.Идэрбат: Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл дээр хуульдаа 3 яам, Үйлдвэрчний эвлэл, ажил олгогч гээд яг тэнцүү сайхан хуваачихсан байгаа шүү дээ. Танайхаас хүсэлт ирсэн байна лээ. Гэхдээ хуулиараа Үйлдвэрчний эвлэлээс ирсэн нэрэн дээр л бид ярих ёстой болохоос Үйлдвэрчний эвлэлийн хажуугаар яамнаас ирсэн нэрийг ярьж болохгүй байхгүй юу, хуулиараа. Тэгэхээр чинь Үйлдвэрчний эвлэлийн эрх ашиг хөндөгдөнө. Миний санаа бол энэ 9 хүний бүрэлдэхүүн дотроо ахмадын төлөөллийг оруулахаар хуульдаа өөрчлөлт оруулчихмаар юм гэсэн санаа. Магадгүй тэтгэврийн зээлтэй, тэтгэвэртэй холбоотой бидний болон төрийн албан хаагч нарын олж хараагүйг ахмадууд илүү олж харж, шийдвэрт тусгуулах байх.

Л.Энхнасан: Энэ асуудлыг бид Байнгын хороон дээрээ яриад Нийгмийн даатгалын ерөнхий хуульд Монголын ҮЭХ-ноос 3 төлөөлөл байх ёстой гэж Үйлдвэрчний эвлэлээс ирсэн нэрсийн дагуу сонгол хийж нэр дэвшигчийг сонгосон. Дараачийн удаа дахиад нэр дэвшигчийг бид сонгоогүй учраас дахиж сонголт явагдана. Энэ үед ахмадын холбооноос нэр дэвшигч ороход нээлттэй байгаа. Ер нь Нийгмийн даатгалын ерөнхий хуульд энэ Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн төлөөллийн талаар дахин ярьж өөрчлөлт хийх нь зүйтэй гэдэг дээр Байнгын хорооны гишүүд бид санал нэг байгаа. Энэ дээрээ бас анхаарч ажиллана.

Одоо Х.Булгантуяа гишүүн асуултаа асууя.

Х.Булгантуяа: Би асуулт асуухаасаа илүү санал хэлье гэж бодлоо. Бид хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг яагаад нэмчхэв гэдэг биш хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг яаж нэмэх вэ гэдэгт эсрэгээрээ Нийгмийн бодлогын байнгын хороо, Улсын Их Хурал ажиллах ёстой гэж бодож байна. Түүрүүн Л.Энх-Амгалан сайдын хэлснээр одоогийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр ажиллаж байгаа хүн бараг байхгүй. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг дорвитойхон нэмэхээр айдаг ганц юм нь төрөөс хариуцаж байгаа хүмүүсийн цалин хөлс, түүнтэй уялдуулж сайн дурын шимтгэл төлөгчдийн төлөх төлбөр л нэмэгдчихнэ гэж айгаад нэмж чадахгүй байгаад байдаг. Гэтэл ийм зүйлээс айсаар байгаад эсрэгээрээ өнөөдөр Монгол хүний хөдөлмөрийн үнэлэмж бага байгаа учраас чадвартай боловсон хүчнээ гадаад руу алдахаас эхлээд бидэнд асуудал их байна. 2023 онд хөдөлмөрийн зах зээлийн томоохон судалгаа хийгээд үзэхэд 2012-2022 оны хооронд цалин нэмэгдсэн байдалд нэрлэсэн цалинг ам.доллароор илэрхийлэхэд 2012 онд 410 ам.доллар 20 цент байсан.

2022 онд буюу 10 жилийн дараа 478 ам.доллар 20 цент. Өөрөөр хэлбэл манай хөдөлмөрийн хөлсний сарын дундаж цалин ерөнхийдөө олигтой нэмэгдэж чадаагүй, иргэдийн зүгээс хөдөлмөрийн үнэлэмж муу байна гэж хэлж байгаа нь бас аргагүй. 2023 оны 7 дугаар сард Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн 3 талт хэлэлцээрийг хийхэд тухайн үед Л.Энх-Амгалан сайд Боловсролын сайдын хувьд оролцож байсан. Сангийн сайд, ХЗДХ-ийн сайд, Эрүүл мэндийн сайд, сайд, ЗГХЭГ-ын дарга гээд анх удаа 5 сайд оролцож, тухайн үед С.Эрдэнэбат гишүүн Үйлдвэрчний эвлэлийн ерөнхийлөгч байсан. Ингээд аль аль талаасаа 5, 5 хүний төлөөлөлтэй оролцож байсан. Тэр үед хамгийн их яригдсан асуудал бол хөдөлмөрийн үнэлэмжийн асуудал. 1990 оноос 2005 оны хооронд 15 жилийн хугацаанд төрөлт огцом буурсан. Үүнээс үүдээд энэ үеийн 18-аас 35 насны хөдөлмөрийн зах зээлд орж ирж байгаа хүмүүс 250,0-300,0 орчим мянгаар цөөрсөн. Тэгэхээр төрөлт буурна гэдэг ийм үр дагавартай байдаг. Одоо манай ажил олгогчдын хувьд хамгийн том толгойны өвчин бол ажиллах хүн олдохгүй байна гэдэг асуудал. Одоо 1,2 сая хүн нийгмийн даатгалын шимтгэл төлж байгаа. Ц.Идэрбат гишүүний хэлж байгаа үнэн л дээ. НДШ төлөгч ажилчдыг ганцхан Үйлдвэрчний эвлэл, хуулиараа Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл дээр төлүүлнэ гээд оруулаад ирчихсэн. Гэтэл Үйлдвэрчний эвлэл нь 200,0 мянган гишүүнчлэлтэй. Одоо НДШ төлж байгаа хүн 1,2 сая, дээрээс нь 500 мянган хүн тэтгэвэр авч байна. Тэд өмнө нь төлчхөөд авч байгаа хүмүүс. Тэгэхээр 1,7 сая буюу төлсөн болон одоо төлж байгаа хүмүүсийг үйлдвэрчний эвлэлийн 200 мянган гишүүнчлэлтэй байгууллага ганцаараа, хуулиараа төлөөлнө гэдэг бол учир дутагдалтай. Тэр үнэн.../минут дуусав./

Л.Энхнасан: Тодруулга нэг минут өгье.

Х.Булгантуяа: Тухайн үед манай Үйлдвэрчний эвлэлийн байгууллага нэлээн уурласаар байгаад үүнийг хуульд оруулсан. Хамгийн харамсалтай нь өөрсдөө сая Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүнийг сонгох болоход маш хариуцлагагүй хандсан байна лээ. Зар тавьсан, нэг хүн материал өгсөн, түүнийг л л ирүүллээ шүү дээ гэсэн байдалтай бараг хандаж байна лээ. Тэгэхээр тэр ер нь буруу.

Тэгэхээр би ийм саналтай байна. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдаас асууя. Ер нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй холбоотой энэ хуулийг Хөдөлмөрийн тухай хуульдаа бүр шигтгээд өгвөл яасан юм бэ?

Хоёрдугаарт, хөдөлмөрийн үнэлэмжийг дээшлүүлэх талаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас цаашид ямар арга хэмжээ авах вэ? Иргэд бухимдаад байгаа, эдийн засгийн өсөлт иргэдийн амьдралд хүрэхгүй байна гэдэг бол үүний нэг тод жишээ. Монгол Улс эдийн засаг нь өсөөд байдаг, цалин болж амьдралд бууж байгаа нь харьцангуй бага. Энэ талаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас цаашид ямар арга хэмжээ авах вэ?

Л.Энхнасан: Л.Энх-Амгалан сайд хариулъя.

Л.Энх-Амгалан: Манай А.Ариунзаяа сайд, Х.Булгантуяа сайдууд маань мэргэжлийн сайдууд учраас дандаа асуудлын шийдлүүд ярьж байна. Бид энэ танхимд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг яагаад нэмэгдүүлсэн бэ гэж хэлэлцэхээс илүү хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг яаж нэмэгдүүлэх вэ гэдгийг хэлэлцэх нь илүү үнэ цэнтэй цаг хугацаа байна гэдэг маш том зөв өнцөг.

Тэгэхээр би түрүүн хэлсэн, Монгол Улсад ДНБ-д эзэлж байгаа бодит цалингийн зардал яг манайтай адилхан 4-өөс 6 хувийн эдийн засгийн өсөлттэй байгаа улс орнуудын хувьд бол их бага юм байна лээ. Сая Х.Булгантуяа сайд жишээ татаж хэллээ. Ам.доллороор илэрхийлэхээр ерөөсөө цалин нэмэгдээгүй байхгүй юу. Үндсэндээ сүүлийн 10 жилд ам.доллар руу шилжүүлэхээр цалин нэмэгдээгүй,. Энд мэдээж макро эдийн засгийн том үзүүлэлтүүд гарч ирнэ. Цаашдаа монгол хүний бүтээмжийг нэмэгдүүлэх чиглэл рүү бид анхаарах ёстой гэж бодож байна. Тэр утгаараа Засгийн газрын мөрийн хөтөлбөрт сүржин нэртэй байж магадгүй ч бүтээмжийн үндэсний хувьсгалыг нэвтрүүлэх талаар ямартай ч хөтөлбөрт туссан. Сая бид Азийн бүтээмжийн байгууллагатай хамтарч Монгол Улсад анх удаа монгол хүний бүтээмжийг нэмэгдүүлэх чиглэл рүү нэлээн том үндэсний хэлэлцүүлгүүдийг хийлээ. Удахгүй Монгол Улсын бүтээмжийн мастер төлөвлөгөөг Х.Булгантуяа сайд гаргах гэж байна. Хөдөө аж ахуйн салбарт цалин бага байгаа шалтгаан нь бүтээмжтэй холбоотой юм.

Өнөөдөр уул уурхай, банк, санхүү, мэдээлэл технологийн салбарт 5-8 сая төгрөгийн цалинтай байгаа нь тэнд бүтээмж өндөр байна. Тэгэхээр бид бүтээмж муутай буюу цалин хөлс бага байгаа салбаруудынхаа бүтээмжийг нэмэгдүүлэх, технологийг нэвтрүүлэх, ур чадварыг дээшлүүлэх чиглэл рүү маш том бодлого явуулах ёстой. Манай хөдөлмөрийн зах зээл дээр байгаа гажуудал бол ерөөсөө л хөдөлмөрийн хомсдолын гажуудал, эрэлт нийлүүлэлтийн гажуудал, мэдээж цалин хөлсний асуудал, бүтээмжийн асуудал байна. Хамгийн гол нь ур чадварын гайп(гар) зөрүү юм. Тийм учраас энэ ур чадварын зөрүүг арилгах.

Бүтээмж нэмэгдүүлж байж монгол хүн бүр 1 цагт ядаж 5-8 ам.доллар авах. Цаашдаа 1 цагт 10 ам.доллороор цалин хөлсөө үнэлүүлэх бүтээмжтэй ард түмэн болохын төлөө бид явах ёстой гэж бодож байна. Би аж ахуйн нэгжүүдийн захирлуудаас уриалахад, би ч гэсэн хувийн хэвшилд ажиллаж байсан. Манай аж ахуйн нэгжүүдийн орлогын ашгийн хувь их өндөр юм байна лээ. Хурдан морь авах болохоор хэдэн тэрбумаар авдаг, 5, 10 ажилчдынхаа цалинг 10, 20 хувиар нэм гэхээр НДШ дарамт болж байна гээд суудаг байж болохгүй. Тиймээс Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн сайдын хувиар би онцгойлж хэлье гэж бодож байна.

Ажил олгогч, баялаг бүтээгчдэд маш чухал, том ачаалал үүсэж байгаа. Гэхдээ ашгийн маржен (margin) манайхан шиг ийм өндөр байдаг улс орнууд их ховор болчихсон шүү. Ашгийн маржен өндөр байна гэдэг бол ажилчдадаа бага цалин өгч байна л гэсэн үг. Тэгэхээр энэ чиглэл рүү бид цалин хөлсний бодлого, бүтээмжийнхээ бодлогыг зайлшгүй өөрчлөх цаг болсон. Тэгэхгүй бол монгол хүн эх орондоо ажиллах, хөдөлмөрлөх сонирхол маш их буурч байна.

Би түрүүн жишээгээр хэлсэн, өнөөдөр Австралид барилгын арматур зангидалт дээр 7 мянган залуучууд ажиллаж байгаа юм байна лээ. Үндсэндээ Австралийн барилгын зах зээл дээр энэ 7 мянган залуучууд арматур зангидалтаар үнэ тогтоож байгаа, гэх мэтээр монгол залуучуудын ур чадвар, бүтээмж бол үнэхээр өндөр. Харин эх оронд нь бид яаж бүтээмжтэй, ур чадвартай залуучуудын өндөр цалинтай, ажлын байруудыг бий болгох вэ гэдэг л манай улсын том зорилт байх болов уу гэж бодож байна.

Тэр хүрээндээ Засгийн газраас нэг хүнд ноогдох ДНБ-ийг 10 мянган ам.доллар хүргэе гэж зориод байгаа нь монгол хүний цалин хөлс хамгийн багадаа 1000 ам.доллар болох зорилтыг тэр 14 мега төслөө хэрэгжүүлж чадвал энэ зорилтод хүрэх цаг хугацаа их ойрхон байна гэдгийг уялдуулж тайлбарлая гэж бодсон юм.

Л.Энхнасан: Баярлалаа. Б.Бейсен гишүүн асуултаа асууя.

Б.Бейсен: Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 792,0 төгрөг болчихсон. Баруун алслагдсан бүс нутагт энэ хүрэлцээтэй юу? Жишээлбэл, бид сая гурилын импортын татварыг тэглэсэн юуг аваад хаячихлаа. Булган сум гэхэд аймгийн төвөөс 317 км. Улаанбаатараас хоёр мянгаад километр хол шүү дээ. Нэг шуудай гурилыг 200,0 – 250,0 мянган төгрөгөөр, 1 тонн нүүрсийг 280,0 – 350,0 мянган төгрөгийн хооронд авдаг. Одоо бензин шатахуун нэмэгдсэн. Тэгэхээр бүсийн нэмэгдлийг олгож байгаа юу? Хэдэн төгрөг олгодог вэ? Жишээ нь, өндөр насны 2 хүн байлаа гэхэд тэтгэвэр нь хоол хүнсэндээ ч хүрэхгүй. Бензин шатахуундаа ч хүрэхгүй болохоор эмнэлэг явж чадахгүй асуудал үүсээд байгаа. Булган сумын хувьд иргэдийн бараг 30-40-өөд хувь нь нүүчихсэн гэхэд хилсдэхгүй байх. Энэ асуудлыг яаж шийдэх вэ?

Л.Энхнасан: Л.Энх-Амгалан сайд хариулъя.

Л.Энх-Амгалан: Б.Бейсен гишүүн бүсийн нэмэгдэл гэдэг ойлголт төрийн албан хаагч нарт байгаа. Тэр тусмаа төрийн тусгай албан хаагч нар, хилийн цэрэг дээр энэ нэмэгдлүүд байдаг. Хоёрдугаарт, өнгөрсөн жилээс эхлээд хөдөө суманд ажиллаж байгаа төрийн албан хаагч нарт сумын нэмэгдэл гэж 40 хувь, аймгийн төв дээр 20 хувь олгож байгаа. Ийм нэмэгдлүүд байна. С.Бямбацогт гишүүн гээд байнга бүсийн нэмэгдэл ярьдаг гишүүд бий л дээ. Бид хүн амын орлогын албан татвар дээр тодорхой шинэчлэл хийхээр Засгийн газар ажиллаж байгаа. Удахгүй Улсын Их Хурал дээр хүн амын татварын шинэчлэл, нийгмийн даатгалын шимтгэлийн реформуудыг хамтарч оруулж ирэхээр тооцоо, судалгаанууд хийгдэж байна. Улаанбаатараас алслагдах тусам бараа бүтээгдэхүүнүүд хөдөө орон нутагт хямд, иргэдийнх нь орлого өндөр, нэмэгдлүүд нь өндөр байх тогтолцоо руу шилжих бодлогын шийдлүүдийг хийх судалгаанууд гаргаж байна гэдгийг хэлье.

Л.Энхнасан: Б.Бейсен гишүүн тодруулга асууя.

Б.Бейсен: Л.Энх-Амгалан сайд аа, бүсийн нэмэгдлийг асууж байгаа нь жишээлбэл, Булган суманд бензин шатахуун 4,0 мянган төгрөг, цахилгаан нь нэмэгдээд л бүх хүнс, өргөн хэрэглээний бараа үнэтэй болдог. Тэгэхээр бүсийн нэмэгдлийг зөвхөн төрийн үйлчилгээний албан хаагч, төрд ажиллаж байгаа хүмүүст олгож байгаа юу? Ажилгүй хүмүүст олгох уу? Ажилгүй хүмүүс, өндөр настан тэтгэвэрийн хүмүүст бүсийн нэмэгдэл гэж авдаг хүн байхгүй байна. Бодит байдал дээр үүнийг яах вэ?

Л.Энхнасан: Л.Энх-Амгалан сайд хариулна.

Л.Энх-Амгалан: Хүн бүр л ажил хөдөлмөр эрхлэх л эрхтэй л дээ. Халамж хэрээс хэтэрсэн гэдэгт бид санал нэг байгаа. Тийм учраас удахгүй Улсын Их Хурал дээр бид Нийгмийн даатгалын багц хууль, Халамжийн багц хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулиуд, Гэр бүлийг дэмжих тухай хуулиудаа багцаар нь өргөн барихаар бэлдэж байна. Энэ хүрээндээ татварын реформуудыг хийнэ. Тэгэхээр мэдээж баруун бүсэд, бүсчилсэн хөгжлөөр хөгжих хөгжлийн шинэ боломж хаалгууд нээгдэж байгаа учраас баруун бүсэд аль болохоор мега төслүүдийг хэрэгжүүлэх, Эрдэнэбүрэнгийн УЦС-аас авахуулаад аж үйлдвэрүүдийн томоохон төслүүдийг хэрэгжүүлэх, ажлын байр бий болгох чиглэл рүү бодлогоо барьж байж бид хүмүүсээ ажилгүйдэл, ядуурлаас гаргахаас өөр шийдэл байхгүй болов уу гэж би бодож байна.

Л.Энхнасан: Б.Бат-Эрдэнэ гишүүн асуултаа асууна.

Б.Бат-Эрдэнэ: Нийгмийн хамгааллын сайдаар ажиллаж байгаагүй учраас магтуулахгүй байх. Бид олон асуудлуудыг хөндөж байгаа. Халамж биш хөдөлмөр эрхлэлтийн асуудлыг хөндөж байгаад баяртай байгаа. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны явж байгаа үндсэн чиг зарчим ний нуугүй хэлэхэд Л.Энх-Амгалан сайдын үед нэлээн сайн явах болов уу гэсэн итгэл үнэмшилтэй байгаа. НДШ бол хуримтлал юм гэдгийг сая Л.Энх-Амгалан сайд өөрөө хэллээ.

Шударгаар хөдөлмөрлөж байгаа хүмүүсийн мөнгийг шударга бусаар халамж авч байгаа нөхдүүд хүртэж байна гэдэг агуулга ч юм уу, нэг талдаа. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэх тусмаа сайн л даа. Заавал 2 жил хүлээгээд байхгүй нэмээд явж л байвал сайн. Халамж биш хөдөлмөр эрхлэлт нэмэгдэж л байвал сайн. Болдог бол аль аль талдаа л байнга нэмж баймаар л байна. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэгдүүлснээр хөдөө орон нутагт ажил эрхлэлттэй холбоотой нөлөөллийн судалгаануудыг хийдэг юм болов уу? Тухайлбал, орон нутагт ажлын байр нэмэгдэх үү, эсвэл нөгөө талдаа зардлын дарамттай холбоотойгоор буурах уу? Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам судалгаа хийсэн бол яг тэдэн оны тийм судалгаанаас тийм үр дүн гарсан гэдгээ тайлбарлаад өгчихмөөр байна.

Хоёрдугаарт, нийгмийн даатгалын шимтгэлийн өөрчлөлттэй холбоотой иргэдэд үзүүлж байгаа нөлөөллийн асуудал байна. Би сая хэлсэн. Доод хэмжээ нэмэгдээд л байвал сайн. Гэхдээ шимтгэлийн асуудал яригдана. Шимтгэлийн

нэмэгдэл яг иргэдийн орлого дээр хэрхэн нөлөөлж байгаа судалгаа байгаа юу? Үүнийг бас Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам яг тэдэн сарын тэдэнд тийм судалгаа хийсэн, тийм байдлаар нөлөөлөл үзүүлж байна гэдгийг тайлбарлаад өгчихмөөр байна.

Нөгөө асуудал нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сантай холбоотой асуудал. Энэ сангаас олгож байгаа санхүүжилт ажилгүйдлийг бууруулахад бодитой хувь нэмэр оруулж байгаа юу? Энэ дээр үнэлгээ хийсэн үү? Хийсэн бол яг ийм бодит үр дүн байгаа гэдгээ яамныхан маань хэлээд өгвөл их сайн байна.

Түрүүн Х.Ганхуяг гишүүн ч хөндлөө. Би Л.Энх-Амгалан сайдын ярианаас таныг сайд байх хугацаанд хуулийн хэрэгжилтийг хангуулахгүй юм байна гэж ойлголоо. 2024 оны 6 дугаар сарын 05-ны өдөр батлагдсан хууль. Парламентад М.Ганхүлэг гишүүн бид 2 тэр үед байгаагүй. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд маань өөрөө байсан. Нэг талдаа та бүхний л баталсан хууль шүү дээ. Хуулиа баталчхаад дараагаар нь энэ асуудалтай юмаа хэрэгжүүлэхгүй гээд суугаад байж болохгүй л дээ. Эсвэл М.Ганхүлэг гишүүнийг 38 тэрбум төгрөг олоод ир гэж байх шиг байна. Улсын Их Хурлын гишүүд боломжоороо төсөв тавиад хууль хэрэгжих ёстой учраас хуулийнх нь дагуу л тавиад явах ёстой.

Л.Энхнасан: Нэмэлт нэг минут.

Б.Бат-Эрдэнэ: Тэгэхээр Малчны тухай хуульд төрөөс баримтлах бодлого 4.29 дээр хуульд заасан өндөр настны тэтгэвэр тогтоолгоогүй малчны тэтгэврийн даатгалын шимтгэлийг нэг удаа нөхөн төлүүлнэ л гээд оруулчихсан шүү дээ. Хэрэгжүүлэхгүй юмыг яах гэж оруулсан юм. Энэ популизмын чинь үр дүнг өнөөдрийг хүртэл бид хүртээд явж байгаа л хэлбэр шүү дээ. Нийгмийн даатгалын сан даахаа больчихлоо гээд та өөрөө сая маш олон жишээ ярилаа. Маш олон популизмуудын л үр дүн. Нөгөө талдаа сонгуульд чиглэсэн үйл ажиллагааны чинь үр дүн. Анхнаасаа эх үүсвэр тодорхой юмнуудыг бид маш сайн бодох л ёстой байсан. Нэгэнт хууль гарчихсан, тогтоол гарчихсан, хэрэгжих ёстой. Маш олон малчид энэ дээр итгэл үнэмшлээ өгчихсөн. Үүний хүрээнд магадгүй МАН санал авсан байх. Энэ дээр тодорхой хариултуудыг аваад нэмэлт асуулт асууя.

Л.Энхнасан: Л.Энх-Амгалан сайд хариулна уу.

Л.Энх-Амгалан: Хамгийн сайн халамж бол хөдөлмөр эрхлэлт гэж бодож байгаа. Тийм учраас өнгөрсөн хугацаанд халамжийн чиглэлээр хийсэн төсөл, хөтөлбөрүүдэд бид үнэлгээ хийсэн. Би буруу санаагүй бол өнгөрсөн намар 2 удаа Байнгын хорооны бүх гишүүдэд нийгмийн хамгааллын болон халамжийн чиглэлээр ийм ийм бодлогууд, хөтөлбөрүүд хэрэгжиж, ийм ийм үр дүн өгсөн байна гэдэг агуулгатай цэнхэр ном өгсөн, Б.Бат-Эрдэнэ гишүүн ээ. Бүх гишүүдэд өгсөн. Тэр дээр үнэлгээнүүд байгаа. Энэ номыг би танд дахиж хүргүүлье. Бараг анх удаа өнгөрсөн хугацаанд халамжийн чиглэлээр авч хэрэгжүүлсэн, нийгмийн хамгааллын чиглэлээр хэрэгжүүлсэн хөтөлбөрүүд дээр үнэлгээ хийсэн анхны тохиолдол болов уу гэж бодож байна.

Энэ дээр үндэслэж бид цаашдаа Монгол Улсад нийгмийн хамгааллын тогтолцооны зураглал хийж байгаа. Системийн шинжилгээ хийлгэсэн. А.Ариунзаяа, Х.Булгантуяа нарын сайдуудын үеэс хийж байсан ажлууд ингээд үргэлжлээд одоо тогтолцооны зураглалууд гарч ирж байна. Удахгүй бид нийгмийн хамгааллын багц хууль болох Нийгмийн даатгалын багц хууль, Халамжийн багц хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Гэр бүлийг дэмжих тухай хууль ингээд ер нь багцаар нь өргөн барих гэж байна. Үүнийг тогтолцооны шинэчлэл гэж харж байгаа. Манай яаманд судалгааны институт байдаг. Энэ институтийг бид жинхэнэ утгаар нь судалгааны эрдэм шинжилгээний хүрээлэн болгон зохион байгуулалт хийж байна. Цаашдаа энэ салбарын статистик мэдээллүүдийг, их өгөгдөлд суурилсан платформуудыг бид хөгжүүлж байна. Эхний дашбоардуудаа та бүхэнд танилцуулсан. Гадаадын донор орнууд, хандивлагч орнуудын шүүмжлээд байгаа зүйл бол биднийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, халамжийн хөтөлбөрүүд хэрэгжүүлж болно. Гэхдээ нэгдүгээрт, та нар зорилтот бүлэгтээ ерөөсөө хүргээгүй байна. Зорилтот бүлгээ тодорхойлж чадаагүй байна. Өөрөөр хэлбэл нийт халамжид зарж байгаа 100 төгрөгийн чинь 26 төгрөг нь дандаа өндөр орлоготой иргэдэд очоод байна гээд байгаа шүү дээ. Тийм учраас зорилтот бүлэгтээ ерөөсөө тодорхойлж чадаагүй.

Хоёрдугаарт, та нарын хэрэгжүүлж байгаа хөтөлбөрүүд дуусдаггүй юм байна. Уг нь халамжийн хөтөлбөрүүд, хөдөлмөр эрхлэлтийн хөтөлбөрүүд бусад улс орнуудад хугацаатай хэрэгждэг. Хэзээ эхлэх, хэзээ дуусах, ямар үр дүнд хүрэх гэдэг. Бодлогын шинжилгээнүүдээ хийдэг, бодлогодоо үнэлэлт дүгнэлт хийдэг тогтолцоо бүтцийг яамандаа бий болгож байгаа. Энэ чиглэлээр нэлээн ахиц дэвшил гарах болов уу гэсэн хүлээлтүүд байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас хэрэгжүүлсэн 6 хөтөлбөрийн хөтөлбөр нэг бүрээр нь Монгол Улсад зарласан. Жил бүхэн 130 тэрбум төгрөг зарж байгаа энэ сангийн хэрэгжүүлж байгаа хөтөлбөрүүд жил бүхэн хэдэн ажлын байрыг бий болгов. Түүний хэд нь тогтвортой ажлын байр, хэд нь улирлын шинж чанартай ажлын байр бий болгов гэдэг судалгааг салбарын эрдэмтдийг цуглуулсан ажлын хэсэг гаргаж байна. Тайлангууд нь удахгүй гарахаар Байнгын хорооныхоо гишүүдэд хүргэнэ гэсэн бодолтой байна.

Таныг ойлгож байна Б.Бат-Эрдэнэ гишүүн ээ. Тойргийн гишүүн болчихсон зовлон их байгаа. Би ч хөдөөгийн тойргоос 4 удаа сонгогдсон. Засгийн газар, Засгийн газрын гишүүн хууль хэрэгжүүлэх үүрэгтэй. Хууль хэрэгжүүлэхгүй гэдэг үг Засгийн газрын гишүүний амнаас гарч болохгүй. Хуулийн хариуцлага хүлээнэ. Засгийн газар хууль дээдлэх зарчмыг баримталж ажилладаг. Нэгэнт хууль батлагдсан бол Засгийн газар хэрэгжүүлэх ёстой. Гэхдээ энэ хуулийг хэрэгжүүлэх журмыг Засгийн газар батална гэсэн ийм зохицуулалттай.

Энэ журам нь батлагдаагүй байна. Журмаа баталж энэ хуулийг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэр 2025 оны улсын төсөв дээр тусгагдаагүй учраас хуулийн заалтыг хэрэгжүүлэхэд маш том хүндрэл учирч байна гэж харж байгаа. Би таныг популист улс төрчдийг дагасан ийм шинэ популист улс төрч битгий байгаасай гэж хүсэж байна. Асуудалд их прагматик ханддаг хүн та. Тийм учраас улс төрчдийнхөө муу жишгийг, алдааг бид давтаж болохгүй. Малчны

тухай хуулийн хэрэгжилтүүдийг хангах журмаа нэгдүгээрт баталъя. Журмаа хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэр нь хэрэгтэй учраас та бүхэн 2026, 2027 оны улсын төсөв дээр тусгаад өгөөрэй. Тэгвэл энэ хууль хэрэгжих бүрэн боломжтой гэдгийг хариуцлагатайгаар хэлье.

Л.Энхнасан: Баярлалаа. Б.Бат-Эрдэнэ гишүүн тодруулга нэг минут.

Б.Бат-Эрдэнэ: Таны өөрийн чинь л хэлсэн үг шүү дээ. Би Нийгмийн хамгааллын сайд байхдаа үүнийг хэрэгжүүлэхгүй л гэсэн шүү дээ. Таны хэлсэн үг дээр л би асуусан. Мөнгийг чинь төсөвлөөд өгөх ёстой. Тэрэн дээр явах ёстой. Та саяынхаа хариултыг Л.Ганхүлэг гишүүний үгэн дээр хэлчихсэн бол тэгээд л болоо байхгүй юу. Популизм хийх гээгүй. Өнөөдөр популизмын үр дүн, нөлөөллийг бид улсаараа амсаж байгаа.

ТАЗ-ийн ажлын албаны маргаан хянах газрын ахлах референт ингэж мэдэгдсэн байна. Хуурамч дипломоор төрд ажилласан хүмүүсийн төрөөс авсан бүх цалинг буцаан төлүүлнэ гэж. Би буруу санаагүй бол 2015 оноос хойш тушаал гаргасан албан тушаалтан нь төлөөд явж байсан санагдаж байна. Одоо ажилд орсон хүмүүс нь төлөх юм байна. Ингэж болдог юм уу?

Л.Энхнасан: Сайд хариулах уу? За С.Эрдэнэбат гишүүн асуултаа асууя.

С.Эрдэнэбат: Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг сайн ярья гэж бодоод байсан, ашгүй манай 3 сайд маань яг зэрэгцээд гоё сууж байна. Би гурвуулантай нь хэлэлцээрт ороод хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмсэн. Хамгийн сүүлд А.Ариунзаяа сайдын үед, дараа нь Х.Булгантуяа сайдын үед. Л.Энх-Амгалан сайд маань энэ уламжлалт 3 талт хэлэлцээрээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 жилд огцом нэг удаа нэмэх биш жил бүр нэмээд явъя, шаардлагатай бол жилдээ 2 удаа бууруулж ч болно шүү дээ. Хуулийн ийм заалт байдаг. Тэр утгаараа Л.Энх-Амгалан сайд Засгийн газрынхаа залгамж чанарын үүднээс асуудалд шуурхай, ажил хэрэгч хандаж нэмэгдүүлэхэд хүчин чармайлт гаргасан хүний хувьд би эхлээд баяр хүргэе. Хоёр сайд ч болон асуулга тавьсан сайд ч гэсэн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэхэд хувь нэмрээ оруулсан сайд нар, талархаж явдаг.

Хоёрдугаарт, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй холбоотой хэлэхэд манай улс ер нь Африкийн урдуурхан л яваад байгаа юм. Өдөрт 10 ам.доллар л байна. Өдөрт шүү дээ. Цаашдаа эдийн засгийнх нь утгаар нь тооцоод томъёолоод дотоодын бүтээгдэхүүнтэй харьцуулаад үзэхээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 1 сая 900 орчим мянган төгрөг байх ёстой байгаа юм. Энэ нь хэрвээ бид нийгэмд байгаа нийт баялгаа зөв, шударгаар хуваарилж чадсан бол гэдгийг би хэлмээр байна.

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг есөн жорын юмтай холиод утгыг нь алдагдуулаад хийчихжээ, хэдүүлээ. Тийм учраас энэ тал дээр ярилцъя, зөвлөлдье. Ажлын байрны төлбөр гэхээр 10 сая төгрөгийн ажилтай хүн ч, 2 сая, 1 сая ч адил хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нугалж төлдөг. Сая төгрөгийн

цалинтай гадаадын ажилтан ч яг ижилхэн төлж байдаг. Тэгэхээр бид өөрчлөлт хийх юм цаана нь байгаа.

Дараа нь, тэтгэвэртэй холбоотой асуудал ярихад маш олон ахмадууд залгаад байна. Одоо гол нь тэтгэврийн зээлийг хязгаарлаад 30 хувьд л авахаар боллоо. Манай нийт тэтгэвэр авагчдын 70-80 хувь нь үндсэндээ бага, дунд тэтгэвэр авдаг. 700,0 – 800,0 орчим мянган төгрөгийн асуудал тавиад байсан. Энэ дээр Л.Энх-Амгалан сайд тодорхой хариулт өгөөч. Маш олон ахмадууд хандаж байгаа учраас танд хандаж асууж байна. Арай чангадчихсан юм биш үү гэдэг тал дээр та хариулт өгөөрэй.

Тэр 3 талт механизмыг би тодруулаад асууя. Тэтгэврийн даатгалын санг манаж байгаа энэ 3 талт механизм гэдэг дээр хуульд энэ зарчмыг барьж л хийсэн. Хэн нэгэн, байгууллага гэхээсээ илүүтэйгээр. Тэгэхээр ахмадын холбоо ч гэх мэт ийм байгууллага орсон улс орон байдаг уу? Сүхбаатар гуайг ахмадын холбооны хувьд хуучин Үйлдвэрчний эвлэлийн холбооноос нэр дэвшээд орж ирсэн юм байна лээ. Дахиад нэр дэвших нь нээлттэй. Тийм учраас ороод ирвэл дэмжихэд бэлэн. Энэ дээр тодруулга аваад.../минут дуусав./

Л.Энхнасан: Л.Энх-Амгалан сайд хариулна уу.

Л.Энх-Амгалан: Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэх энэ шийдвэрүүд дээр манай С.Эрдэнэбат гишүүн манлайлж Үйлдвэрчний эвлэлийн Ерөнхийлөгч байхдаа манлайлж ажилласан. Улсын Их Хурал дээр ч гэсэн энэ асуудлаар дуу хоолой болоод ажиллах байх, тантай санал нэг байна. А.Ариунзаяа сайдын асуулгын санаа ч гэсэн Хөдөлмөрийн хууль нь шинэчлэгдчихсэн байхад хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг зохицуулдаг хууль маань нэлээн олон жил шинэчлэгдээгүй учраас цаг үеийнхээ шаардлагыг хангаж чадахаа больсон гэж байна. Үндсэндээ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ гэдэг бол бараг шимтгэл төлөхөд тооцдог ийм л механизм болчихоод байгаа байхгүй юу. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр өнөөдөр цалин авч байгаа иргэд бараг байхгүйг би хэлсэн. Түрүүн манай Байнгын хорооны дарга ч гэсэн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр цалин авч байгаа хүн Монгол Улсад хэд байна гээд асуугаад байсан. Статистик хараад байхад үнэхээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр цалин авч байгаа хүн их л бага л болчихсон тоо харагдаад байгаа юм. Цалингийн дундаж хэмжээ бараг 2,4 саяд хүрчихсэн байгаа. Дээд цалин 5 сая, 8 сая хүрчихсэн. Гэхдээ энэ цөөхөн хүмүүсийнх гээд манай иргэд шүүмжлээд байдаг. Энэ нөгөө уул уурхай, банк санхүү, мэдээлэл технологийн салбаруудад ийм өндөр цалинтай явдаг. Гэхдээ ямар ч байсан улсын хэмжээнд энэ 2 дугаар улирлын байдлаар дундаж цалин ийм үзүүлэлттэй гараад байгаа юм. Тийм учраас бидний гол зорилго бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тооцох аргачлалаа шинэчилье, хуулиа шинэчилье, С.Эрдэнэбат гишүүн ээ. Монгол хүний нэг цагийн цалин хөлс дор хаяж 5-аас 8 ам.долларт эхний ээлжинд хүрэх, цаашаа 10 ам.долларт хүрдэг ийм бүтээмжтэй ард түмэн байх ёстой гэдэг дээр би тантай санал нэг байна.

Ахмадын тэтгэврийн зээлийн асуудал байгаа. Энэ уг нь Үйлдвэрчний эвлэлээс ч, Ахмадын хороо, Ахмадын зөвлөлөөс ч гэсэн ийм санал гаргасан. Ахмадын зээл гэдэг бол тухайн өрхийн орлогын амьжиргааны асуудал байдаг учраас их эмзэг асуудал. Ахмадууд чинь авч байгаа зээлээ өөртөө биш, үр хүүхдэдээ зарцуулчхаад байгаагаас болж өрхийн орлого нь буураад байна гэдэг нийтлэг асуудал байгаа гэдэгтэй хүн бүр санал нэг байх шиг байгаа юм.

Гэхдээ би ахмадуудад нэг зүйлийг хэлье. Тэтгэвэр бол та бүгдийн өмч. Өмчөө захиран зарцуулах нь та бүгдийн эрх. Та бүгдийн эрхэд хөндлөнгөөс хэн ч оролцох эрхгүй. Энэ дээр л би та бүхэнтэй санал нэг байгаа. Гэхдээ ахмадын амьжиргааны асуудал бол төрийн бодлого, төрийн хамгаалалт, нийгмийн хамгаалал байх ёстой. Тийм учраас нийгмийн хамгааллын бодлого, төр засгийн бодлого энэ рүүгээ чиглэх ёстой. Үндсэндээ ахмадын тэтгэвэр дээр саяын авсан арга хэмжээ жаахан цочмогдсон байхыг үгүйсгэхгүй. Яагаад гэвэл манай нийт ахмадуудын бараг 48-аас 52 хувь нь бага тэтгэвэр авдаг. Жишээ болгож нэг тэтгэвэр авагчаар ярихад 650,0 мянган төгрөгийн тэтгэвэртэй ахмад байхад тэрнийх нь 470,0-480,0 мянгыг нь амьжиргаандаа авч үлд ээ, үүнийхээ зөрүүгээр зээл ав гэхээр сарын 200,0 мянга хүрэхгүй буюу жилийн 2,4 сая төгрөгийн зээл аваад ахуй амьдралдаа тохиолдсон зүйлээ шийд гэж хэлэхэд жаахан хатуудаж байгаа нь үнэн. Тиймээс нөхцөл байдалд бид дүгнэлт хийж Монголбанкттай ярилцсан. Гэхдээ бид зээлийн хүү, зээлийн хэмжээг тогтоодоггүй шүү дээ. Монголбанкны мөнгөний бодлогын газраас арилжааны банкууддаа чиглэл өгч зохицуулж явах учраас арилжааны банкнуудтай хэлэлцээр хийж саяын зохицуулалтуудыг ямар ч байсан амьдралд нийцсэн, тэр тусмаа бага тэтгэвэр авч байгаа хүмүүс тэтгэврээ барьцаалж зээл авбал өөрийнх нь эрэлт хэрэгцээнд нь нийцсэн зохицуулалтууд байх ёстой юм байна гэдэг дээр Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэнтэй тохиролцсон. Ирэх 7 хоногт Бодлогын зөвлөлөө хуралдуулъя гэсэн болохоор тодорхой шийдлүүд гарах болов уу гэсэн хүлээлттэй байна. Эхний ээлжид ямар ч байсан авч байгаа цалингийн 50 хувийг өөртөө үлдээж, 50 хувиар нь зээл авдаг байдлаар, ийм зохицуулалтын асуудлаар Ц.Идэрбат гишүүн ч гэсэн Монголбанк руу асуулга асуусан байна лээ. Энэ асуудлаар удахгүй шийдлүүд гарах болов уу гэсэн хүлээлттэй байна.

Л.Энхнасан: Тодруулга нэг минут.

С.Эрдэнэбат: Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй холбоотойгоор ЖДҮ эрхлэгч нарт хүнд цохилт болж байгаа гэдэг нэг талаас харах өнцөг мөн. Нөгөө талдаа хэрвээ энэ цалинг өгч чадахгүй бол цагаар тогтоосон учраас заавал 8 цаг ажиллуулах биш 5 цаг ажиллуулах, тэр хүнийг 3 цагтаа өөр боломжтой газар ажиллах боломжийг нээх юм. Гэтэл шууд автоматаар сараар нь үржүүлээд 792,0 мянгаас л заавал төл гэдэг хуулийн зохицуулалт руу аваачиж тавьчхаад байгаа учраас нөгөө талын энэ боломжийг олж харахгүй байгаа юм. Хуулиар бол цагаар тогтооно гэсэн, яг сараар тогтооно гэсэн юм байхгүй. Тийм учраас хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нэмэгдчихээр ЖДҮ эрхлэгч нар дампуурна, унана гээд л, үнэндээ манай жижгүүд нэг их ярьдаггүй шүү дээ. Харин том компаниуд л тэр ажлын байрны төлбөрөөс нэмчих болов уу, нөгөө талаас дээд цалингийн төлдөг хэмжээ гэдэгтэй холбоотойгоор дэгсдүүлж ярьдаг юм бол байгаа. Тийм учраас өнөөдөр гишүүд.../минут дуусав./

Л.Энхнасан: Баярлалаа. Би нэг асуулт асууя. Ер нь ажилтны цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ нэмэгдэх эерэг үр дагавартай. Ажил олгогчдын хувьд шимтгэл төлөгчид нь нэмэгдэж байгаа. Энэ дээр дарамт ирэх эсэх талаар болон ийм нэмэгдэл ирэхээр байна гэсэн судалгаа байна уу?

Хоёрдугаарт, цагаар ажиллах талаар яам ямар бодлого баримталж байна? Ялангуяа малчдын гэрээт ажилтнаар оюутнууд маш их цагаар ажиллаж байна. Цаашдаа гэрээт ажилтан ажиллах, нэмэгдүүлэх дээр ямар нэгэн хөшүүрэг, олон улсад жишээ нь, Японд цагаар ажилладаг хүмүүс зарим татвараас чөлөөлөгдсөн байдаг. Энэ талаар сайд, яам, цаашилбал Засгийн газар ямар бодлоготой байна вэ?

Л.Энх-Амгалан: Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэх асуудлаар дангаараа яам шийддэггүй. 3 талынхаа хэлэлцээрээр шийддэг. Ажил олгогчдын холбоо, Худалдаа, аж үйлдвэрлэлийн танхимын төлөөллүүд орж, нэлээн тооцоо судалгаатай хандсан. Байнгын хорооны даргаас яг ямар хүмүүст тодорхой ачааллууд ирэх, тэр тусмаа ЖДҮ эрхлэгчид дээр ирэх ачааллуудыг тооцоолж үзсэн үү гэж байна.

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр сайн дураараа НДШ төлж байгаа 134,0 мянган хүн байгаа. Энэ дээр мэдээж 660,0 мянгаас НДШ төлж байсан бол 792,0 мянгаас төлнө. НДШ төлж байгаа 176,0 мянган иргэд бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр төлж байгаа. Түүнийгээ дагаад мэдээж тодорхой хэмжээгээр НДШ бас нэмэгдэнэ. Гэхдээ энэ нь эргээд ирээдүйд өөрийнх нь тэтгэвэр бас нэмэгдэх шууд үр дагавартай, өгөөжөө хүртдэг шимтгэл юм гэж хэлэхийг хүсэж байна.

Цаашдаа бид НДШ гэдгийг шимтгэл, хураамж, татвар гэж ойлгохоосоо илүү хуримтлалын нэг хэлбэр юм гэдгийг л ард иргэддээ сайн ойлгуулах шаардлага үүссэн гэж бодож байна. НДШ төлөгч 1,2 сая хүн байна. Үүнээс 25 хувь нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр нийгмийн даатгалын шимтгэлээ төлж байгаа хүмүүс, энэ дээр бага зэргийн ачаалал ирсэн гэдгийг үгүйсгэхгүй.

Л.Энхнасан: Цагийн ажилтны талаарх яамны бодлого?

Л.Энх-Амгалан: Ер нь цагаар тооцож ажлын хөлс олгох, цагаар ажиллуулах энэ тогтолцоо руу орох нь зүйтэй. Гэхдээ энэ чинь эерэг болон сөрөг талтай л юм байна лээ. Одоо цагийн ажил хийж байгаа хүмүүсийн хөдөлмөрийн гэрээний асуудал маш сул байдаг. Ямар нэгэн байдлаар цагийн ажил хийж байгаад үйлдвэрлэлийн аваар осолд орох, ажилгүйдэлд өртөх гэх мэтээр хөдөлмөрийн гэрээ хийгддэггүй, хөдөлмөрийн гэрээгээр бус хөдөлмөрийн хөлсний гэрээгээр зохицуулагдаж байгаа. Нийгмийн хамгааллууд нь сулрах ийм сөрөг үр дагавартай. Монгол Улсад гэхдээ арбат гэж ярьдаг цагийн буюу өдрийн ажлын брокер, биржүүд их бий болчихсон байна. Би хэд хэдэн удаа хувийн биржүүд дээр очиж ажилласан. Ингээд энэ цаашдаа бол.../минут дуусав./

Л.Энхнасан: Нэмэлт нэг минут өгье.

Л.Энх-Амгалан: Ямар ч байсан одоо Монгол Улсад цагийн ажил тэр тусмаа залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэл рүү цагийн ажлын зохицуулалтуудыг хийж өгөхөөс өөр арга байхгүй. Үүнийгээ дагаад нийгмийн хамгааллын асуудлуудыг нь мартаж болохгүй. Бид нийгмийн даатгалын шимтгэлийн, тэтгэврийн шинэчлэл дээр оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн том бодлого явуулах гэж байна. М.Ганхүлэг гишүүн, бид оюутан цагтаа НДШ төлөхгүй. Тогтмол ажлын байранд, тогтмол цалинтай болсон үеэс эхэлж гэрээ байгуулаад нийгмийн даатгалын шимтгэлээ төлөх гэх мэтээр оюутнуудыг ажил хөдөлмөртэй болгох, ахмадуудад бас ажил хөдөлмөр эрхлэх нэг боломж нь энэ цагийн ажил шүү дээ. Нэгэнт хөдөлмөрийн зах зээл дээр хомсдол бий болчихсон. Бидэнд байгаа өнөөдрийн нөөц бол оюутнууд, ахмадууд байна. Тийм учраас ахмадууд, оюутнуудыг цагаар ажиллах боломж, зохицуулалтуудыг хийж өгөхөөс өөр аргагүй байна.

Л.Энхнасан: Баярлалаа. Гишүүд асуулт асууж дууслаа. Одоо зөвхөн асуулт асуусан гишүүн үг хэлж, асуулт асуух учраас А.Ариунзаяа гишүүн үг хэлж, асуултаа асууна.

А.Ариунзаяа: Надад 5 минут байгаа тиймээ. Миний минутыг 5-аар нь өгөөрэй. Би асуулт асуухгүй, үг хэлье.

Хөдөлмөрийн хөлсний тухай хууль, тогтоомж хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ тогтоох тухай хууль байгаа. Энэ хуулийн зорилт нь хөдөлмөрийн гэрээ болон хөлсөөр ажиллах гэрээ, тэдгээртэй адилтгах бусад гэрээнд баримтлах цагийн үндсэн цалин хөлсний доод хэмжээг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулна гэж байгаа. Гэтэл цагийн харилцаа гэхээсээ илүүтэй бид нар сарын 792,0 мянган төгрөг гэдгээрээ л нэгдүгээрт яваад байна.

Хоёр дахь нь, зөвхөн цалин хөлстэй холбоотой асуудлыг зохицуулах ёстой байтал хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдсан маш олон бусад бодлогууд, эерэг давуу байдал үүсгэхээсээ илүүтэй сөрөг санхүүгийн ачаалал үүсгээд байна. Ийм учраас хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдуулсан бусад бүхий л бодлогуудаа больж, торгууль хүртэл хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй холбогдож “тооцох нэгж” гэж хууль зүйн салбарын торгуулиудыг тусад нь гаргасан. Үүнтэй нэгэн адилаар шимтгэл төлөлт болоод бусад төлбөрүүдийг тусад нь гаргах шаардлагатай байна. Тус хуулийн 5 дугаар зүйл буюу 5.4-т “Хөдөлмөр нийгмийн зөвшлийн 3 талт Үндэсний хороонд 2 жилд нэг удаа тогтоох бөгөөд...” гэсэн үндсэн хугацаа нь байгаа учраас 2 жилдээ нэг удаа тогтоох нь өөрөө тухайн ажилтны цалин гэхээсээ илүүтэй тухайн цалинг олгож байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудад бизнесээ тогтвортой хөгжүүлэх, эдийн засгийн хүртээмжээ жаахан нэмэгдүүлж байж эргээд цалингаа нэмэх энэ боломжийг нь өгөх тухай асуудал учраас бизнесүүдийг хамгаалах тал дээр нь анхаарсан ийм заалтыг 2010 онд тухайн үед Хөдөлмөрийн сайд Т.Ганди, Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж байсан, тухайн үед оруулсан энэ өөрчлөлт нь “2 жилд нэг удаа” байх гол агуулга нь бизнесүүдийг эрсдэлээс хамгаалах асуудал байсан юм. Хуулийн 7.2 дахь заалт бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй холбоотойгоор маш их төсвийн зохицуулалтууд, төрөөс дааж байгаа шимтгэлийн

асуудлууд болон олгогдож байгаа тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ нь уялдаатай байдаг учраас зайлшгүй төсвөөр үүнийг хэлэлцэн баталж, тухайн жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжүүлнэ гэсэн. Хэрэв тухайн жилийн төсөв батлагдсанаас хойш шинэчлэн тогтоосон бол дараагийн төсвийн жилээс эхлэн дагаж мөрдөнө л гэж заасан байгаа. Тэгэхээр яалт ч үгүй төсөв өргөн барьсан хойно энэ шийдвэр гарсан учраас хуулийн 7.2 дахь хэсгийг үндсэндээ зөрчсөн гэж миний хувьд үзэж байгаа. Ер нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хүмүүс юу гэж буруу ойлгоод байдаг вэ гэвэл хөдөлмөрийн бүтээмж л юм шиг дундаж цалинтай, ердийн цалинтай хольж хутгаж бодоод байдаг. Гэтэл өнөөдрийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ бол зөвхөн цалин хөлсний асуудал биш юм. Би хэдэн тоон мэдээлэл та бүхэнд хэлье.

Хэн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр цалинжиж байна гэхээр энд нэг ч төрийн албан хаагч байхгүй. Төр төрийн албан хаагчдынхаа цалинг нэмчихсэн. Хувийн хэвшлийн 90,0 орчим мянган хүн л хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс доош цалин хөлс авч байгаа гэж НДЕГ-ын тайлангийн мэдээн дээр байгаа юм. Тэгэхлээр сайн дурын НДШ бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй шууд уялдсан байдаг. Сарын 89100 төгрөг төлж байсан бол одоо 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 106920 төгрөг болж байгаа учраас хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ хөдөлснөөс шалтгаалсан сар бүрийн нэмэлт ачаалал нь 17820 болж байна. 170 орчим мянган хүнтэй. Малчдын асуудал байна. Ер нь бол 280,0 мянган малчин байгаа бол 51 хувь нь л НДШ сайн дураараа төлдөг. Малчдын 20 хүрэхгүй хувь нь нийгмийн даатгалын энэ харилцаанд орсон гэсэн үг. Тэгэхээр төрөөс 50 хувийг нь даагаад даагаад энэ хамрагдалт нь нэмэгдэхгүй байгаа. Ер нь маш их ачааллыг зөвхөн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэгдүүлсэнтэй холбоотойгоор, сарын төлөх хэмжээ нь 2022 онд нийгмийн даатгалын сайн дурын шимтгэл нь 56,0 мянга байсан бол 2023 онд 74,0 мянга, 2024 онд 89,0 мянга, 2025 онд 106,0 мянган төгрөг болж нэмэгдэж байна. Энэ бол нэмэлт санхүүгийн ачаалал учраас тухайн сар бүр хүн НДШ-ээ төлөх үү, үгүй юу. Ийм өндөр болох тусам төлөхгүй байх сэдэл нь улам нэмэгдэнэ. Нэн ялангуяа нийгмийн даатгалын нэр хүндийг олон талаас нь муулж ярьж байгаа энэ цаг үед маш их хүндрэлтэй гэсэн үг. ЭМД-ын шимтгэл сайн дураараа төлж байгаа гэнэ. Албан хөдөлмөр эрхлээд 700,0 мянган хүн шимтгэл төлж байгаа бол 2,4 сая иргэний төлбөрийг энэ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 2 хувиар төлдөг. Тэгэхээр энэ дээр ч гэсэн сарын нэмэлт ачаалал орж ирж байна. Яг одоо бол тухайн хамрагдалт.../минут дуусав/

Л.Энхнасан: Нэг минут нэмье.

А.Ариунзаяа: Нийгмийн даатгалын сайн дурын шимтгэл, ЭМД-ын шимтгэл дээр давхар ачаалал үүсэж байгаа. 2025 онд сарын 15840 төгрөг төлж байгаа. Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн 144.2, 144.3-т "...25-аас дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллагууд хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулах..." үүргийг хүлээдэг. Ажиллуулахгүй бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэх төлбөрийг төлөх ёстой. Одоогийн байдлаар 8 мянган аж ахуйн нэгж, байгууллага төлөх ёстойгоос 800 аж ахуйн нэгж, байгууллага төлж байна. Гадаадаас ажиллах хүч авч байгаа бол мөн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих

санд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэн дүнгээр төлбөр төвлөрүүлэх ёстой. Энэ ч гэсэн өнөөдөр давхар ачааллыг үүсгэж байгаа юм. Ийм учраас Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуулийг зайлшгүй өөрчилж, цагийн хөлсийг тогтоодог байх, бусад холбогдох нэмэлт ачааллуудыг салгах тал дээр ажиллахгүй бол болохгүй байна. СӨХ-ны төлбөр хүртэл нэмэгдсэн гэдэг гомдлыг иргэдээс ирүүлсэн. Баярлалаа.

Л.Энхнасан: Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяагаас Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад хандсан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний талаарх асуултын хариуг хэлэлцэж дууслаа.

Ажлын хэсэгт баярлалаа.

---oOo---

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ АСУУЛГА, АСУУЛТ,
ТҮҮНИЙ ХАРИУГ ХЭЛЭЛЦСЭН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**

№64

Эмхэтгэсэн: К.Пүрэвсүрэн
Хянасан: Д.Энхбат
Ч.Онончимэг
Эх бэлтгэсэн: Б.Төгсзаяа

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хяналт шалгалтын газраас эрхлэн гаргав.

Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэх, олшруулах цехэд бэлтгэв.